

Лиахона



Ахлагч Гонг болон ахлагч Соарэс–
“Бүх дэлхийд Христийн нэрний
тусгай гэрчүүд,” х. 12, 18

Бишопоо ойлгоход туслах 8 зүйл, х. 24

Иосеф Смитийн “Сионы үйл хэргийн
төлөө хийсэн сүнслэгээр өдөөгдсөн
алхам,” х. 28

Бидний Бурхантай байгуулсан гэрээний
тухай хожмын үеийн түүхүүд, х. 34

**“ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ ЭХ
МААНЬ БИДНИЙ ЭЦСИЙН АЗ
ЖАРГАЛ, ӨРГӨМЖЛӨЛИЙГ
ТӨЛӨВЛӨСӨН** гэдгийг мэдэх

нь бидэнд алсын хараатай
байж, тэнгэрлэг эцэг эхийн
хайртай хүүхдүүд гэсэн хэв
шинжийг өгөн, хүнд хэцүү
үед ч их эзэнд итгэх итгэлийг
маань өсгөн нэмэгдүүлдэг.”

АХЛАГЧ КВИНТИН Л.КҮК


“Их Эзэн хэрхэн нигүүлсэнгүй хандсаар ирсэн бэ?” 34-р хуудас.



34

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 6 Тохинууллын зарчмууд:
Бусдад туслахын тулд
тусламж авах нь**
*Тохинуулалдаа хэзээ, хэрхэн
бусдыг татан оролцуулахаа
хэрхэн мэдэж авах вэ?*



ХАВТСАН ДЭЭР

Харин өөрт байгаагаа л би чамд өгье,
Волтэр Рэйн.

- 12 Ахлагч Гэррит В.Гонг: Их
Эзэнийг хайрла, Түүнд найд**
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

- 18 Ахлагч Улиссэс Соарэс:
Заль мэхгүй нэгэн**
Ахлагч Нийл Л.Андэрсэн

- 24 Бишоп бүр тойргийнхоо
гишүүдийг юуг мэдээсэй
гэж хүсдэг вэ?**
Майкл Майэрс
*Заримдаа бид бишопууд дууд-
лагаа сайн хийхийн тулд чад-
лынхаа хэрээр зүтгэж байгаа
бидний л адил хүмүүс гэдгийг
мартдаг.*

- 28 Гэгээнтнүүд: Сүмийн түүх—
8-р бүлэг: Христийн Сүмийн
өсөлт**
*Мормоны Ном хэвлэгдэж
байх үед хэдэн хүн үнэн Сүмд
хөтлөгдөн ирсэн. Иосеф уг
номыг хэвлэгдэн гарсны дараа
Сүмийг зохион байгуулав.*

- 34 Их Эзэн хэрхэн нигүүлсэнгүй
хандсаар ирсэн бэ?**
Ахлагч Квинтин Л.Күк
*Гишүүд итгэлтэй хожмын
үеийн гэгээнтнүүдийн тухай
Сүмийн олон боть түүхийг
унхсанаар сүнслэгээр өдөөгдөх
болно.*

ӨГҮҮЛЛҮҮД

- 4 Итгэлийн хөрөг: Майкл
Исаак—Польш, Быдгощ**
- 10 Бид юунд итгэдэг вэ?:
Аравны нэгийн мөнгийг
юунд зарцуулдаг вэ?**
- 40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн
дуу хоолой**
- 80 Биднийг дахин уулзах хүртэл:
Бидний тууштай дэмжлэг**
Ерөнхийлөгч Жэймс Э.Фауст



48

- 44 Сайн мэдээний дагуу амьдрах бидний сэдэл**
Минди Сэлү
Бидний зөв шударга амьдрах учир шалтгаан нэг зүйл дээр тулгуурладаг.

- 48 Наманчлалд хөтлөх анхны алхам**
Аурилас Петерсон
Ихээхэн зүрх зориг гарган бишоп дээрээ очсоноор бүхнийг өөрчилсөн.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой.
Сэжүүр: Та гэрлээ хэрхэн гэрэлтүүлдэг вэ?



50

- 50 Их Эзэний арга замаар суралцах нь**
Ахлагч Дэвид А.Бэднар
Сүнснийг багшаа болгосноор бидний суралцах чадвар өсөн нэмэгдэнэ.

- 54 Ерөнхий чуулганаас суралцах 5 арга зам**
Ерөнхий чуулганы захиасаас илүү ихийг суралцахын тулд дараах санааг уншиж танилц.

- 56 Ариун Сүнсээр заалгасан нь**
Эдгээр өсвөр үеийнхэн Ерөнхий чуулганаас юу сурч мэдсэнээ хуваалцав.

- 58 Зурагт хуудас: Хэрэв та нар сонсох юм бол**

- 59 Ерөнхий чуулганы талаарх баримт**

- 60 Асуулт, хариулт**
Хүмүүс хэрэлдэж, маргаж байхад би гэр орондоо Сүнснийг хэрхэн урьж чадах вэ?

- 62 Ирээдүйд тань таныг бэлддэг зам**
Дөрвөн залуугийн дараах туршилага ирээдүйд хэрхэн амжилтад хүрэх талаар зааж өгнө.



72

- 66 Бурханы хайрыг дамжуулах нь**
Аллий Б.
Бид нүүж ирээд, салбарт цөөхөн хүн байгааг анзаарав. Тиймээс би ямар нэгэн арга хэмжээ авахаар шийдэв.

- 67 Хавцал дахь залбирал**
Карсэн К.
Бид машин руугаа эргэж очих замаа хэзээ ч олохгүй юм байна гэж би айж байлаа.

- 68 Гэрлээ гэрэлтүүл: Чех улсад тод гэрэлтсээр**

- 70 Төлөөлөгчид Христийн талаар гэрчилдэг**
Ахлагч Жэффри Р.Холланд

- 71 Бидний хуудас**

- 72 Итгэл, найдвар, ач ивээл— 3-р хэсэг: Голланд дахь итгэл найдвар**
Мэган Армнэкт

- 74 Мормоны Номын уншлагын клуб**

- 75 Хуучин Гэрээний баатрууд: Естер зоригтой нэгэн байв**

- 76 Судрын түүхүүд: Хатан хаан Естер**
Ким Вэбб Рэйд

- 79 Будах хуудас: Би бусдад хайрыг мэдрэхэд нь тусалж чадна**

**2018 ОНЫ АРАВДУГААР САР, 19, №5
ЛИАХОНА 14754 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Фүкс,
Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард,
Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар,
Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн,
Роналд А.Расбанд, Гари И.Стивенсон, Дэйл Г.Рэнланд,
Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Хюго И.Мартинэз

Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Бэки Кравэн

Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Бага Лигранд Р.Куртис,
Эдуард Дюб, Шэрон Юбанк, Кристина Б.Франко, Доналд
Л.Холлструм, Даглас Д.Холмс

Удирдах захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Фрэнсиска Олсон

Редакцийн баг: Мэрисса Дэниел, Дэвид Диксон, Дэвид
А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гэррэт
Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Рэйн Жэнсэн, Шарлотт
Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мардок, Салли Жонсон
Одэкэрк, Жошуа Ж.Пэкий, Жан Пинбороу, Ричард М.
Ромни, Минди Сэлү, Чакэлл Вордлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрюс, Фэй
П.Андрус, Мэндий Бэнгли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд,
Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан
Ловфгрэн, Скотт М.Моой, Эмили Чизко Рэммингтон, Марк
В.Робисон, Брэд Тизри, К.Никол Вокзорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэнн Адэйр, Жюли Бардэтт, Томас
Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрэк
Ричардсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэниел, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивен Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Бэркир

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт

liahona.lds.org pyu; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга,
украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад
(хялбаршуулсан), чех, швед, эстонч, япон хэлээр нийтлэгддэг.
(Хилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй
бол хувь хүмүүс Лиахона сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа
(мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал
хувиран авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй.

Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд
ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй.
Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар
хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St.,
FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон
шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

October 2018 Vol. 19 No. 5. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required
for change of address. Include address label from a recent issue;
old and new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Post Information: Publication Agreement #40017431)


POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).

NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.


Дэлгэрэнгүй мэдээллийг интернэтээс үзэж болно



Liahona.lds.org гэсэн хаягаар
өгүүлүүдийг уншиж мөн өөрийнхөө
түүхийг илгээнэ үү.



Сүнснэг өдөөлт бүхий бусадтай
хуваалцаж болох захиасуудыг
(англи, португаль, испани
хэлээр) **facebook.com/liahona**
хаягаар орж үзээрэй.



Санал хүсэлтээ **liahona@ldschurch.org**
хаягаар илгээнэ үү.



Store.lds.org-оор орж захиална уу.
Аль эсвэл хангамжийн төв дээрээ очин,
тойргийн удирдагчаасаа асууж лавлан,
1-800-537-5971 (Америкийн Нэгдсэн Улс
болон Канадад) дугаараар холбогдоно уу.

©GETTY IMAGES-ИЙН ШИГТЭЭ ЗУРАГ

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Ажил эрхлэлт, 62

Аравны нэг, 10

Ариун Сүнс, 50, 56, 60

Ариун сүмүүд, 42, 71

Бие даасан байдал, 40, 62

Бишопууд, 24, 48

Бошиглогчид, 42, 71, 80

Бэрхшээл, 4

Гэрчлэл, 56, 68, 71

Ерөнхий чуулган, 54, 56,
58, 59

Есүс Христ, 44, 70

Жишээ, 68

Залбирал, 4, 40, 41,

67, 68

Зориг, 75, 76

Илчлэлт, 41, 50

Иосеф Смит, 28, 34

Итгэл, 4, 40, 42, 44

Мормоны Ном, 28, 74

Наманчлал, 48

Номлолын ажил, 43, 66

Өршөөл, 48, 72

Суралцах, 50

Сүмийн түүх, 28, 34

Сүмийн удирдагчид,
12, 18

Тохинуулал, 6, 24

Тэнгэрлэг Эцэг, 34, 43

Хайр, 66, 79

Хуучин Гэрээ, 75, 76

Эв нэгдэл, 24, 43, 60





ИТГЭЛИЙН ХӨРӨГ

Бөөрний дутагдлаас болж шаналж буй Майкл “Өвчинд олон сайн тал бий” гэв. Өвчнийхөө улмаас сайн мэдээнд улам бүр талархах болсон тэрээр өвчнийг “сайн сорилт” хэмээн хэлсэн юм.

ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН

Майкл Исаак

Польш, Быдгощ

Эхэндээ би бухимдсан л даа.

“Яагаад би гэж?,” “Их Эзэн, би танд үйлчилж байсан шүү дээ” гэж би залбирсан. Хэсэг хугацааны дараа би яагаад гэдгийг ойлгосон. Судруудад “эдгэрэх итгэлтэй, мөн үхэлд оноогдоогүй тэр нь эдгэрэх болно” (С ба Г 42:48) гэсэн байдаг.

Сүмийн гишүүд миний төлөө залбирч байсан ч эрүүл мэнд маань дордсоор байв. Тэд залбирлыг нь сонсохгүй байна гэж бодож байсан ч илүү сайн хүмүүс болж мөн би тэдний хайрыг мэдэрч байсан учраас үнэндээ залбирлыг нь сонссон байсан юм.

Би эрүүл байлаа гэхэд одоогийн энэ насандаа дахин хэдэн жил ч наслах байсан юм билээ? Гэсэн ч надад хийх олон зүйл бий.

Надад Сүм бий. Мөн би залбирч, мацаг барин, хийж буй бүх зүйлээрээ дамжуулан Бурхантай холбогдох боломжтой. Надад өөр юу хэрэгтэй вэ?

Заримдаа би өөртөө “Би ямар агуу зүйлд оролцож байгаагаа мөн энэ нь ямар агуу үйл хэрэг гэдгийг ойлгохын тулд л өвдсөн юм байна” гэж хэлэх үе гардаг.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Амьдралын зовлон бэрхшээлийг хэрхэн итгэл найдварын хүчээр даван гарч болох талаар lds.org/go/10185 дээрх ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний үгээс илүү ихийг суралцана уу. Итгэлийн өөр хөргийг lds.org/go/18 вэбсайтаас үзнэ үү.

Тохинууллын зарчмууд

БУСДАД ТУСЛАХЫН ТУЛД ТУСЛАМЖ АВАХ НЬ

Тохинуулах хүчин чармайлтаг тусламж хэрэгтэй

үед бид бусдыг үүнд хэрхэн татан оролцуулж болох вэ?

Тохинууллын ярилцлагад болон эхний ням гаргийн зөвлөлийн хуралд оролц.

Хэд хэдэн судасны хатуурлын улмаас Кэйт тэргэнцэр дээр суух болсон бөгөөд түүнийг орой бүр тэргэнцрээс нь ор руу нь оруулахад тусламж хэрэгтэй болохыг тэр олж мэдэв. Энэ ажлыг нэг гишүүнд хариуцуулахад хэтэрхий хүнд байлаа. Тиймээс ахлагчдын чуулгынхан зөвлөлдөөд, түүнд орой бүр туслах хуваарь гаргав.¹

Бид үйлчилж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээ, чадавхыг мэдсэнээр тэдний хэрэгцээнд туслахын тулд юу хэрэгтэй болохыг олж мэдэх боломжтой. Тохинууллын ярилцлага болон эхний ням гаргийн зөвлөлийн хурал нь бусдыг хэрхэн зохих ёсоор татан оролцуулах ажлыг авч хэлэлцэх хоёр боломж юм.

Тохинууллын ярилцлага

Тохинуулагч эгч нар ба Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл тохинуулагч ах нар ба ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн хооронд хийгддэг улирал тутмын эдгээр ярилцлага нь бидний тохинуулдаг хүмүүстэй холбоотой гаргадаг цорын

ганц *албан ёсны* тайлан юм. Тохинууллын ярилцлага нь наад зах нь улиралд нэг удаа (1) хариуцсан гэр бүл, хувь хүмүүсийнхээ боломж чадавх, хэрэгцээ шаардлага, асуудлын талаар зөвлөлдөх, (2) ахлагчдын чуулга, Халамжийн нийгэмлэг эсвэл тойргийн зөвлөлийн зүгээс үзүүлж болох дэмжлэг тусалцааг тодорхойлох, (3) удирдагчдаас суралцаж, тохинуулалд урам дэм авах боломж юм.

Ахлагчдын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчид чухал хэрэгцээг бишоптойгоо шууд ярилцан, түүнээс зөвлөгөө, удирдамж авна.

Та тохинууллын ярилцлагын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ministering.lds.org-оос авна уу.

Тохинууллын ярилцлагыг утга учиртай болгох нь

Тохинууллын хөтөлбөр нь Сүмийн зүг чигийг чиглүүлдэг гол цэг болох талаар ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоний мэдэгдлийг дэмжин, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Гари И.Стивэнсон “Энэхүү алсын хараа хэрхэн хэрэгжих нь . . .

“Тохинууллын зарчмууд”
сэдэвтэй нийтлэлүүд нь бидэнд
айлчлан очихдоо хуваалцахад
биш, харин нэг нэгнээ хэрхэн
халамжилж сурахад туслах зорил-
готой. Үйлчилж байгаа хүмүүсээ
таньж мэдэх үед тэдэнд халамж
энэрлээс гадна ямар захиас
хэрэгтэй байгааг Ариун Сүнс
бидэнд шивнэн хэлэх болно.



ЕСҮС БУСДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛДАГ БАЙСАН

Есүс 5 талх, 2 жижигхэн загасаар 5000 хүнийг хооллосон.

Аврагч хэдэн удаа бусдыг энэхүү тохинууллын ажилд татан оролцуулсныг
олж тодорхойлохын тулд Иохан 6:5–14-ийг уншина уу.



тохинуулагч ах, эгч нарт тохинууллын ярилцлагаар хэрхэн зааж, мөн тэд хэрхэн оролцож байгаагаас шалтгаалж болно”² гэж заажээ.

Тохинуулагч ах, эгч нарт өгөх 4 зөвлөгөө:

- Зөвлөгөө эрэлхийлэн ярилцлагад ор. Суралцахад бэлэн бай.
- Өөрт тань хэрэг болох хэрэгцээг авч хэлэлцэхэд бэлэн бай.
- Хувь хүний хэрэгцээ шаардлагаас гадна давуу тал, ур чадвар дээр нь төвлөр.
- Шаардлагатай бол улирал тутмын ярилцлагын хооронд ерөнхийлөгчийн зөвлөлийнхөнтэй холбоо барь.

Удирдагчдад өгөх 5 зөвлөгөө:

- Ярилцлага урт байх шаардлагагүй ч утга учир бүхий ярилцлага өрнүүлэх боломжтой газарт уулзахад хангалттай цаг төлөвлөсөн байх ёстой.
- Тохинуулагч ах юм уу эгчид тохинуулах боломжийг ашигла.
- Та зөвхөн айлчлан очсон гэсэн тоо авах эсвэл холбоо барьсан эсэхийг шалгаж байна гэсэн сэтгэгдэл төрүүлэх асуултыг бүү тавь (“Та тохинуулаа хийсэн үү?”). Хүссэн үйл явцыг бататгах асуултуудыг тавь (“Тухайн гэр бүлийн төлөө залбирахад танд ямар мэдрэмж төрсөн бэ? Таныг эдгээр мэдрэмжийнхээ дагуу үйлдэхэд юу болсон бэ?”).

- Чин сэтгэлээсээ сонс мөн тэмдэглэж ав.
- Хамтдаа зөвлөлд. Тохинууллын хамтрагчид томилогдсон хүмүүсийнхээ төлөө илчлэлт хүлээн авах эрхтэй.³

Тохинууллын ярилцлагын талаарх асуулт хариулт

Тохинууллын ярилцлага гэж юу вэ?

Энэ нь тохинуулагч ах нар ба ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлд эсвэл тохинуулагч эгч нар ба Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хооронд Ариун Сүнснээс сүнслэг өдөөлт эрэлхийлж, хүлээн авах боломж олгох орчинд хийгддэг ярилцлага юм. Үүний үр дүнд тохинуулагч ах, эгч нар Аврагчийн арга замаар харж халамжлан, хайрлаж, зааж, тайтгаруулахад сүнслэгээр өдөөгдөх боломжтой.

Улирал тутмын эдгээр ярилцлагыг биечлэн уулзаж хийх хэрэгтэй юү?

Тэдгээрийг гол төлөв биечлэн уулзаж хийдэг ч нүүр тулан уулзах боломжгүй бол утсаар эсвэл онлайнгаар хийж болно. Ерөнхийдөө, хоёр хамтрагч тохиромжтой үед хоёулаа ярилцлагад оролцоно.

Тохинууллын ярилцлагын зорилго юу вэ?

Тохинууллын ярилцлага нь тохинуулдаг хувь хүн, гэр бүлийнхнийхээ одоогийн нөхцөл байдлыг дүгнэж, хэтийн төлөвлөгөө гаргаж, шаардлагатай тусламжийг үзүүлэх боломжийг тохинуулагч ах, эгч нарт олгодог. Энэ нь мөн ахлагчдын чуулга, Халамжийн нийгэмлэгийн зүгээс ямар тусламж үзүүлж болох тухай ярилцах боломжийг олгодог.

Би хувийн чанартай, нууц асуудалд хэрхэн хандах ёстой вэ?

Тохинуулагч ах, эгч нар хувийн мэдээллийг зөвхөн ахлагчдын чуулгын эсвэл Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчтэй эсвэл бишоптой шууд хуваалцана. Хувийн чанартай, нууц мэдээллийг эхний ням гаргийн зөвлөлийн хурлаар хуваалцаж болохгүй.

Та тохинууллын ярилцлагыг харуулсан сургалтын видео бичлэгүүдийг ministering.lds.org-оос үзнэ үү.

Бусдын хэрэгцээний талаар зөвлөлдөх нь тохинууллын ярилцлагын гол хэсэг билээ. Мөн 2018 оны 9-р сарын дугаар дахь “Тэдний хэрэгцээний талаар зөвлөлд” гэсэн тохинууллын зарчмуудын талаарх нийтлэлийг үзнэ үү.



Эхний ням гаргийн зөвлөлийн хурал

Тохинууллын ярилцлагаас гадна эхний ням гаргийн зөвлөлийн хурал нь бусдыг тохинуулалд татан оролцуулах өөр нэгэн арга зам юм. Халамжийн нийгэмлэг, ахлагчдын чуулгын хурлуудад Сүнсээр болон бүлгийн бусад хүнээр дамжуулан оролцож байгаа хүмүүст сүнс-лэг өдөөлт ирж болно.

Зөвлөлийн хурал дараах зорилготой. Үүнд:

- “Орон нутагтаа хүлээсэн үүрэг, боломж, бэрхшээлтэй асуудлуудаа хамт хэлэлцэх;
- Бие биенийхээ ойлголт, туршлагаас суралцах, мөн
- Сүнснээс хүлээн авсан мэдрэмжийнхээ дагуу үргэлж үлдэх.”⁴

Зөвлөлийн хурлууд нь яриа хэлцэл төдий зүйл биш юм. Тэдгээр нь биднийг хувь хүн болон бүлгийн хувьд Сүнсний өдөөлтийн дагуу үйлдэхэд хөтөлдөг. Гишүүд эдгээр хурлын үр дүнд Их Эзэний ажлыг хийж гүйцэтгэх хүсэлтэй байгаагаа мэдэрдэг.

Үйлдэх урилга

“Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Эрэгтэй, эмэгтэй хүн бүр мөн манай залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн томчууд нь нэг нэгнээ халамж-лахаар чин сэтгэлээсээ баттай шийдэж, Христийн цэвэр хайраар ийн үйлдэх урам аваасай хэмээн бид залбирч байна”⁵ гэж хэлсэн. ■

ЭШЛЭЛҮҮД

1. *Mormon Messages* video “Lift,” [lds.org/media-library](https://www.lds.org/media-library)-ийг үзнэ үү.
2. Gary E. Stevenson, in “Ministering Interviews” (video), [ministering.lds.org](https://www.ministering.lds.org).
3. Рассэл М Нэлсон, “Тохинуулах нь,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 125
4. *Come, Follow Me—For Melchizedek Priesthood and Relief Society*, in *Liahona*, Nov. 2017, 140; also available at comefollowme.lds.org.
5. Жэффри Р.Холланд, “Тэдэнтэй хамт байж, бэхжүүл,” *Ensign* эсвэл 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 126.

АРАВНЫ НЭГИЙН МӨНГИЙГ ЮУНД ЗАРЦУУЛДАГ ВЭ?

Таны аравны нэгийн өргөлийн мөнгийг юунд зарцуулдаг вэ?



Та орлого олоод,



орлогынхоо 10 хувийг аравны нэгийн өргөл болгон өгдөг
(С ба Г 119-ийг үзнэ үү).



Та аравны нэгийн өргөлөө бишопын болон салбарын
ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнд өгч эсвэл
donations.lds.org-оор онлайнаар төлж болно.



Сүмийн төв байран дахь Тэргүүн Зөвлөл, Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулга, Бишопын ерөнхийлөгчийн зөвлөл бол
Аравны нэгээр төлөгдсөн өмч хөрөнгийг хариуцсан хороо юм
(С ба Г 120-ийг үзнэ үү). Их Эзэний удирдамжаар тэд эдгээр
ариун нандин аравны нэгийн санг хэрхэн ашиглах талаар
сүнслэгээр өдөөгдсөн шийдвэрийг гаргадаг.

АРАВНЫ НЭГИЙГ ДАРААХ ЗҮЙЛД АШИГЛАЖ БОЛНО.



Ариун сүм, цуглааны байр
болон Сүмийн бусад барилга
байгууламжийг барьж,
арчлан хамгаалах



Сүмийн боловсролын
хөтөлбөрүүдийг явуулах



Судар болон бусад
материалыг хэвлэх



Гэр бүлийн түүхийн
судалгаа хийх



Халамж, хүмүүнлэгийн
тусламж үзүүлэх



Номлолын ажил хийх



Тойрог, салбарын гишүүдийн
хооронд нөхөрсөг дотно
харилцааг дэмжихэд
зориулсан Сүмийн үйл
ажиллагааг санхүүжүүлэх

ИЛҮҮ ИХИЙГ СУРАЛЦ

- Дэвид А.Бэднар,
“Тэнгэрийн цонх-
нууд,” 2013 оны
10-р сарын Ерөн-
хий чуулган, 19
- Малахи 3:7–18
- “Аравны нэг,”
Итгэлдээ үнэнч
байх нь (2004),
21–24



Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулга
**Ахлагч Д.Тодд
Кристоффэрсон**

АХЛАГЧ ГЭРРИТ В.ГОНГ: Их Эзэнийг хайрла, Түүнд найд

Гэрлээд удаагүй, Английн Оксфордын Их сургуулийн оюутан Гэррит В.Гонг хувийн туршлагаараа, бид Их Эзэнийг хайрлан, Түүнд найдах үед Тэр бидэнд тусалж, удирдан, хүчирхэгжүүлдэг гэдгийг мэдэж авчээ.

Гэррит нэг нь докторын зэрэг болох, бакалаврын дараах хоёр зэрэг горилохоор ажиллаж байсан бөгөөд Родын тэтгэлэгт оюутан байв. Тэр үед тэрээр Оксфордын тойргийн бишопын зөвлөлд бас үйлчилж байв. Тэрээр эхнэр Сюзаны хамт Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид Б.Хайтын (1906–2004) Солт Лэйкийн ариун сүмд гэрлэхэд нь өгч байсан зөвлөгөөг дурсан санах. Ахлагч Гонг “тэрээр биднийг үргэлж дуудлагатай байх ёстой гэж хэлсэн” гэж яриад, “Хэрэв бид Бурханд итгэн, чадлынхаа хэрээр хамгийн сайнаараа хийвэл Тэр бидэнд үргэлж тусалдаг гэдгийг бид мэддэг байсан” гэв.

Гэррит, Сюзан хоёр түүний хэлснээр “тэнгэрлэг тусламж, энэрэнгүй өршөөл”-ийг хүлээн авсан ажээ. Гэррит бишопын зөвлөлд үргэлжлүүлэн үйлчилж байхдаа диссертациаасаа гадна докторын зэрэгт шаардагдах бүхий л шаардлагыг гүйцээсэн. Тэрээр Оксфордын тойргийн бишоп Алан Вэбстэрээс санваарын адислал өгөхийг гүйв. Адислал өгч байх үед Гэррит “Хийж чадах бүхнээ үргэлжлүүлэн хий, Их Эзэн чамайг адислах болно” гэсэн амлалтыг хүлээн авсан байна.

Хуульчийн бичиг хэргийн туршлагатай тойргийн хоёр гишүүн нь гар бичмэлийг нь сайн дураараа шивж өгөхөөр болж, Гэррит хэдхэн сарын дотор диссертациа дуусгах боломжтой болов. Чухамдаа, ердөө гурван жил

гаруйн хугацаанд тэрээр магистр, докторын зэргээ хоёуланг хамгаалж чаджээ. Төгсөх үедээ тэр тэнхмийн судалгааны ажил хүлээн авав. Оксфордод суралцсан туршлага нь Их Эзэнд найдах итгэлийг нь, өнөө хүртэл тэвчиж ирсэн найдварыг нь хүчирхэгжүүлсэн бөгөөд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байгаа үед нь ч Гэррит В.Гонгийг үргэлжлүүлэн адислах болно.

Талх ба загас

Ахлагч Гонг “Их Эзэн нинжин сэтгэлтэй, өгөөмөр бөгөөд биднийг адислахаар эрэлхийлж байдаг. Хэрэв бид чадах бүхнээ хийвэл Тэрээр биднийг хийж чадах байснаасаа ч илүүт хийх боломжтой болгох болно. Энэ бол талх, загас үржсэнтэй адил зүйл. Их Эзэн бидний хийж чадсаныг аваад, өөрсдийнхөө хэр хэмжээнд хийж чадахаас маань хавьгүй том болгон өсгөн томруулдаг.”





“Оксфордоод байхдаа Сюзан бид хоёр тойрогтоо үйлчилсэн туршлагаа эрдэм номоо дээдлэн үздэгийн адил эрхэмлэн үздэг байсан. Өнөөдрийг хүртэл нөхөрлөсөн хамгийн дотно ихэнх найз маань Оксфордын тойргийн хүмүүс.

Тэдний дундаас Тим, Катэрин Витт хоёр Гонгийнхонтой ариун сүм рүү явахаа мартдаггүй байсан юм. “Тонг ах мөнхийн утга учиртай зүйлсийн талаар бясалган бодож байх үедээ цаг хугацаагаар хязгаарлагдахгүйн тулд бугуйн цагаа тайлдаг байсныг би сайн санаж байна. Тэрхүү жижиг үйлдэл нь ариун сүмийн шүтлэг бишрэлийнхээ тал дээр илүү хичээнгүй байхад минь надад тусалсан юм” гэж Витт эгч хэлэв.

Гонгийнхон сайн мэдээгээр дамжуулан таньж мэддэг болсон

найз нөхөдтэйгөө үе үе уулздаг. “Хүмүүс ‘Бид таныг дээд зөвлөлд байхад хамт ажиллаж байсан гэх мэт зүйл хэлнэ. Бид ч бас мөн адил тэгж хэлнэ’ гэж ахлагч Гонг хэлээд, ‘Намайг залуухан бишоп байхад минь тусалсан гадасны ерөнхийлөгч, тойргийн зөвлөлдөө би талархаж байна. Бид бүгдээрээ биднийг Христ рүү ирэхэд хөтөлдөг, урамшуулан дэмждэг, бидэнд сайхан сэтгэлээр ханддаг эцэг эх, хадам, хөрш, номлолын ерөнхийлөгч, эгч нар болон санваарын удирдагчдаа өртэй” гэв.

Гэр бүлийн өв

Ахлагч Гонгийн гэр бүлийн 34 үеийн түүх МЭ 837 онд төрсөн Анхны Луу Гонгоос

Талх, загасны зарчим нь суралцах дээр ч бас хэрэгждэг үнэн зарчим юм. “Суралцахуй бол мөнхийн зүйл учраас албан боловсрол олж авах боломжгүй үед ч суралцахуйн сүнс ач холбогдолтой хэвээр байдаг. Бид өөрсдийн нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрэл ба үнэнийг эрэлхийлж чадна. Биднийг хийх үед Их Эзэн үүнийг олоход маань туслах болно” гэж хэлэв.

Гэрээнд харьяалагдах нь

Оксфордоод байхдаа ахлагч Гонг сайн мэдээний бас нэг өөр зарчимд буюу түүний хэлснээр “гэрээнд харьяалагдах” зарчимд суралцжээ.

Тэрээр “Бид Их Эзэн рүү илүү ойртох үедээ нэг нэгэндээ илүү ойртдог” гэж хэлэв.

Ахлагч Гонг өөрийнхөө эцэг эх Жийн, Волтэр, эхнэр Сюзан нартайгаа аз жаргалаа холбож ойлгодог. Эцэг эхийнх нь гэр “Бурханы хүүхэд болгоноо гэх хайрыг бишрэн хүндэтгэх сүсэг бишрэлээр дүүрэн байсан” гэж тэрээр хэлсэн юм. Ахлагч Гонг эхнэртэйгээ анх танилцах үед түүнд Сюзан нь аль хэдийн сайн таньдаг хүн шиг нь санагдаж байжээ.

улбаатай. Ахлагч Гонгийн эмээ, өвөө хоёр нь Хятадаас Нэгдсэн Улс руу цагаачилжээ. Түүний ээж Жийн АНУ-ын Хавайд өсвөр насандаа Сүмд нэгдсэн юм. Дараа нь тэрээр АНУ-ын Юта муж дахь Провогийн Бригам Янгийн Их Сургуульд элсэн орсон бөгөөд тэнд Дүрслэх урлагийн коллежийн анхны декан Гэррит дэ Жонгийн гэрт байрладаг байжээ. “Дэ Жонгийнхон надад сайн мэдээний гэр бүл гэж ямар байдаг талаар ойлгоход минь тусалсан” гэж тэр хэлсэн.

Жийн БЯИС төгссөнийхөө дараа АНУ-ын Калифорнийн Пало Алто дахь Станфордын Их сургуульд орсон бөгөөд тэнд Волтэр А.Гонгтой танилцжээ. “Тэр аль хэдийн Христэд итгэгч байсан бөгөөд сэргээгдсэн сайн мэдээний санал болгодог зүйлүүдийг маш хурдан ойлгож авсан” гэж тэр хэлэв. Волтэр Гонг Сүмд нэгдээд, жилийн дараа тэд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэжээ. Тэд хоёулаа мэргэжлийн сурган хүмүүжүүлэгчид болсон бөгөөд нийтдээ дал гаруй жилийг багшилж сургахад зориулжээ.

“Аав маань бас патриарх болсон бөгөөд манай гэрт өгсөн патриархын адислалууд гэрийг маань хүүхэд болгоноо хайрладаг Бурханы хайрыг бишрэх гүн гүнзгий бишрэл хүндэтгэлээр дүүргэсэн юм” гэж ахлагч Гонг ярив.

1953 оны 12-р сарын 23-нд Жийн, Волтэр хоёрын гурван хүүхдийн ууган нь мэндэлжээ. “Түүний нэрийг Гэррит гэсэн нь Гэррит дэ Жонгийн дурсгалд зориулан нэрлэсэн голланд нэр бөгөөд дундах нэрийг Волтэр гэсэн нь аавыг нь дурсан өгсөн нэр юм. Манай овгийн нэр хятад бөгөөд энэ нь түүний өвийг дурсан хэрэг билээ” гэж Жийн тайлбарлав.

Жийн “Гэррит өөрийн хоёр дүү Брайн, Маргурит нараа анхаарч, асран халамжилдаг байсан. Тэр дүү нартаа туслах дуртай, бүр гутлаа үдэх гэх мэт аар саар зүйлд нь ч тусалдаг байсан” гэж хэлэв. Тэрээр нэг удаа Сүмээс ирснийхээ дараа, Гэррит, Брайн хоёрыг ариун ёслол дээр хэлдэг үг уйтгартай гэж хоорондоо ярьж байхыг нь сонссоноо дурсдаг. “Тэгээд би тэдэнд тэгвэл та нар илүү сайн үг бэлдээд ир гэж уриалсан юм. Тэд ч

Зүүн гар талаас: Маржори, Гордон Б.Хинкли нар Гонгийнхны хуримын хүлээн авалт дээр Гэррит, Сюзан хоёртой хамт байгаа нь. Тайваньд номлогч байхдаа ахлагч Гонг нэгэн гэр бүлд сайн мэдээ заасан бөгөөд олон жилийн дараа ерөнхий эрх мэдэлтнээр үйлчилж байхдаа тэр гэр бүлийн охидын нэгнийх нь зээ хүүтэй уулзсан байна. Вьетнамд ахлагч Гонг, Сюзан Гонг эгч хоёр бэрхшээл сорилттой тулгарсан хүүхдүүдэд баяр баясгалан авчрах арга зам болгож, ханын зураг зурж өгч байгаа нь. Гонгийн гэр бүлийн гишүүд Вьетнамд ханын зураг зурахад тусалсан хүмүүсийн хамт.

уриалгыг хүлээн авч, бүх үгэнд илүү анхаарал хандуулж эхэлсэн” гэж тэр ярив.

Өсвөр насандаа Гэррит тойргийнхоо залуу эрэгтэйчүүдтэй үүргэвчтэй аялал, явган аялал хийх дуртай байжээ. Насан туршийнх нь найз Волли Солбэкэ нэг кэмпиин аяллынхаа талаар онцгойлон дурсдаг. “Би Гэррит, түүний дүү Брайн, бас манай Сүмийн гишүүн бус нэг найзтайгаа дөрвүүлээ байлаа. Нэг мэдсэн чинь бид сүмийн дуулал дуулж гарлаа. Гэррит аяыг нь, Брайн тенор, би басс хоолойгоор дуулж байв. Бид бараг 10, 20 дуулал дуулсан даа. Зүгээр л бидэнд дуулах нь их хөгжилтэй байсан юм. Маш сайхан байсан



шүү. Сүмийн гишүүн бус найзын маань сэтгэл их догдолсон.”

Солбэкэ ах, ахлах сургуульд байхад нь Гэррит хөгжөөн дэмжигчдийн ахлагчдаас шатрын багаа чимээгүй дэмжиж өгөхийг гүйж байсныг нь санадаг аж. “Тэр

сэтгэл санааны дэмжлэг хүн бүхэнд хэрэгтэй гэж тэднийг ятгаснаар тэд тэмцээн дээр ирсэн байсан” гэж тэрээр ярив.

Ахлах сургууль төгссөнийхөө дараа ахлагч Гонг Бригам Янгийн Их Сургуульд элсэн оржээ. 1973–1975 оны хооронд тэрээр Тайвань Тайпей номлолд үйлчилсэн бөгөөд буцаж БЯИС-д ирээд, Ази судлал, их сургууль судлалаар бакалаврын зэрэгтэй болжээ.

Үерхэл ба гэрлэлт

Ахлагч Гонг номлолоос буусныхаа дараа Провогийн Номлогчийг бэлтгэх төвд ням

гаргийн орой болдог галын дэргэдэх цугларалтуудад сайн дураараа үйлчлэл хийдэг болжээ. Цуглаан нь Тайванийг зорьж байсан номлогчдыг тэндхийн хүмүүс, ёс заншил, соёлтой танилцахад тус болж байв. Номлогчдын нэг болох Сюзан Линдсэй эгч Ютагийн Тэйлорсвиллээс ирсэн бөгөөд Ричард П болон Мариан Б.Линдсэй нарын охин байв. Линдсэй ах Далын хоёрдугаар чуулгын гишүүн байжээ. Ахлагч Гонг “Сюзан надад үргэлж таньдаг хүн шиг минь санагддаг байсан” гэж хэлэв.

Хоёр жилийн дараа Сюзан номлолоо дуусгаад, хэдэн сарын дараа БЯИС-д буцаж ирэхэд Гонг гэрийнхэнтэйгээ Провод байжээ. Аав нь их сургуульд багшилж байсан бөгөөд Гэррит хоёр долоо хоногийн хугацаатайгаар зочлох төлөвлөгөөтэй байжээ. Сюзан тэр хоёр өдөр бүр болзоонд явдаг байснаас болж айлчлал нь дөрвөн долоо хоногоор сунгагдав. Тэгээд Гэррит Оксфорд руу буцахаасаа өмнө Хавайд дадлага хийхээр явав.

“Бид бөмбөрцгийн хоёр өөр газраас болзоо хийдэг байв. Би Англид суралцахынхаа хажуугаар Атлантын далайн цаана байсан түүний тухай бүх зүйлийг мэдэхийг хүсдэг байлаа” гэж ахлагч Гонг дурсав.



Гонг эгч “Бид утсаар ярьж, сүй тавьсан. Талархлын баяраар тэр гэртээ эргэн ирж, шинэ онд нээгдсэн ариун сүмийн анхны өдөр бид хоёр гэрлэсэн юм” гэж яриу. Хоёр долоо хоногийн дараа тэд хамтдаа шинэ амьдралаа эхлүүлэхээр Англи руу нисжээ.

“Хүмүүс гэрлэх үедээ хоёр гэр бүл нэг болох тухай ярьдаг. Яг ийм зүйл надад тохиолдсон. Би Гонгийн гэр бүлийн хэсэг гэдгээ мэдэрдэг шиг бас Линдсэйгийн гэр бүлийн хэсэг гэдгээ мэдэрсэн юм” гэж ахлагч Гонг яриу.

Онцгой ажил мэргэжил

Тэрээр Оксфордоод хэсэг хугацаанд байсныхаа дараа АНУ-ын Вашингтон Ди Си-д засгийн газрын үйлчилгээний албанд ажиллах болжээ. 1984 онд тэрээр Рейган-Буш нарын дахин сонгуулийн компанит ажлын бүрэлдэхүүнд ажилласан бөгөөд тэнд тэр хожим нь Ютагийн амбан захирагч болсон Майк Лийвиттэй нэг өрөөнд ажиллаж байжээ. “Гэррит ажигч, ухаантай хүн байсан хэдий ч тууштай сайхан сэтгэлтэй хүн гэдгээрээ ялгардаг байсан” гэж Лийвитт ах хэлэв.

1985 онд Гэррит Төрийн Департаментийн нарийн бичгийн тусгай туслахаар ажиллаж байв. 1987 онд тэрбээр АНУ-аас Хятадын Бээжин хотод суугаа элчин сайдын тусгай туслах болсон юм. 1989–2001 оны хооронд тэрээр Вашингтон Ди Си дэх Стратеги, олон улс судлалын төвийн хэд хэдэн албыг хашжээ. Түүнийхээ дараа тэрээр БЯИС-ийн стратеги төлөвлөлтийн ерөнхийлөгчийн туслахын албан тушаалыг хүлээн авсан бөгөөд энэ албанд найман жил ажилласан.

БЯИС-ийн харилцаа холбооны ерөнхийлөгчийн туслах Карри Жэнкинс зэргэлдээх өрөөнд нь суудаг байв. Тэр эмэгтэй Гэррит Гонгийн эргэн тойрондоо байгаа хүмүүсийг урамшуулан дэмжих ур чадварынх нь талаар дурсан ярихдаа “Хэрэв танд хэцүү даалгавар хийнэ гэсэн итгэл байхгүй бол таны өмнөөс түүнд тэрхүү итгэл байдаг байлаа. Тэр зөвлөх, найдвар өгөх, урагш зүтгэх, өөрийгөө батлан харуулахад тань туслах



бүх зүйлийг хийдэг байсан” гэж ярьсан юм.

Ахлагч Гонгийг Вашингтонд болон БЯИС-д байхаас нь мэддэг Холбооны шүүгч Томас Б.Гриффит түүнтэй харилцаж байсан харьцаагаа дурсан ярихдаа, “Ярианы төгсгөлд бүх анхаарал тан дээр байсан байна гэдгийг та ухаарна. Тэр бол сайн сонсогч. Тэр танд юм бодуулах асуулт тавина” гэж түүнийг тодорхойлов.

Чөлөөндөө гарсан, Далын ерөнхий эрх мэдэлтэн, БЯИС-ийн ерөнхийлөгч асан Сэсил О.Самуэлсон ахлагч Гонг бол “ерөнхийдөө чимээгүй, гэхдээ дугуй нь үргэлж эргэж байдаг хүн” хэмээн хэлжээ.

Гэр бүлийн амьдрал

Гэррит, Сюзан хоёр Абрахам, Сэмүэл, Кристофер, Матай гэсэн дөрвөн хүүхдийн эцэг эх болсон бөгөөд хүүхдүүд нь бүгд өөр өөр нөхцөлд өсөн торнижээ.

“Биднийг Бээжинд байхад хүүхдүүд маань нэг нэгнийхээ хамгийн сайн найз нь байхаар адислагдсан байв” гэж ахлагч Гонг ярив.

“Нэг талаар, тэд дэлхийг харах өнцгөө өргөжүүлэх боломжтой байсан. Нөгөө талаар, энэ нь биднийг хоорондоо нягт гэр бүл байхад маань тусалсан юм. Хөвгүүд маань, бидний эцэг эх болохынхоо хувьд тэдэнд хийсэн хамгийн сайн зүйл бол тэдэнд эрэгтэй дүү өгсөн явдал гэж одоо ч гэсэн хэлдэг.”

“Нэг удаа бид олон удаагийн нислэгээс авсан хөнгөлөлт эдлэх эрхээ ашиглах болсон юм” гэж ахлагч Гонг ярив. “Бид хүн бүрд өөр өөрсдийнхөө чиглэлийг сонгох боломжийг олгосон. Бид амьдарч байсан Вашингтон Ди Си-ээсээ аяллаа эхлүүлж, Англи, Чех, Грек, Турк, Энэтхэг, Хятад, Япон руу явахаар болсон.

Бид энэ аяллын туршид нэг журмыг хатуу баримтална гэж тохиролцсон байлаа” гэж Сюзан эгч ярив. “Бид явсан газар болгондоо тухайн нутгийн хүмүүсийн иддэг хоолыг идэж байв.” Аяллын эцсийн цэг болох Японд ахлагч Гонг хөвгүүдээ үхрийн махаараа дэлхийд хамгийн алдартай ресторана руу авч явна гэж хэлэв.

Мақдоналдст дөрвөн өлссөн хүү эцэг эх хоёртойгоо 17 гамбургэр идэж билээ!” гэж Сюзан эгч ярив.

“Аав, ээж хоёр туршлагаас суралцахад өндөр ач холбогдол өгдөг. Аав маань туршлага хүмүүсийг болон бүхэл бүтэн соёлыг хэрхэн төлөвшүүлдэг талаар их боддог” гэж Абрахам хэлэв. Мөн Абрахам аавынхаа талаар “тэр санаагаа гүйцэд ойлгуулахын тулд маш тодорхой ярьдаг бас хэлсэн болгондоо бүрэн итгэдэг” гэж онцолсон.

Сэм “аав Төрийн Департаментэд завгүй ажилладаг байхдаа ч миний оролцохыг их хүсэж байсан ‘Чэллэнж 24’ гэдэг гуравдугаар ангийн математикийн тэмцээнд бэлтгэхэд орой бүр надад зааж, давтуулдаг байсан. Тэрээр намайг тэмцээнд түрүүлбэл 24 давхаргатай мөхөөлдөстэй үдэшлэг хийнэ гэж хэлж билээ” гэв. Сэм үндэсний шигшээд орох хүртлээ хичээсэн боловч түрүүлээгүй юм. Гэсэн ч Гонгийнхон мөхөөлдөстэй үдэшлэг хийжээ. 24 давхаргатай байлгана гэдэг нь хэцүү байсан ч дунд нь нэгийг борцтой хийсэн байжээ.

Кристофер, Матай хоёр “эцэг эхийнхээ хуваалцдаг найдвар, хайр, чин сэтгэлээ зориулдаг чанарт нь” хэчнээн их талархалтай байдаг тухай ярив. Энэ бол ахлагч Гонг, Гонг эгч хоёрын нэгэн нэгэнтэйгээ, мөн хөвгүүдийнхээ болон гэр бүлийнхээ хүн нэг бүртэй хуваалцдаг хайр юм.

Сюзан эгч хэлэхдээ “Тэррит бол бүхий л зүрх сэтгэлээ зориулсан сайн аав төдийгүй хүү бас ах юм шүү. Тэрхүү үүргүүд нь түүний хувьд маш чухал байдаг. Тэрээр гэр



бүлийн харилцаа нь бусад бүх зүйлээс чухал гэдгийг ойлгоход бидэнд тусалдаг” гэжээ.

Сүмийн туршлага

Хэдийгээр ажил болон гэртээ завгүй байдаг ч ахлагч Гонг Сүмд дээд зөвлөх, дээд пристийн бүлгийн удирдагч, гадасны ням гаргийн ангийн ерөнхийлөгч, семинарын багш, бишоп, гадасны номлолын ерөнхийлөгч, Бүсийн дал зэрэг дуудагуудад хүсэл зоригтойгоор үргэлжлүүлэн үйлчилж ирсэн.

Тэр дуудагдсан газраа ч мөн гэр бүлийнхээ амьдралд ч тодорхой зан чанарыг байнга харуулдаг. “Тэрээр хүн бүрийг Тэнгэрлэг Эцэгийн хүү, охин гэж үздэг. “Тэр гэхдээ бүхнээс илүү Бурханыг хайрладаг. Тэнгэрлэг Эцэгийн хаант улсыг байгуулахыг, Түүний



Зүүн гар талаас:
Тайландад ахлагч Гонг католик сүмийн дээд албан тушаал бүхий санваартан Франсис Хавиэр, Бангкок хотын тэргүүн бишоп Кардинал Криэнгсак Ковитаванижтай уулзаж байгаа нь. Ахлагч Гонг хүү Сэмийнхээ хамт Канадад аялсныхаа адилаар хүү болгонтойгоо ганцаарчилсан аялал хийх дуртай. Ахлагч Гонг Амьдралын талхны тухай бодлоо 2017 онд институт, семинарын багш нартай хуваалцсан нь. Гонг эгч Камбожийн нэгэн гишүүний гэрт мэндчилж байгаа нь.

хүүхдүүдийг адислахын төлөө бүх зүрх сэтгэлээ зориулахыг тэр үнэхээр хүсдэг” гэж Гонг эгч хэлсэн юм.

Тэрээр эхнэрээ хүндэтгэн биширдэг. “Надад юут ч хий гэж даалгасан бай, Сюзан надтай хамт байдаг. Сюзан бүх хүнтэй амархан харьцчихдаг ба бусад хүнтэй эв зүйгээ олчихдог. Түүний шинэ газарт очих, шинэ зүйл хийж үзэхдээ үргэлж дуртай байдагт нь би талархдаг” гэж тэр хэлсэн юм.

Далд үйлчилсэн үйлчлэл

Ахлагч Гэррит В.Гонг 2010 оны 4-р сарын 3-нд Далын ерөнхий эрх мэдэлтнээр

дэмжигдэн батлагдсан. Түүнд Хонгконгт удирдах газар нь байрладаг Азийн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчлэх томилолт өгчээ. Дараа нь тэрээр Азийн бүсийн ерөнхийлөгч болов. 2015 оны 10-р сарын 6-нд ахлагч Гонг Далын ерөнхийлөгчөөр томилогдсон бөгөөд тэндээ Африк, Төв Америк зэрэг дэлхийн янз бүрийн улс орнуудад бүс хариуцах зэргээр олон улсын талаарх туршлага нь үргэлжилсэн.

Тэрээр “Эдгээр газарт та гэгээнтнүүдтэй уулзаад, тэднийг хайрлах болно. Хүмүүс танд, Бурхан тэдний амьдралд хэрхэн оролцогийг, Бурхан гэж хэн болох, мөн Тэр бидний хүн нэг бүрийг хэр их хайрлагдгийг мэдэж авсан ойлголтынх нь салшгүй хэсэг болсон учраас итгэлийнхээ тухай ярихад нь та адислагдсанаа мэдэрдэг” гэж хэлсэн юм.

“Бид ямар ч нөхцөл байдал руу ахлагч Гонгийг томилсон бай, түүнтэй холбогдсон хэн боловч анд найзтай болсон гэдгээ мэдэрдэг. Тэр өндөр түвшний мэдлэгтэй ч даруу хүн. Тэр бүх түвшний хүмүүстэй харьцдаг бөгөөд үргэлж сайн бэлтгэлтэй байж, хүмүүсийг итгүүлж чаддаг” гэж ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон яриw.

Төлөөлөгчөөр дуудагдав

Ахлагч Гонг Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчлэх дуудлага хүлээн авах үеийнхээ талаар: “Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон хайрт хонгор Сюзаны минь хажууд миний гарыг зөөлхөн гэгч атган, намайг Их Эзэний энэхүү ариун нандин дуудлагад дуудахад би мэгдэн гайхсан” (Их Эзэн Христ энэ өдөр амилсан,” *Ensign* эсвэл 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 121) хэмээн хэлжээ. Бүрэн дарууссан боловч Их Эзэнийг хайрлах хайр, Түүнд итгэх итгэл найдварынхаа хувьд бат бөх ахлагч Гонг энэхүү дуудлагыг хүлээн авсан юм. Түүнийг 2018 оны 3-р сарын 31-нд дэмжин баталсан. Тэрээр “Бүх дэлхийд Христийн нэрний тусгай [гэрч]” (С ба Г 107:23) байхаар Их Эзэнээр сайтар бэлтгэгдсэн нэгэн билээ. ■



Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулга

Ахлагч Нийл
Л.Андэрсэн

АХЛАГЧ УЛИССЭС СОАРЭС: Заль мэхгүй НЭГЭН

Есүс тохинууллынхаа эхэн үед төлөөлөгчдөө сонгож байсан бөгөөд Өөрийг нь чиглэн ирж явсан Натанаелыг олж харжээ. Есүс тэр даруй Натанаелын сайн хүн болохыг мэдээд, “заль мэхгүй, жинхэнэ Израиль хүнийг харагтун”¹ гэж айлдав.

Есүс Натанаелын цэвэр ариун зүрх сэтгэлтэй, санаа зорилгодоо үнэнч шударга, хоёр нүүргүй, хуурамч зангүй гэдгийг мэддэг байв. Их Эзэн зөв шударга ийм зан чанарт дуртай бөгөөд Натанаелыг төлөөлөгчөөр дуудав.²

Улиссэс Соарэс бол эртний Натанаелын адил нэгэн бөгөөд Аврагч түүнийг бас дууджээ.

“Эцэг эхийн маань гэрэл”

Дөрвөн хүүгийн бага нь болох Улиссэс 1958 оны 10-р сарын 2-нд Бразилийн Сан Паулод төржээ. Тэрээр даруу амьдралд төрж өссөн хэдий ч эцэг эх Аппарэсидо, Мэрсэдэс Карэчо Соарэс нар нь зөв шударга, хөдөлмөрч, номлогчдыг хүндлэн сонсдог хүмүүс байжээ. Тэд 1965 онд, Улиссэсийг 6 настай байхад Сүмд нэгджээ.

“Би Аппарэсидо ахыг цуглаан тасалж байхыг хэзээ ч хараагүй бөгөөд тэрээр Улиссэсийг залуу эрэгтэй байхад гадасны ерөнхийлөгчөөр үйлчилж байсан” гэж Осирис Кабрал хэлэв. “Мэрсэдэс бас их итгэлтэй нэгэн байсан. Улиссэс эцэг эхийнхээ чин сэтгэлтэй занг өвлөн авсан юм” гэж Осирис Кабрал хэлэв.

Улиссэсийн төрөлхийн сайхан сэтгэл Их Эзэний арга замуудаас суралцаж байхад нь улам бүр цэцэглэв. “Би эцэг эхийнхээ гэрлийг дагаж, Сүмд өссөн” гэж ахлагч Улиссэс хэлэв. Түүнийг тэрхүү гэрлийг дагаж явахад эсэргүүцэл байсан ч гэрчлэл нь улам ихээр өсжээ.

“Би сургуульдаа цорын ганц Сүмийн гишүүн байсан бөгөөд бусад хөвгүүд үргэлж намайг доош нь татаж, буруу зүйлсийг хийлгэхэд түлхдэг байв” гэж тэр ярих. “Ийм асуудал бэрхшээлийн дунд хэрхэн өөрийгөө хамгаалахад суралцах хэрэгтэй байсан ч би Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ намайг амжилттай байхад минь тусална гэж үргэлж найддаг байсан. Хэрэв би өөрийнхөө хийх ёстой зүйлийг хийх л юм бол Их Эзэн мөн Өөрийнхөө хийх ёстой зүйлийг хийх болно гэдгийг би бүр залуу эрэгтэй байхдаа ухаарсан юм. Гэвч та Түүний гараас болон Түүний сайн мэдээнээс чанга зууран атгах хэрэгтэй” гэж тэр хэлэв.

Улиссэсийг 15 настай байхад бишоп нь түүнээс өсвөр үеийнхний Ням гаргийн ангид хичээл заахыг хүсжээ.





Улиссэс өсөж том болохдоо, хэрвээ түүнээс хүсэн хүлээж байгаа зүйлийг эсвэл гуйснаас илүүг хийвэл Их Эзэн түүнийг өгөөмрөөр адислах болно гэдгийг ойлгож авчээ. Яг ийм сургамж болсон зүйл түүнийг номлолд гарахаар бэлдэх үед тохиолджээ. Улиссэстэй хийсэн ярилцлагынхаа үеэр бишоп нь зарлигуудыг дуулгавартай дагах, зөв зохистой амьдрахын ач холбогдлыг онцлон хэлсэн байна. Тэр бас санхүүгийн хувьд бэлтгэлтэй байх нь чухал болохыг ярьжээ.

Өнөөдөр Бразилийн бүх номлогч номлолын зардалдаа хувь нэмэр оруулдаг бөгөөд олон гэр бүл зардлуудад нь хувь нэмэр оруулдаг болсон. Улиссэс номлолд гарах насанд хүрэхдээ, номлол хийхэд шаардлагатай бүх мөнгөө өөрийнхөө хөдөлмөрөөр олох болно гэж шийджээ. Хатуу чанга ёс зүй шаардагддаг аавынхаа жижиг бизнест олж авсан, хурдан бичиж шивэх чадвараар зэвсэглэсэн тэрээр нэгэн компанийн цалингийн тооцоо бэлтгэх өдрийн ажил олжээ.

Элсэлтийн хүнд хэцүү шалгалт өгснийхөө дараа тэр техникийн ахлах сургуулийн нягтлан бодохын ангид оройгоор суралцаж эхлэв. Тэр сар бүр аравны нэгийн өргөлөө өгснийхөө дараа номлолдоо зориулан мөнгө хадгалдаг байв. Нэг жилийн дараа тэрээр компанийнхаа нягтлан бодох бүртгэлийн хэлтэс рүү шилжин томилогдсон байна.

“Би ингэж л номлолынхоо мөнгийг хадгалсан юм. Би явахаасаа өмнө гурван жилийн турш сар болгон өөрт хэрэгтэй цамц, өмд,

Түүний заасан нэг хичээл нь сайн мэдээний гэрчлэл олж авахад төвлөрсөн байлаа. Улиссэс Мормоны Номыг судалсан байсан бөгөөд Сүм үнэн гэдгийг мэдэрч, Аврагч Есүс Христэд итгэдэг байв.

Тэр хичээлдээ бэлтгэж байх үедээ сайн мэдээний үнэний талаар ангийнхандаа хүчтэйгээр гэрчлэхийг хүсдэг байжээ. “Би судалж, чин сэтгэлээсээ залбирдаг байсан” гэж ахлагч Соарэс дурсаж байна. “Намайг өвдөг сөгдөн суусны дараа зүрх сэтгэлд минь маш зөөлөн, намуухан дуу хоолой ирж, намайг зөв зам дээрээ байгаа гэдгийг баталсан юм. Тэр бол маш хүчтэй мэдрэмж байсан тул би мэдэхгүй гэж хэзээ ч хэлж чадахааргүй байсан.”

Улиссэс Соарэс эцэг эх Аппарэсидо, Мэрсэдэс Соарэс нарынхаа “гэрлийг дагаж, Сүмд өссөн” (Зүүн гар талд).

Улиссэс ямар ч эсэргүүцэл тохиолдож байсан Их Эзэнд найддаг байсан учраас Аврагчаас, мөн Түүний сайн мэдээнээс чанга зууран барих хэрэгтэй гэдгийг хүүхэд байхаасаа ойлгожээ.

оймс, зангиа, чемодан зэрэг юмс худалдан авч байсан” гэж ахлагч Улиссэс хэлэв. Түүнчлэн тэр эцэг эх, орон нутгийн удирдагчдаасаа маш их хайр болон дэмжлэгийг хүлээн авч байжээ.

Улиссэс нь Бразил Рио дэ Жанейро номлолд дуудагдав. Тэрээр хожим Бразилээс дуудагдсан ерөнхий эрх мэдэлтэн, ерөнхийлөгч Хэлио да Роча Камаргогийн удирдлаган доор номлолынхоо эхний хэсгийг гүйцэтгэжээ. Улиссэс 1978 оны эхээр номлолоо эхэлсэн. Тэр оны сүүлээр Латин Америкт анхны ариун сүмийг ерөнхийлөгч Спенсэр В.Кимбалл (1895–1985) онцгойлон адислав.

1980 оны 1-р сард Улиссэс хишгээ мөн адил хүртээгүй байсан хамтрагчийнхаа хамт Рио де Жанейрод Бразилийн Сан Пауло ариун сүм рүү найман цаг явж хүрэх автобусанд суужээ. Улиссэсийн эцэг эх болон ах нар түүнийг угтан авч, Соарэсын гэр бүлийнхэн ариун сүмд энэ амьдралдаа болон үүрд мөнхөд лацдан холбуулсан юм. Улиссэс Сан Пауло ариун сүмд өнгөрөөсөн таван цагаа хэзээ ч мартдаггүй. Тэр өдөртөө тэрээр хамтрагчийнхаа хамт номлолын талбар руугаа буцжээ.

Бурханыг бүхний түрүүнд тавих

Улиссэс номлолдоо маш их дуртай байсан нь гэрчлэлийг нь хүчирхэгжүүлжээ. Тэрээр гэртээ буцаж ирснийхээ дараа ажил олж хийн, орон нутгийнхаа их сургуульд санхүү бүртгэл, эдийн засгийн чиглэлээр суралцаж эхлэв.

Гэртээ ирээд, долоон сар болсны дараа тэрээр гадас хоорондын бүжгийн үйл ажиллагааны үеэр “Моргадо эгч”-гэй санамсаргүй тааралдав. Улиссэс хэсэг хугацаанд түүний бүсийн удирдагч байсан бөгөөд тэд үдшийг сүүлийн үеийн мэдээнээс эхлүүлэн номлолын түүхээ ярилцаж өнгөрүүлжээ. Гурван долоо хоногийн дараа тэд болзож эхлэв.

Розана Фернандэс Моргадог эгч Маргарэт нь Сүм рүү авч явж эхлэх үед тэр найман настай байжээ. Яваандаа итгэлтэй, хоёр залуу сонирхогч эцгээсээ баптисм хүртэх зөвшөөрөл авсан ч тэд түүнийг 17 нас

Ахлагч Соарэс эхнэр Розанадаа “амьдралынхаа хамаг сайн сайхан зүйлсийн төлөө” талархдаг. Тэд Бразил Рио дэ Жанейро номлолоос бууснаасаа хойш хоёр жилийн дараа, 1982 онд гэрлэв (баруун цаад талд).



Ахлагч Соарэс эхнэр Розанатайгаа 2000 онд (дээд талд), гэр бүлийнхэнтэйгээ (баруун доод талд), 1979 онд бүрэн цагийн номлогч байхдаа (зүүн дээд талд), шинэ гишүүн Элийзэ Вагнэр дэ Суза ба түүний сүйт бүсгүй (одоо эхнэр нь болсон) Рэжинагийн хамт. Сантос ах одоо Эспирито Санто муж дахь Бразил Вила Вилха гадасны ерөнхийлөгчөөр үйлчилж байна. Ахлагч Соарэсын хамтрагч байсан Ким Пиккэтт ар талд нь зогсож байна.

хүртэл хүлээх хэрэгтэй болжээ. Розана баптисм хүртэх зөвшөөрөл автлаа есөн жил Сүмд явжээ.

Улиссэс хойд Сан Паулод, харин Розана хотын өмнөд хэсэгт эцэг эхтэйгээ амьдардаг байв. Тархсан хотоор автобус, метрогоор явахад гурван цаг болдог байв. Азаар, Маргарэт нөхөр Клаудиотойгоо эцэг эхийнхээ гэрийн ойролцоо амьдардаг байжээ.

“Улиссэс Розанатай уулзахаар амралтын өдрөөр ирээд, гэр рүүгээ шөнө буцахад хэцүү байдаг байсан” гэж ирээдүйн хүргэнийхээ тухай Далын ерөнхий эрх мэдэлтэн Клаудио Р.М.Коста эргэн дурссан юм. Тиймээс, Маргарэт тэр хоёр Улиссэсийг болзооных нь дараа гэртээ хоноход урьдаг байв.



“Бид түүнийг түр зуур үрчилж авсан юм” гэж ахлагч Коста нэмж хэлэв.

“Тэр манай зочны өрөөний буйдан дээр унтдаг байсан” гэж Коста эгч хэлээд, “Бид гэрлээд удаагүй байсан учраас бидэнд илүү хөнжил байдаггүй байв. Гэхдээ тэр манай нэг хуучин хөшгийг нөмрөөд унтдаг байсан. Тэр дараа өдөр нь дахин Розанатай уулздаг байсан тул аз жаргалтай байдаг байсан. Тэр манай охин дүүд сайн ханддаг байсан болохоор аав, ээж хоёрт маань тэр маш их таалагддаг байв” гэж ярилаа.

Улиссэс, Розана хоёр Бразилийн Сан Пауло ариун сүмд 1982 оны 10-р сарын 30-нд гэрлэжээ.

Хэрэв та ахлагч Соарэс, Соарэс эгч хоёртой хэдэн минут хамт байвал тэдний бие биенээ гэсэн хайр, бишрэл, хүндэтгэл илт харагдах

болно. Ахлагч Соарэсын хувьд Розана эгч “сайн сайхан, хайр, миний болон гэр бүлийнхээ төлөө Их Эзэнд бүхнээ зориулах чин сэтгэлийн жишээ болдог.”³ Соарэс эгчийн хувьд Улиссэс “тэнгэрээс ирсэн бэлэг” нь ажээ.

Соарэс эгч “Тэрээр үргэлж туйлын хариуцлагатай, зөв шударга байдаг бөгөөд гэр бүлээ маш сайн анхаарч халамжилдаг, надтай байнга маш сайхан ханддаг нэгэн. Тэрээр Сүмийн бүх дуудлагадаа хамгийн сайнаараа үйлчилж ирсэн. Тэр явж шууд л хийдэг. Тэр үргэлж Бурханыг амьдралынхаа бүх зүйлээс тэргүүнд тавьдаг. Тэр Бурханыг бүх зүйлийнхээ тэргүүнд тавьдаг бол намайг ч гэсэн бас бүх зүйлийн өмнө тавина гэдгийг мэддэг учраас би түүнд ахин дахин дурладаг” гэж тэр нэмж хэлсэн юм.

Ахлагч Соарэс эхнэрийнхээ тухай “Тэр манай гэрийн жинхэнэ баатар, урам дэм нь юм. Тэр хүмүүсийг хайрладаг, сайхан сэтгэлтэй, хүн болгонд тэвчээртэй

ханддаг. Тэр манай гэр бүлийг нэгтгэн, хүн болгоны сайн талыг олж хардаг. Тэр миний амьдралд тохиолдсон бүх зүйлд агуу их нөлөө үзүүлсэн хүн. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад дуудагдсан дуудлагынхаа талаар би түүнд хошигнон “амьдралд минь сайн мэдээний хүч ийм их нөлөөлсний төлөө би чамайг буруутгамаар байна” гэж билээ.

Сайхан сэтгэл

Соарэсын ууган хүү Густаво эцэг эхийнхээ үгэнд оролгүй, зөвшөөрөл ч авалгүй Сан Пауло хотод жил бүр болдог Фэста Жунина хэмээн нэрлэгддэг тэмдэглэлт үйл явдалд оролцохоор явжээ.

“Намайг цугласан олны дунд сайхан зугаацаж байтал нэрийг минь хөтлөгч дуудан, олны өмнө гарч ирэхийг зарлав. Тэгэхэд би аавыгаа олж харсан” гэж тэр уг шөнийн талаар дурсан ярих.

Эцэг эхийнх нь санаа маш их зовсон байсан ч Улиссэс Густавог загнахын оронд чанга тэврэн авчээ.

“Бид миний алга болсон талаар их нухацтай ярилцсан боловч эцэг эх маань надад хүндэтгэлтэй хандсан. Намайг хамгаалдаг гэдгийг би мэдэрсэн бөгөөд тэд надад үнэхээр их хайртай юм байна гэдгийг мэдсэн” гэж Густаво ярих.

Улиссэс гэр бүлдээ бүхнээ зориулдаг. Олон жилийн туршид завгүй ажилтай, ийш тийш аялдаг байсан ч тэр хүүхдүүдтэйгээ харилцах харилцаагаа бэхжүүлэхэд үргэлж цаг зав гаргадаг байсан.

Ахлагч Улиссэсийг 2018 оны 3-р сарын 31-нд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад дэмжин батлагдахад хамгийн их цочирдон гайхсан хүмүүс нь Густаво болон түүний хоёр эмэгтэй дүү Лэтисиа Каравалло, Наталиа Соарэс нар байв. Хэрэв хайр, шаргуу хөдөлмөр, энэрэнгүй сэтгэл, даруу зан бүхий хүн төлөөлөгчид тохирдог гэдгийг тэд мэддэг байсан бол Их Эзэн яагаад аавыг нь дуудсан болохыг ойлгох байсан.

“Есүс төлөөлөгчдөө дуудахдаа хамгийн их мэдлэгтэй фарисайчуудыг биш, загасчдыг дуудсан байдаг” гэж Лэтисиа ярих. “Манай аав, ээж хоёр үүнтэй адил. Тэд Их Эзэнд бүрэн итгэдэг бөгөөд Тэрээр тэднийг амиа боддоггүй, шаргуу хөдөлмөрлөх хүсэлтэй, ямар ч засаж залруулах зүйлийг хүлээн зөвшөөрдөг даруухан хүмүүс гэдгийг мэддэг учраас Өөрийн ажлыг гүйцэлдүүлэхийн тулд тэднийг ашигладаг.

Аавынх нь “сайхан сэтгэл” Аврагчийн онцгой гэрчүүдийн нэг болох хүний хувьд урагш тэмүүлэхэд нь туслах болно” гэж Наталиа хэлсэн юм. “Тэрээр үүнийг хийх зүрх сэтгэлтэй хүн. Тэр тэнгэрээс ирэх нөлөөг мэдэрдэг





бөгөөд хүн болгоныг хайрлан, зөв гэсэн юуг ч болов хийхийг хүсдэг” гэж тэр нэмж хэлэв.

“Гарцгүй зүйл гэж байхгүй”

Ахлагч Соарэс 2000–2003 оны үед Португаль Порто номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа “Tudo vai dar certo” буюу гарцгүй зүйл гэж байхгүй гэсэн португаль хэлц үгийг ашиглагдаараа алдаршжээ.

“Тэрээр үүнийг бидэнд заасан юм” хэмээн номлогчдынх нь нэг Ту Бэннэтт дурсан ярив. “Тэр итгэлээр мөн Их Эзэний биднээр хийлгэхийг хүсдэг зүйлийг хийвэл гарцгүй зүйл гэж байхгүй гэсэн өөдрөг үзлээр амьдардаг.”

Тэр мөн номлогчдодоо *хүнд хэцүү* эсвэл *боломжгүй* гэсэн үг ашиглахгүй байхыг заадаг байсан гэж өөр нэгэн номлогч Ричард Шийлдс хэлээд, “Бид юмсыг ‘саад бэрхшээл’ гэж хардаг байсан. Тэрхүү зөвлөгөө надад, юмсыг ‘хүнд хэцүү’ эсвэл ‘боломжгүй’ гэж харахаасаа илүү даван туулж болох саад бэрхшээл гэж хардаг болж, амьдралаа босгоход тусалсан юм” гэв.

Ийм их итгэл, өөдрөг үзэл амар хялбар амьдралаас урган гараагүй. Ахлагч Соарэс, Соарэс эгч хоёр юу ч үгүй байхаас авхуулаад урам хутарах, олон цагаар ажиллаж, суралцсанаас ядарч туйлдах, өвчин шаналлыг тэсэж тэсвэрлэх, хүүхэд нь зулбах, эцэг эх, ах эгч дүүсээ алдах зэрэгт зүрх сэтгэл нь шаналах ямар байдлыг сайн мэддэг.

Гэхдээ амьдралынхаа аяны туршид тэд ахлагч Соарэсын дуртай “Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно”⁴ гэсэн судрын эшлэлд итгэлтэй тавьжээ.

Ахлагч Соарэс “саад бэрхшээл бол бидний өсөж хөгжихийн нэг хэсэг юм. Гэхдээ зовлон шаналалд тэвчээртэй байж, амьдралын саад бэрхшээлийг даван туулахад суралцах, итгэлтэй хэвээр үлдэх үед маань Их Эзэн дээд

зэргээр анхаардаг бөгөөд амласан адислалаараа биднийг адисалдаг” гэж хэлсэн юм.

“Биднийг төмөр бариулаас чанга зууран барих үед Их Эзэн биднийг ганцаардуулахгүй” гэж тэр нэмж хэлэв.

Зарлиг, сайн мэдээ, судар, Их Эзэн Есүс Христээс байнга чанга зууран барих нь бидэнд амьдралынхаа саад бэрхшээлийг даван туулахад тусалдаг. “Биднийг өвдөг сөгдөн залбирах үед Тэрээр бидэнтэй хамт байж, биднийг удирдан хөтөлдөг. Тэр бидний явах зүг чиг, хийх зүйлсэд маань сүнслэг нөлөө үзүүлдэг. Биднийг өөрсдөө дуулгавартай, даруу байхад Их Эзэн залбирлуудад маань хариулдаг” гэж ахлагч Соарэс гэрчлэв.

Зүрх сэтгэлээ зориулсан шавь

Улиссэс Соарэс ур чадвартай, бэлтгэгдсэн хүн. Түүний боловсрол, тэр дундаа бизнесийн удирдлагын магистрийн зэрэг нь түүнийг Бразил дахь олон үндэстний корпорацид нягтлан бодогч, аудиторoor ажилаахад бэлтгэсэн юм. Тэрхүү туршлага нь түүнийг Сүмийн санхүүгийн албанд ажилаахад бэлтгэсэн бөгөөд энэ нь түүнийг 31 настайдаа Сүмийн ажлын албаны хамгийн залуу захирлуудын нэг болоход бэлтгэжээ. Ингэж бэлтгэгдсэн нь түүнд номлолын ерөнхийлөгчөөр мөн 2005 оны 10-р сарын 2-нд Далын ерөнхий эрх мэдэлтнээр үйлчлэхэд сайнаар нөлөөлсөн.

Ахлагч Соарэс 2013 оны 1-р сарын 6-нд Далын ерөнхийлөгчөөр дуудагдахаасаа өмнө Бразилийн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд болон Африкийн зүүн өмнөд бүсэд зөвлөхөөр тус тус үйлчилжээ. Тэндээ тэрээр ахлагч Дэйл Г.Рэнландын зөвлөхөөр, дараа нь Далын ерөнхий эрх мэдэлтнээр үйлчилсэн. Одоо Арван хоёр Төлөөлөгчийн



Чуулгын гишүүн, ахлагч Дэйл Г.Рэнланд түүнтэй хамт байсан тэр үеийг сайхнаар дурсдаг.

“Ахлагч Соарэс бол сэргэлэн цовоо, амласандаа хүрдэг, Есүс Христийн үнэнч шавь мөн” гэж ахлагч Рэнланд хэлээд, “Их Эзэний даалгаврыг биелүүлэхдээ түүн шиг асар их хичээл зүтгэл гаргадаг өөр хүнийг би мэдэхгүй. Хэрэв түүгээр ямар нэгэн юм хийлгэхийг хүсвэл тэр бүх л зүрх сэтгэлээрээ хийдэг” гэв.

Ахлагч Соарэс Африкийн гэгээнтнүүдэд дорхноо “дурласан” гэж тэр хэлсэн юм. Тус бүсэд түүнд хүлээлгэсэн үүргүүдийн нэг нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын Канангад нэгэн гадасны чуулганыг тэргүүлэх

Перугийн гэгээнтнүүдийн хамт (зүүн талд), Гана (доор), бусад улс оронд хаана ч үйлчилж, тохиуулсан ахлагч Соарэс “хүмүүст амархан хайртай болдог” гэж ахлагч Клаудио Р.М.Коста хэлсэн байдаг.



явдал байлаа. “Тэрээр буцаж ирээд, уулзсан хүмүүсийнхээ сайн сайхан, зүрх сэтгэлээ зориулдаг чанарынх нь талаар зогсолтгүй ярьдаг байсан” гэж ахлагч Рэнланд ярих.

Ахлагч Соарэстай Далын ерөнхийлөгчийн зөвлөлд таван жил хагас үйлчилсэн ахлагч Л.Витнэй Клэйтон түүнийг зөвшилцөл байгуулагч хэмээн нэрлэдэг ажээ. “Тэрээр сайн сонсож, эргэцүүлэн дүгнэдэг. Тэрээр хурал цуглаануудыг удирдахдаа бидний дуу хоолой өрсөлдөгч гоцлол дуучных шиг биш, харин найрал дууг бүрдүүлнэ гэдэгт тун хянамгай хандаж ирсэн.

Ахлагч Соарэс португаль, англи, испани, франц хэлээр харилцах чадварынхаа

Олон жилийн туршид ажлын болон аяллын завгүй хуваарийн дагуу амьдарч ирсэн хэдий ч ахлагч Соарэс эхнэр, хүүхдүүд болон ач зээ нараа (зүүн дээд талд) үргэлж амьдралынхаа тэргүүнд тавьсаар иржээ. Тэрээр мөн эхнэрийнхээ хамт чадварлаг тогооч болохын тулд цаг гаргадаг байсан (зүүн цаад талд).

тухайд тун даруу байдаг. Гэхдээ тэрхүү байнгын анхаарал татдаг авьяас чадвар нь Сүмд адислал болдог” хэмээн ахлагч Клэйтон хэлэв. Ахлагч Соарэс Сүмийн гишүүдийн ихэнхтэй өөрсдийнх нь хэлээр ярьж чадна.

“Улиссэс хүүхэд байхаасаа л удирдагч байсан” гэдгийг түүний хүргэн ах, ахлагч Клаудио Коста ажигласан байна. “Тэр маш ухаантай, чадварлаг, хамгийн сайн сайхнаа зориулах тал дээр маш хариуцлагатай ханддаг. Тэр эргэн тойрныхоо хүмүүсийг шууд л хайрладаг. Түүнд Аврагчийн жинхэнэ шавийн зүрх сэтгэл, Есүс бол Христ гэдэг баттай гэрчлэл бий. Би түүнд хайртай бөгөөд түүнийг Их Эзэний төлөөлөгчөөр дэмжин баталж байгаадаа талархалтай байна” гэж тэр хэлэв.


Мөн Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын хэлснээр: “Ахлагч Соарэс бол цэвэр ариун, заль мэхгүй нэгэн бөгөөд Аврагчийн гэм зэмгүй шавь юм. Түүний гэрэл, дулаахан инээмсэглэл, өгөөмөр зангаар дамжуулан маш олон хувь хүн, гэр бүлд Аврагчийг дагах, Түүний сайн мэдээний дэг жаягаар амьдрах агуу хүсэлтэй болоход нөлөөлж байсан, нөлөөлж ч байна, нөлөөлөх ч болно.”

Энэ эрин үед Их Эзэн Эдвард Партрижид “түүний зүрх сэтгэл миний өмнө цэвэр ариун байгаагийнх билээ, учир нь дотроо заль мэхгүй эртний Натанаелтай тэрээр адил болой”⁵ гэж хэлсэн байдаг. Их Эзэн Хайрум Смитийн талаар “учир нь зүрх сэтгэлийнх нь үнэнч шударгын учир мөн миний өмнө зөв болох зүйлийг тэрээр хайрладгийн учир Их Эзэн бибээр түүнийг хайрладаг билээ”⁶ хэмээн хэлсэн.

Улиссэс Соарэсын тухайд ч гэсэн Их Эзэн ингэж л хэлэх байсан. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Иохан 1:47
2. James E. Talmage, *Jesus the Christ* (1916), 217–218, 222-ыг үзнэ үү.
3. “Бошиглогчид Ариун Сүнсний хүчээр ярьдаг,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 123.
4. Сургаал ба Гэрээ 112:10
5. Сургаал ба Гэрээ 41:11
6. Сургаал ба Гэрээ 124:15



Бишоп бүр

тойргийнхоо гишүүдийг
юуг мэдээсэй гэж хүсдэг вэ?

*Би бишопоор үйлчилж байх
хугацаандаа суралцсан
8 үнэнээ энд дурдъя.*

Майкл Майэрс

Надад бишопоор үйлчлэх гайхалтай сайхан боломж тохиосон юм. Үйлчилж байх үедээ би хэмжээлшгүй их зүйлийг сурсан. Гэхдээ би нийтлэг гэж үзсэн 8 зүйлд суралцсан. Хэдийгээр энэ жагсаалтад бүгдийг оруулаагүй ч энэ нь бишоп бүрийн тойргийнхоо гишүүн бүрээс мэдээсэй гэж хүсдэг зүйлийг хуваалцах гэсэн миний оролдлого юм.

1. Бишоп нь тойргийнхоо гишүүн бүрийг жинхэнэ ёсоор хайрладаг.


Бишопын өөрийн тойргийг хайрлах хайр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын бидний хүн нэг бүрийг гэх хайртай холбоотой. Бишопыг ариун ёслолын цуглаан дээр гишүүдээ харах үед түүнд урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй бусдыг энэрэн хайрлах, зовлонг нь ойлгох чадвар өгөгддөг. Бишопыг босож зогсон, тойргийн гишүүдээ хэчнээн хайртайгаа хуваалцах үед түүний үгс чин сэтгэлийн угаас, үнэн бодит байдаг юм. Бишоп тань таныг хайрлаж, санаа тавьж, төсөөлж байгаагаас тань хавьгүй ихээр анхаарал халамж тавьдаг гэдгийг мэдэж ав.



2. Бишоп гишүүдийнхээ итгэл, залбирлын ачаар бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлын хувьд дэмжлэг туслалцаа авдаг.

Бишоп тоолж баршгүй олон цагийг үйлчлэхэд зориулдаг. Тэр ням гарагт Сүм дээр байнга олон цагийг өнгөрүүлэн, ажлын өдрүүдэд ажлын дараах цаг заваа тойргийнхоо гишүүдийг эргэж тойрох, ярилцлага хийх, асарч халамжлахад зарцуулдаг.

Тойргийнхоо гишүүдийн итгэл, залбирлын ачаар бишоп энэ бүхнийг долоо хоног бүр хийж чаддаг. Шинэ бишопор дуудагдсаны дараа гишүүдийг “бишопыг адислаарай” гэж залбирах бүрд миний нүднээс өөрийн эрхгүй нулимс гардаг байсан. Та нарын итгэлийн залбирал үнэхээр хариулагддаг бөгөөд залбирлын тань дэмжлэг туслалцааг бишоп хүлээн авч, мэдэрдэг. Их Эзэн итгэлээр дүүрэн тэдгээр залбирлын тань хариут Сүмийн бишопт өгдөг юм.



3. Бишоп ихэнхдээ уг дуудлагад өөрийгөө тэнцэхгүй гэж боддог (гурав, дөрвөн жил өнгөрсөн ч гэлээ).

Дуудлагадаа үнэхээр “бэлтгэгдсэн” гэж бодож байсан маш цөөхөн бишопыг би мэднэ.

Гэхдээ “Их Эзэн дуудсан нэгнээ тэнцэхээр болгодог”¹ гэдгийг би бас мэднэ.

Бишоп тэнцэхүйц болж байгаагаа мэддэг ч дуудлагаа хэзээ ч сайн хийж чадахгүй юм байна гэсэн бодол түүнээс салдаггүй. Тэрээр хэрэгтэй үед ухаалаг зөвлөгөө өгөх, хүмүүсийг гомдоохгүй, Сүнстэй холбоотой байх гэж чадлынхаа хэрээр хичээдэг ч заримдаа дуудлагаа хангалттай сайн хийж чадаж байгаа эсэхдээ эргэлздэг.

4. Бишопыг тойргийнхоо гишүүдэд зөвлөгөө өгч байхад Бурханы Сүнс түүгээр дамжуулан ажилладаг.

Бишопоор үйлчилж байх үеийн юуг хамгийн их санагалздаг вэ? гэж надаас асуухад би бишопын нөмрөгийг дагалдан ирдэг Сүнсний хүчтэй нөлөөг санагалздаг гэдгээ хүмүүст хэлдэг. Хайртай хүнээ алдсан нэгнийг тайтгаруулан, үнэнч бус эхнэр, нөхөртэйн улмаас зовж байгаа хүмүүстэй ярилцаж эсвэл наманчлахад урьж байхад итгэлтэй бишоптой хамт байдаг Сүнс бол Бурханы буюу илчлэлтийн Сүнс юм.

Саяхан өмнөх тойргийн маань нэг гишүүн надаас хувийнхаа асуудалд туслахыг хүссэн. Тэр шинэ тойрог руу нүүсэн ба шинэ бишопоосоо зөвлөгөө авах эсэхээ сайн мэдэхгүй байв. Би туслахдаа баяртай байсан ч бишопын атгадаг түлхүүрийг атгахаа больсон бөгөөд тэдгээр түлхүүр хэрэгтэй тусламж дэмжлэгийг нь өгөхөд нэн чухал үүрэг гүйцэтгэж болно гэж дуудлагаасаа бууснаас хойш олон удаа хэлсэн үгээ түүнд давтан хэлэв. Би түүнд бишоптойгоо ярихыг санал болголоо. Түүнтэй хоёр долоо хоногийн дараа уулзахад тэр бишоптойгоо уулзаж, тэр түүний асуудал юу болохыг мөн хэрхэн сайн туслахыг аль хэдийн мэдэж байсан мэт санагдсанаа хэлж билээ. Хэдийгээр бишоп алдаа гаргадаг ч Их Эзэн түүнд сүнслэгээр нөлөөлж, удирдан залж, хэлэх үгээр нь дамжуулан хүмүүсийн амьдралыг адисалдаг.



5. Бишоп ч гэсэн хүн учраас заримдаа алдаа гаргаж мөн зарим үед буруу зүйл хийдэг.

Эцсийн эцэст тэр эгэл хүн шүү дээ. Тэдэнд дутагдал, сул тал, өрөөсгөл үзэл мөн хувийн асуудал бий. Сүнс бишопын албанд дуудагдсан хүнийг тохирохоор болгодог ч бишоп хүн учраас түүнд ч гэсэн бидэнд тулгардаг бүхий л асуудал тулгардаг төдийгүй сул дорой талууд ч байдаг.

Үүнийг ухааран ойлгох нь түүний дуудлагад үзүүлдэг хүндлэл эсвэл зөвлөгөөг нь сонсохдоо тавьдаг биднийг анхаарлыг багасгах ёсгүй. Бишоп өөрийн сул талуудыг мэддэг ба тэдгээрийг ялан дийлэхэд юм уу ядаж л бишопоор үйлчлэхэд нь садаа болохгүй байх ёстой. Хэчнээн их хичээсэн ч тэр үргэлж төгс бус хэвээр байна.

6. Бишоп тойргийн гишүүдээ хангалттай сайн харж хандаж, тусалж дэмжиж чадсангүй дээ гэж боддог.

Бишопт өдөр бүр тухайн өдөр өөр хэнд тусалж эсвэл туслах ёстой байсан бол гэж бодогддог. Би гишүүн нэг бүртэй тогтмол уулзахыг хүсдэг байсан ч надад бас бүрэн цагийн ажил, гэр бүл, өсвөр үеийнхний хөтөлбөр болон тусламж хэрэгтэй тойргийн гишүүд байсан юм. Надад энгийнээр хэлэхэд гишүүн бүртэй тогтмол уулзах хангалттай цаг байдаггүй байлаа.

Гэсэн хэдий ч заримдаа Сүнс надад хэцүү байдалд орсон тодорхой нэг гишүүн дээр очиж уулзах хэрэгтэй гэсэн сүнслэг удирдамжийг бишопын хувьд өгдөг байсан. Тэдэн дээр очиход эхлээд “Таныг ирнэ гэдгийг би мэдэж байсан юм” гэж хэлэхийг би олон удаа сонссон. Эргэж очсон явдал Бурхан залбирлыг маань хариулдаг гэдгийн нотолгоо болохыг хэн хэн нь ухааран ойлгох үед Сүнс хамгийн хүчтэй мэдрэгддэг байсан.

Түүнчлэн “зовлон зүдгүүргүй” гэгдэх идэвхтэй гишүүд маань үүдэн дээрээ намайг хэрхэн угтан авдаг байсан нь надад маш их таалагддаг байсан. Тэр сайн хүмүүс долоо хоног бүр сүмдээ ирэн, дуудлагадаа итгэлтэй үйлчилж, гаднаа том асуудалгүй мэт харагддаг байсан учраас санваарын удирдагчид тэдэн дээр тогтмол очиж уулздаггүй байв. Тэд бишоптойгоо нүүр тулан ганцаарчлан уулзаж байгаадаа маш их баярладаг байлаа. Би та бүхэнд “Баярлалаа! Цаашид ч энэ хэвээрээ байгаарай! Бишоп тань та нарыг хайрладаг бөгөөд боломж бололцоо байсансан бол олон удаа зочлон очих байсан” гэж хэлэх гэсэн юм.

7. Бишоп тань та нарыг бие биедээ бодитой, үнэхээр чин сэтгэлээсээ үйлчлээсэй гэж хүсдэг.

Бишопын хувьд надад тойргийн аль нэгэн гишүүнийг хэцүү байдалтай байгааг хэлэх үед би үргэлж “Тэрийн болон айлчлагч багш нь хэн бэ?” гэж асуудаг байсан. Энэ бол тухайн гишүүний хэрэгцээ шаардлагыг богино болон урт хугацаанд хангах боломжтой эсэхэд үнэлгээ хийх нэг арга зам юм. Ганцаараа үйлчилж байгаа бишоп тойрог, гадасны бусад гишүүний тусламжгүйгээр хүн бүрд хүрч ажиллаж чадахгүй. Тэр ноцтой хүнд байдалд орсон хүмүүс дээр очиж уулзаж чадна, очиж уулзах ч болно. Гэхдээ тэрээр санваарын болон Халамжийн нийгэмлэгийн тусламж дэмжлэгээр хүрч чадахгүй газраа хүрч, тусалж чадна.

Энэ бол тохинууллын ажлын утга учир юм. Бидний зарим нь яагаад бие биедээ тохиуулдаг гэдгээ мартсан байдаг. Их Эзэн бидэнд “бие биеэ хайрлагтун” (Иохан 13:34) хэмээн зарлигласан. Танай бишоп тойргийнхоо гишүүдийн амьдралд “илүү гар бие оролцохын тулд” тохинууллыг сүнслэгээр өдөөгдсөн арга зам болгон ашиглаж байгаа гэдгийг бүү март.



8. Бишоп өөрийн сүргийн төлөө бүхнийг хийхийг хүсдэг.

Өдөр, орой гээд ямар ч цаг үед мөн санваарын адислал өгөх, төөрөгдөлд орсон хүүхдэд зөвлөгөө өгөх эсвэл аваар ослын газар очих гээд юу ч байсан тэр гишүүддээ хэрэгтэй гэсэн бүх зүйлийг хийхийг хүсдэг. Тэр бүгдийг хийж чадахгүй мөн бүх нөхцөл байдалд тохирох хүн нь биш байж болох ч шаардлага гарсан үед түүнээс тусламж гуйхаасаа хэзээ ч эмээх хэрэггүй. Бишоп яг тэр үед үйлчлэхэд бэлэн байх бөгөөд та хоёр хамтран ажилласнаар хоёул адислагдах болно гэдгээ бүү март.

Надад энэхүү ариун нандин дуудлагад үйлчлэх гайхалтай сайхан боломж олдсонд би үргэлж даруусдаг. Намайг үйлчилж байхад итгэл маань мэдлэг болон хувирсан. Би одоо сайн мэдээ үнэн гэдэгт итгэдэггүй, харин үүнийг мэддэг болсон. Би бас Бурхан намайг хэн болохыг мэддэг гэдэгт итгэдэггүй, харин бидний хүн нэг бүрийн хэн болохыг мөн өдөр тутмын амьдрал, хувийн асуудлыг маань мэддэг гэдгийг нь мэднэ. Цаашилбал, Тэрээр Өөрийн үйлчлүүлэгчдээр, ялангуяа санваарын түлхүүр атгагчдаар дамжуулан ажилладаг гэдгийг би мэднэ. Бурхан энэ ажилд анхаарал халамж тавьдаггүй байсан бол би бишопоор үйлчилж чадахгүй байсан гэдгээ мэднэ. Сайн мэдээний үнэн болон Бурханы хүүхдүүдээ гэх хайр нь үйлчлэх боломжийг бишоп бүрд олгодог юм ■.

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Thomas S. Monson, “Duty Calls,” *Ensign*, May 1996, 44.







8-р БҮЛЭГ

8-р бүлэг: Христийн Сүмийн өсөлт

Энэ бол Гэгээнтнүүд: Хожмын үеийн Есүс Христийн Сүмийн түүх нэртэй Сүмийн шинэ дөрвөн боть түүхэн өгүүмлийн номын 8-р бүлэг юм. Уг ном 14 хэл дээр хэвлэгдэн гарсан бөгөөд Gospel Library аппликэйшний Сүмийн түүх хэсэгт болон saints.lds.org дээр байгаа. Өмнөх бүлгүүд нь өмнө гарсан дугааруудад хэвлэгдэн гарсан ба Gospel Library аппликэйшин болон saints.lds.org вэбсайт дээр 47 хэлээр тавигдсан.

1828 оны долоодугаар сарын эхээр гартаа гар бичмэл барьсан Иосеф Их Эзэн өөрөөс нь Мормоны Номыг хэвлүүлж, үүний захиасыг хол ойргүй түгээхийг хүсэж байгааг мэдэж байлаа. Гэвч хэвлэлтэй холбоотой ажил нь түүнд болон түүний гэр бүлд танил бус зүйл байв. Тэр гар бичмэлийг аюулгүй хадгалж, хэвлэх хүнийг эрж олон мөн шинэ судрыг унших хүсэлтэй хүмүүсийн гарт номоо яаж ийгээд хүргэх ёстой байв.

Мормоны Ном шиг зузаан номыг хэвлэхэд өндөр өртөгтэй гарахаар байлаа. Иосефын санхүүгийн байдал түүнийг орчуулга хийж эхэлснээс хойш дээрдээгүй байсан бөгөөд олсон бүх мөнгөө гэр бүлдээ зарцуулж байв. Эцэг эх нь хүний эдлэн дээр ажиллан, ядуу хэвээрээ байсан тул мөн л адил нөхцөл байдалтай байжээ. Иосефт төслийг санхүүжүүлж чадах цорын ганц найз байсан нь Мартин Харрис байв.

Иосеф шаргуу ажиллахаар шамдав. Тэр орчуулгаа дуусгахаасаа өмнө хэн нэгэн гар бичмэлийг хулгайлах юм уу эрхийг нь булаахаас сэргийлж номын зохиогчийн эрхийг авахаар өргөдөл өгсөн байв.¹ Түүнчлэн Иосеф Мартины тусламжтайгаар ном хэвлэхийг зөвшөөрөх хэвлэлийн хүнийг хайж эхлэв.

Тэд эхлээд Палмирт хэвлэх ажил эрхэлдэг насаар Иосефтой чацуу Эгбэрт Грандин дээр очсон ба Грандин номыг хуурамч гэж бодсон учраас тэр даруй уг саналаас татгалзсан байна. Иосеф, Мартин хоёр шантралгүй хайсны эцэст ойролцоох хотод хэвлэх хүсэлтэй хүн байгааг олов. Гэвч тэд түүний саналыг хүлээн авахаасаа өмнө Грандинаас номыг хэвлэхийг хүсэж байгаа эсэхийг дахин нэг удаа асуухаар Палмирт буцаж ирэв.²

Энэ удаад Грандин төсөл дээр ажиллах илүү хүсэлтэй болсон байсан ч таван мянган хувийг хэвлэж, үдэхэд 3000 долларыг урьдчилан бүрэн төлөхийг шаарджээ. Мартин хэвлэлийн зардал дээр тусална гэж хэдийн амласан байсан

ч энэ хэмжээний мөнгийг гаргахын тулд өөрийн эдлэнг барьцаалах хэрэгтэй болж магадгүй гэдгийг ойлгов. Энэ нь Мартинд асар их ачаалал болж байсан ч Иосефын найзуудаас ийм хэмжээний мөнгөөр тусалж чадах хүн байхгүйг тэр мэдэж байлаа.

Зовж шаналсан Мартин Мормоны Номыг санхүүжүүлэх нь зөв эсэхэд эргэлзэж эхэлжээ. Тэр бүс нутгийнхаа хамгийн шилдэг эдлэн газруудын нэгийг эзэмшдэг байсан бөгөөд газраа барьцаалж, зээл авснаар үүнийгээ алдаж ч болох байлаа. Мормоны Номын борлуулалт муу байвал насан туршдаа хуримтлуулсан хөрөнгө нь нүд ирмэхийн зуур алга болж болох байв.

Мартин үүнд санаа зовж байгаагаа Иосефт хэлж, өмнөөс нь илчлэлт авч өгөхийг гуйжээ. Үүний хариуд Аврагч Эцэгийнхээ хүслийг гүйцэлдүүлэхийн тулд Өөрийн гаргасан юутай ч зүйрлэшгүй золиослолын талаар ярьсан ба бүх хүн наманчилж мөн өршөөл хүртэж болохын тулд нүгтийн төлөөсийг төлж байх үеийнхээ Өөрийн эцсийн зовлон шаналлыг дүрслэн хэлсэн. Их Эзэн дараа нь Бурханы төлөвлөгөөг улиран тохиолгохын тулд өөрийн ашиг сонирхлыг золиослох ёстойг Мартинд зарлиглав.

“Чи өөрийнхөө өмч хөрөнгөнд харамч шунаг байх ёсгүй, харин Мормоны Номыг хэвлэхэд үүнийг харамгүйгээр хуваалц” хэмээн Их Эзэн хэлжээ. Их Эзэн энэ номонд Бурханы үнэн үг агуулагдаж байгааг мөн энэ нь сайн мэдээнд итгэхэд бусдад тусална гэдгийг Мартинд батлан хэлсэн юм.³

Хөршүүд нь Мартини шийдвэрийг ойлгоогүй хэдий ч тэр Их Эзэнд дуулгавартай байж, эдлэнгээ барьцаалан, зээл авав.⁴

Грандин гэрээнд гарын үсэг зурснаар энэ томоохон төсөл дээр ажиллаж эхлэв.⁵ Иосеф Мормоны Номын бичвэрийг тухайн үед нэг бичээчийн тусламжтайгаар гурван сарын дотор орчуулсан гэвэл, Грандин арван хоёр хүний хамт 590 хуудас бүхий ажлын эхний хувиудыг хэвлэж, үдэхэд долоон сарыг зарцуулахаар байлаа.⁶

Иосеф хэвлэгч хөлсөлснийхөө дараа 1829 оны аравдугаар сард эдлэн дээрээ ажиллаж мөн Эмматай хамт байхын тулд Хармонид буцаж ирэв. Энэ үед Оливер, Мартин, Хайрум гурав хэвлэлтийг хариуцан, Грандины ажлын явцын талаар Иосефт тогтмол мэдээлж байлаа.⁷

Иосеф эхэлж орчуулсан хуудаснуудыг алдсаныхаа дараа хэрхэн цөхөрч байснаа санаж байсан тул цэг таслалуудыг нэмж мөн өрөлтөд оруулж болохын тулд хэвлэлд өгөх хувийг бэлдэн, Мормоны Номын гар бичмэлийг хуудас хуудсаар нь хуулж бичихийг Оливерээс хүсжээ.⁸

Оливер номыг баяртайгаар хуулсан ба тухайн үед бичсэн захидалуудад энэ талаарх сэтгэгдлийг бүрэн дүүрэн илэрхийлсэн байдаг. Оливер Мормоны Номон дээрх Нифай, Иаков, Амюлек нарын үгсийг давтан, Христийн хязгааргүй Цагаатгалд талархаж байгаагаа Иосефт бичиж байсан юм.

Тэр Иосефт “Би Бурханы нигүүлслийн талаар бичиж эхлэхдээ хэзээ болихоо мэдэхээ больдог ч цаас,

цаг хоёр хүрэлцдэгтүйд асуудал үүсдэг”⁹ гэжээ.

Яг тэр сүнс Мормоны Номыг хэвлүүлэх үеэр хүмүүсийн анхаарлыг Мормоны Номонд хандуулж байв. Өмнө нь хэвлэлийн үйлдвэрт ажиллаж байсан Томас Марш олон сүмд явж байсан ч аль нь ч түүний Библиэс олж мэдсэн сайн мэдээг номлохгүй байгаа мэт санагддаг байв. Тэр сэргээгдсэн үнэнийг заах шинэ сүм удахгүй байгуулагдана гэдэгт итгэж байлаа.

Тэр зун Томас Бостон дахь гэрээсээ олон зуун километрийн зайд орших Нью Йоркийн баруун зүг рүү аялах ёстойгоо Сүнсээр мэдэрчээ. Яагаад ингэж хол аялах болсноо мэдээгүй тэрээр гэрийн зүг буцаж аялалаа тэнд гурван сар байсан байна. Гэсэн хэдий ч буцах замдаа зогссон газрынх нь гэрийн эзэгтэй түүнээс Иосеф Смитийн “алтан номны” талаар сонссон эсэхийг асуухад Томас сонсоогүй гэдгээ уг эмэгтэйд хэлсэн ба улам ихийг мэдэхийг хүсэж байв.

Эмэгтэй түүнд Мартин Харристой уулзахыг зөвлөөд, Палмирт хүрэх замыг зааж өгчээ. Томас даруй тэнд очиж, Мартинь Грандины хэвлэх үйлдвэр дээр байхад нь олж уулзжээ. Хэвлэлийн ажилтан Томаст Мормоны Номын 16 хуудсыг өгөхөд, тэр шинэ итгэлийнхээ анхны амтыг эхнэр Элизабеттайгаа хуваалцахаар тэдгээр хуудсыг Бостонд авчрав.

Элизабет хуудаснуудыг уншаад, энэ бүхэн Бурханы ажил байсан гэдэгт бас итгэсэн юм.¹⁰

Тэр намар, хэвлэлийн ажилтнууд Мормоны Номон дээр тогтвортой ахиц гаргаж байх үед өмнө нь шүүгчээр ажиллаж байсан Абнер Көүл гэгч Грандины хэвлэлийн үйлдвэрт сонин хэвлэж эхэлжээ. Абнер Грандины ажилтнуудыг гэртээ харьсны дараа шөнө цех дээр ажиллаж байхдаа хараахан үдэгдэж, гүйлгээнд гарах болоогүй байсан Мормоны Номын хэвлэгдсэн хуудаснуудыг ашиглаж болохоор байв.

Абнер удалгүй сонин дээрээ “Алтан Библи”-ээр тохуурхан тоглож эхэлсэн төдийгүй тэр өвөлжингөө номноос авсан хэсгүүдээ өгөөдсөн тайлбартайгаар хэвлэн гаргаж байв.¹¹

Хайрум, Оливер хоёр Абнерын юу хийж байгааг олж мэдээд, түүнтэй уулзжээ. “Танд Мормоны Номыг ийм аргаар хэвлэх ямар эрх мэдэл байна вэ?” “Биднийг зохиогчийн эрхээ авсныг та мэдээгүй юу?” гэж Хайрум шаардан асуув.

Абнер “Энэ та нарт хамаагүй ээ.” “Би хэвлэлийн үйлдвэрт мөнгө төлсөн, тиймээс хүссэн болгоноо хэвлэх болно” гэв.

Хайрумыг “Сонин дээрээ энэ номны талаар дахин нийтлэхийг хориглож байна” гэхэд

Абнер “Надад хамаагүй ээ” гэж хэлсэн байна.

Юу хийхээ мэдэхээ больсон Хайрум, Оливер хоёр Хармонид байсан Иосефт үг дайснаар, тэр Палмирт даруй иржээ. Иосеф Абнерыг хэвлэлийн өрөөндөө сониноо уншиж байхад нь олж уулзав.

Иосефыг “Та шаргуу ажиллаж байх чинь” гэхэд

“Та яажшуухан байна даа, ноён Смит” гэж Абнер хөндий хүйтнээр хариулав.

“Ноён Көүл, Мормоны Ном болон үүнийг хэвлэх эрх надад олгогдсон. Та үүнд оролцохгүй байвал сайнсан.”

Абнер хүрмээ тайлж шидээд, ханцуйгаа шамлан “Эрхэм ээ, та зодолдмоор байна уу?” “Тэгвэл, хүрээд ир” гээд нударга зангидан зандрав.

Иосеф инээмсэглэн “Та хүрмээ өмссөн нь дээр байх. Энд хүйтэн байна бас би тантай зодолдохгүй” гэлээ. Тэр цааш нь “Гэхдээ та миний номыг хэвлэхээ болих ёстой” гэж тайвнаар хэлэв.

“Чи өөрийгөө шилдэг нь гэж бодож байгаа юм бол хүрмээ тайлаад, оролдоод үз л дээ” гэхэд

“Хууль гэж байгаа шүү, хэрэв мэдээгүй байсан бол та мэдэж авах болно. Гэхдээ тантай зодолдоод сайн зүйлд хүргэхгүй учир би тийм юм хийхгүй” гэж Иосеф хариулжээ.

Абнер хууль зөрчиж байгаагаа мэдэж байв. Тэр тайвширсан төдийгүй Мормоны Номноос хэсэгчлэн авч сониндоо хэвлэхээ больжээ.¹²

Номлогч Соломон Чэмберлин Канад руу явах замдаа Палмирын ойролцоо түр буудалласан айлаасаа “Алтан библийн” талаар анх сонссон байна. Тэр Томас Марштай адил амьдралынхаа турш сүмээс сүм дамжин явсан ч үзэж харсан зүйлстээ сэтгэл хангалуун бус байв. Зарим сүм сайн мэдээний зарчмуудыг номлож, сүнслэг бэлгүүдэд итгэдэг байсан ч тэдэнд Бурханы бошиглогчид болон санваар байсангүй. Их Эзэн Өөрийн сүмийг тохиолгон авчрах цаг ойртож байгааг Соломон мэдэрч байв.

Соломон энэ гэр бүлийн Иосеф Смит ба алтан ялтсуудын талаар ярихыг сонсоод, толгойноос нь хөлийн ул хүртэл цахилгаан гүйхийг мэдэрч, Смитийн гэрийнхнийг олж, номын талаар илүү ихийг олж мэдэхээр шийджээ.

Тэр Смитийн гэрийг олж очин, үүдэнд нь Хайрумтай уулзав. “Энэ байшинд амар амгалан байг” гэж Соломонуыг хэлэхэд

“Ерөөл бат оршиг” гэж Хайрум хариуллаа.

“Энд үзэгдэл, илчлэлтэд итгэдэг хүн байна уу? гэж Соломонуыг асуухад

“Байлгүй яах вэ, энд амьдардаг бүх хүн үзэгдэлд итгэдэг” гэв.

Соломон Хайрумд олон жилийн өмнө үзсэн үзэгдэлээ ярьж өгөв. Энэ үзэгдэлээр нэгэн тэнгэр элч Бурханы сүм дэлхий дээр байхгүй байгаа ч удахгүй эртний төлөөлөгчдийн сүмтэй адил хүчирхэг сүм байгуулагдана гэжээ. Хайрум болон байшинд байсан бусад хүн Соломонуы юу ярьж байгааг ойлгож байсан ба тэд адил зүйлд итгэдгээ түүнд хэлжээ.

“Мэдэж авсан зүйлсээсээ надтай хуваалцаач. Би тэднийг хүлээн авч чадна гэж бодож байна” гэж Соломон хэлэв.

Хайрум түүнийг Смитийн гэр бүлд зочноор үлдэхийг урьж, Мормоны Номын гар бичмэлийг үзүүлэв. Соломон хоёр өдрийн турш үүнийг судлаад мөн Хайрумтай хамт Грандины хэвлэх оффист очиход тэр хэвлэсэн 64 хуудсыг авч түүнд өгөв. Соломон үдээгүй хуудаснуудыг гартаа барьсаар, шинэ итгэл үнэмшлийнхээ талаар мэдэж авсан бүхнээ номлохын тулд Канадыг зүглэн аяллаа үргэлжлүүлжээ.¹³

1830 оны 3-р сарын 26-нд Мормоны Номын эхний хувиуд үдэгдэн, Грандины хэвлэх газрын 1-р давхарт

гүйлгээнд гарахад бэлэн болон тавигдсан байв. Номнуудыг бор өнгийн тугалын арьсаар хийсэн хавтсанд чанга гэгч үдсэн байсан ба арьс, цавуу, цаас, бэхний үнэр ханхалж байсан. Номын нуруун дээр *Мормоны Ном* гэсэн үгс алтан шаргалаар бичигдсэн байв.¹⁴

Люси Смит шинэ судрыг нандигнан, үүнийг Бурхан Өөрийн хүүхдүүдийг удахгүй цуглуулж, эртний гэрээгээ сэргээх бэлгэ тэмдэг гэж үзэж байв. Номын нүүр хуудсан дээр энэ ном өнгөрсөн цагт Бурханы Өөрийн хүмүүсийн төлөө агуу зүйлс хийсэн гэдгийг болон өнөө үед амьдарч буй Өөрийн хүмүүст мөн адил адислалуудыг өгөхөөр гар сунгадаг гэдгийг үзүүлэх, түүнчлэн Есүс Христ бол дэлхийн Аврагч гэдгийг бүх дэлхийд итгүүлэх зорилготой гэж тунхагласан байв.¹⁵

Номын ард талд, ялтсуудыг харснаа мөн уг орчуулгыг үнэн гэдгийг мэддэгээ дэлхийд мэдүүлсэн гурван гэрч ба найман гэрчийн гэрчлэлүүд багтсан байв.¹⁶

Энэ бүх гэрчлэл байсан ч зарим хүн үүнийг хуурамч гэж бодож байсныг Люси мэдэж байлаа. Хөршүүдээс нь олон хүн Бурхан нэгээс илүү үндэстэнг Өөрийн үгээр адисалсан гэдгийг ойлгохгүй байснаас зөвхөн Библи байхад хангалттай гэдэгт итгэж байв. Бурхан дэлхийд хандан ярих зүйлээ ярьчихсан бөгөөд дахин ярих нь үгүй гэдэгт зарим хүн итгэдэг байсан тул энэ захиасыг эсэргүүцсэн гэдгийг тэр бас мэдэж байлаа.

Энэ болон бусад шалтгаанаар Палмирын ихэнх хүн номыг худалдаж аваагүй юм.¹⁷ Гэвч зарим нь хуудаснуудыг судалж, захиасуудынх нь хүчийг мэдэрч, Их Эзэнээс үүний үнэн эсэхийг асуухаар өвдөг сөгджээ. Мормоны Ном бол Бурханы үг байсныг Люси өөрөө мэддэг байсан бөгөөд үүнийг бусадтай хуваалцахыг хүсэж байв.¹⁸

Иосеф, Оливер хоёр Мормоны Номыг хэвлүүлснийхээ дараахан удалгүй Есүс Христийн сүмийг зохион байгуулахад бэлтгэж байлаа. Хэдэн сарын өмнө Их Эзэний эртний төлөөлөгчид болох Петр, Иаков, Иохан нар Иохан Баптистын амласны дагуу тэдэнд үзэгдэж, тэдэнд Мелкизедек санваар хүртээжээ. Энэхүү нэмэлт эрх мэдэл нь Иосеф, Оливер хоёрыг баптисм хүртээсэн хүмүүстээ Ариун Сүнсний бэлэг өгөх боломжтой болгосон юм. Петр, Иаков,

Иохан нар мөн тэднийг Есүс Христийн төлөөлөгчид байхаар томилсон байв.¹⁹

Энэ үеэр Иосеф, Оливер хоёр Витмерийн гэрт байх хугацаандаа энэ эрх мэдлийн талаар илүү их мэдлэг олж авахын төлөө залбирчээ. Үүний хариуд Их Эзэний дуу хоолой сонсдож, нэг нэгнээ сүмийн ахлагчаар томилохыг тэдэнд тушаав. Гэхдээ итгэгчид өөрсдийг нь Аврагчийн сүмийн удирдагч хэмээн дагахаар хүлээн зөвшөөрөхөөс нааш тэд үүнийг хийх ёсгүй байв. Мөн тэд сүмийн бусад албан тушаалтныг томилж, баптисм хүртээсэн хүмүүстээ Ариун Сүнсний бэлэг өгөх ёстойг тэдэнд хэлэв.²⁰

1830 оны 4-р сарын 6-нд Иосеф, Оливер хоёр Их Эзэний зарлигийг дагаж, Түүний сүмийг байгуулахаар Витмерийн гэрт уулзав. Тэд хуулийн шаардлагуудыг хангахын тулд, шинэ сүмийн анхны гишүүдээр 6 хүнийг сонгожээ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэн дөчөөд хүн уг үйл явдлыг гэрчлэхээр жижиг байшин дотор мөн эргэн тойронд цугларсан байлаа.²¹

Иосеф, Оливер хоёр өмнө нь Их Эзэнээс авсан заавраа дуулгавартай дагахаар Бурханы хаант улсын удирдагчдаар өөрсдийг нь дэмжин батлахыг мөн сүм зохион байгуулагдаж байгааг зөв гэж үзэж байгаагаа мэдэгдэхийг цугларагсдаас хүсэв. Цугларсан гишүүд бүгд зөвшөөрсөн төдийгүй Иосеф Оливерын толгой дээр гараа тавьж, түүнийг сүмийн ахлагчаар томиласны дараа тэд байраа сольж, Оливер Иосефыг томилов.

Дараа нь тэд Христийн Цагаатгалыг дурсан санаж, ариун ёслолын талх, дарсыг адислав. Тэгээд тэд баптисм хүртээсэн хүмүүсийнхээ толгой дээр гар тавин, сүмийн гишүүнээр баталж, тэдэнд Ариун Сүнсний бэлэг өгөв.²² Их Эзэний Сүнс цуглаанд оролцсон хүмүүсийн дээр цутгадахад тэдний зарим нь бошиглож эхлэн, зарим нь Их Эзэнийг магтан дуулж, бүгд хамтдаа баясацгааж байлаа.

Түүнчлэн Иосеф шинэ сүм даяар өгөгдсөн анхны илчлэлтийг хүлээн авав. Их Эзэн хүмүүстээ өөрсдийн ариун түүхийг бичиж, өөрсдийн үйлийн цэдгүүдийг хадгалахыг мөн Иосеф Смитийн бошиглогч, үзмэрч, илчлэгчийн үүргийг гэрчлэх ёстойг сануулан, “Болгоогтун, та нарын дунд цэдэг хөтлөгдөх болно” хэмээн зарлиглажээ.

“Сайн сайхны төлөө хүчирхэг хүч чадалд Сионы ашиг сонирхлыг урагш ахиулахын тулд би түүнд бурханлигаар нөлөөлсөн билээ. Түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой. Учир нь эдгээр зүйлүүдийг хийснээр тамын үүд та нарыг дийлэх нь үгүй”²³ хэмээн Их Эзэн тунхагласан юм.

Хожим нь Иосеф голын дэргэд зогсоод, эцэг эхийгээ сүмд элсэн, баптисм хүртэхийг харав. Үнэний эрэлд олон жил өөр өөр замаар бэдэрсний дараа тэд эцэст нь итгэлээрээ нэгдсэн юм. Аавыгаа уснаас гарахад Иосеф түүний гараас барин, голын эрэг дээр гарахад нь туслаад, тэврэн авч,

“Бурхан минь, би аавынхаа Есүс Христийн үнэн сүмд баптисм хүртэхийг нүдээрээ үзлээ!”²⁴ гэж аавынхаа цээжинд нүүрээ наан, дуу алджээ.

Тэр үдэш баяр хөөрт автсан Иосеф ойролцоох ой руу орж, найзууд, гэр бүлийнхнээсээ холдон, ганцаараа байхыг хүссэн юм. Анхны үзэгдэлээс хойш арван жилийн дотор тэр тэнгэр нээгдэхийг харж, Бурханы Сүнийг мэдэрч, тэнгэр элчүүдээр сургагджээ. Тэр бас нүгэл үйлдэн, бэлгээ алдаж мөн наманчилснаар Бурханы нигүүлслийг хүлээн авч, Мормоны Номыг Түүний хүч хийгээд ач ивээлээр орчуулсан билээ.

Ийнхүү Есүс Христ Өөрийн Сүмийг сэргээсэн бөгөөд эрт цагт төлөөлөгчдийн сайн мэдээг дэлхийд түгээхдээ атгаж байсан тэрхүү санваарыг Иосефт олгосон.²⁵ Иосефын мэдэрч байсан баяр хөөр туйлын их байсан тул тэр үдэш Иосеф Найт, Оливер хоёрыг түүнийг хайж олох үед тэр уйлаад сууж байсан гэдэг.

Тэр баяр баясгалангаар дүүрсэн байсан юм. Ажил хэдийн эхэлсэн байлаа.²⁶ ■

Эш татсан бүтээлүүдийн бүрэн жагсаалт saints.lds.org вэбсайтад англи хэл дээр бий.

Тэмдэглэл дэх Сэдэв гэсэн үг нь онлайнгаар болон saints.lds.org вэбсайт дээр дэлгэрэнгүй мэдээлэл байгааг илэрхийлнэ.

ЭШЛЭЛҮҮД

- Copyright for Book of Mormon, June 11, 1829, in *JSP*, D1:76–81.
- “Prospect of Peace with Utah,” *Albany Evening Journal*, May 19, 1858, [2]; “From the Troy Times,” *Albany Evening Journal*, May 21, 1858, [2]; John H. Gilbert, Memorandum, Sept. 8, 1892, photocopy, Church History Library.
- Супраал ба Гэрээ 19 (Revelation, circa Summer 1829, at josephsmithpapers.org); see also Historical Introduction to Revelation, circa Summer 1829 [DC 19], in *JSP*, D1:85–89; and Knight, *Reminiscences*, 6–7.
- McBride, “Contributions of Martin Harris,” 1–9; Joseph Smith History, 1838–56, volume A-1, 34, in *JSP*, H1:352 (draft 2).
- John H. Gilbert, Statement, Oct. 23, 1887, Church History Library; Indenture, Martin Harris to Egbert B. Grandin, Wayne County, NY, Aug. 25, 1829, Wayne County, NY, Mortgage Records, volume 3, 325–26, microfilm 479,556, U.S. and Canada Record Collection, Family History Library; Historical Introduction to Revelation, circa Summer 1829 [DC 19], in *JSP*, D1:85–89.
- Copyright for Book of Mormon, June 11, 1829, in *JSP*, D1:76–81; John H. Gilbert, Memorandum, Sept. 8, 1892, photocopy, Church History Library; Porter, “The Book of Mormon,” 53–54.
- John H. Gilbert, Memorandum, Sept. 8, 1892, photocopy, Church History Library; Lucy Mack Smith, History, 1844–45, book 9, [8]; Joseph Smith to Oliver Cowdery, Oct. 22, 1829, in *JSP*, D1:94–97.
- John H. Gilbert, Memorandum, Sept. 8, 1892, photocopy, Church History Library; Lucy Mack Smith, History, 1844–45, book 9, [2]; “Printer’s Manuscript of the Book of Mormon,” in *JSP*, R3, Part 1:xxvi. **Сэдэв:** Мормоны Номыг хэвлэн нийтэлсэн нь
- Oliver Cowdery to Joseph Smith, Nov. 6, 1829, in *JSP*, D1:100–101; Mosiah 3:18–19; 5:5–7; 4 Nephi 1:17; see also Oliver Cowdery to Joseph Smith, Dec. 28, 1829, in *JSP*, D1:101–4.
- Thomas B. Marsh, “History of Thomas Baldwin Marsh,” *LDS Millennial Star*, June 4, 1864, 26:359–60; June 11, 1864, 26:375–76.
- Lucy Mack Smith, History, 1844–1845, book 9, [9]. Абнер Көүлийн хэвлэсэн Мормоны Номын хэсгүүдийн жишээг харахын тулд “The Book of Mormon,” *Reflector*, Sept. 16, 1829, 10; “Selected Items,” *Reflector*, Sept. 23, 1829, 14; “The First Book of Nephi,” *Reflector*, Jan. 2, 1830, 1; and “The First Book of Nephi,” *Reflector*, Jan. 13, 1830, 1 зэргийг үзнэ үү. **Сэдэв:** Мормоны Номын шүүмжлэгчид
- Lucy Mack Smith, History, 1844–1845, book 9, [9]–[12]; Lucy Mack Smith, History, 1845, 166–168.
- Chamberlin, *Autobiography*, 4–11.
- Copyright for Book of Mormon, June 11, 1829, in *JSP*, D1:76–81; John H. Gilbert, Memorandum, Sept. 8, 1892, photocopy, Church History Library; “Book of Mormon,” *Wayne Sentinel*, Mar. 26, 1830, [3]. Зарим ном нь хонины нэхийгээр хийсэн хавтастай байв.
- Title Page of Book of Mormon, circa early June 1829, in *JSP*, D1:63–65; see also Lucy Mack Smith to Solomon Mack, Jan. 6, 1831, Church History Library.
- Testimony of Three Witnesses, Late June 1829, in *JSP*, D1:378–82; Testimony of Eight Witnesses, Late June 1829, in *JSP*, D1:385–87.
- Tucker, *Origin, Rise, and Progress of Mormonism*, 60–61.
- See Lucy Mack Smith to Solomon Mack, Jan. 6, 1831, Church History Library.
- Joseph Smith History, circa Summer 1832, 1, in *JSP*, H1:10; Doctrine and Covenants 27:12–13 (Revelation, circa Aug. 1830, in Doctrine and Covenants 50:3, 1835 edition, at josephsmithpapers.org); Oliver Cowdery to Phineas Young, Mar. 23, 1846, Church History Library; “Joseph Smith Documents Dating through June 1831,” in *JSP*, D1:xxxvii–xxxix; see also Cannon and others, “Priesthood Restoration Documents,” 163–207. **Сэдэв:** Мелкизедек санваарын сэргээлт
- Joseph Smith History, 1838–1856, volume A-1, 27, in *JSP*, H1:326–28 (draft 2).
- Joseph Smith History, 1838–1856, volume A-1, 37, in *JSP*, H1:364 (draft 2); Stevenson, Journal, Dec. 22, 1877; Jan. 2, 1887; An Act to Provide for the Incorporation of Religious Societies (Apr. 5, 1813), *Laws of the State of New-York* (1813), 2:212–19. **Сэдэв:** Христийн Сүмийн анхны цуглаан
- Joseph Smith History, 1838–1856, volume A-1, 37–38, in *JSP*, H1:364–71 (draft 2).
- Joseph Smith History, 1838–1856, volume A-1, 37, in *JSP*, H1:366; Doctrine and Covenants 21 (Revelation, Apr. 6, 1830, at josephsmithpapers.org); “History of Joseph Smith,” *Times and Seasons*, Oct. 1, 1842, 3:928–29.
- Lucy Mack Smith, History, 1844–1845, book 9, [12]; Knight, *Reminiscences*, 8; see also Bushman, *Rough Stone Rolling*, 110.
- Joseph Smith History, 1838–1856, volume A-1, 38, in *JSP*, H1:372 (draft 2); Joseph Smith, “Latter Day Saints,” in Rupp, *He Pasa Ekklesia*, 404–5, in *JSP*, H1:506.
- Knight, *Reminiscences*, 7.



Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулга
Ахлагч
Квинтин Л.Кук

Их Эзэн хэрхэн нигүүлсэнгүй хандсаар ирсэн бэ?

*Сүмийн тухай олон боть түүх нь Аврагчийн бидний төлөө хийсэн
зүйлсийн талаарх ой санамжийг маань тэлэх замаар бидэнд
гэрээгээ сахихад тусална.*

Бараг зуун жилийн дараа Сүмийн олон боть түүх Тэргүүн Зөвлөл болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын удирдлаган доор хэвлэгдэж байна. *Гэгээнтнүүд: Хожмын үеийн Есүс Христийн Сүмийн түүх* хэмээх нэртэй энэхүү түүхэн өгүүлэл нь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан гэгээнтэн болсон энгийн хүмүүсийн бодит түүх юм (Мозая 3:19-ийг үзнэ үү). *Үнэний жишиг, 1815–1846* гэх эхний боть нь дуусаад байгаа төдийгүй дэлхийн өнцөг булан бүрд түгээхээр 14 хэл дээр орчуулагдаад байна.

Гэгээнтнүүд ном нь Бурхан Өөрийн хүүхдүүдийг хайрладаг учраас үүрдийн гэрээгээ хэрхэн сэргээсэн талаар өгүүлдэг. Энэ нь Их Эзэн үймээн самуун, сорилт, бэрхшээлтэй үед итгэл найдвар, амар амгаланг өгөхийн тулд хэрхэн сайн мэдээгээ сэргээсэн болохыг үзүүлдэг. Энэ нь бас сэргээгдсэн гэрээнүүдийг Есүс Христээр дамжуулан хэрхэн өргөмжлөлд хүргэдэг болохыг харуулдаг.

Уг түүх Иосеф Смитээр эхлэх байх гэж та бодож болох ч *Гэгээнтнүүд* ном нь 1815 онд болсон үйл явдлаар буюу дэлхий даяар үхэл, өвчин, сүйрэл авчирсан Индонезид болсон галт уулын дэлбэрэлтээр эхэлдэг. Биднийг Аврагчтай холбож, амьдралын бүхий л асуудлыг даван туулах боломж олгодог гэрээнүүдийг Их Эзэн хэрхэн сэргээсэн талаарх Түүний илчилсэн зүйл дээр эхний цэгийг сонгон суурилуулсан юм.



Бурхан хилэнц, зовлон, зүдгүүр, үхэх үед учирдаг хагацлыг авч хаяагүй ч Аврагчийн Цагаатгалаар дамжуулан эдгээж, харилцаа холбоо мөнхөд үргэлжлэх боломжтой гэдгийг бататгадаг гэрээнүүдийг бошиглогчдоороо дамжуулан шинэчилсэн.

“Их Эзэн бибээр, дэлхийн оршин суугчид дээр ирэх тэрхүү сүйрлийг мэдэх учраас, өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг дуудан, тэнгэрээс түүнд ярьж, мөн түүнд зарлигуудыг өгсөн ажгуу;

Тэрхүү миний үүрдийн гэрээ үндэслэгдэн бий болж болохын тулд юм” (С ба Г 1:17, 22).

Эхний түүхээсээ эхлэн дэлхий даяар тараагдах хүртлээ *Гэгээнтнүүд* ном нь дэлхийн өнцөг булан бүрд байх Бурханы хүүхдүүдэд энэ нь тэдний зовлон бэрхшээлийг мэддэг Бурхантай хийсэн гэрээний түүх юм гэдгийг сануулж байгаа юм. Бурхан Өөрийн бошиглогчоор дамжуулан гэрээнүүдийг сэргээсэн бөгөөд тэдгээр нь хилэнц, уй гашуу, зовлон, зүдгүүр, үхэл хагацлыг авч хаяхгүй ч Аврагчийн Цагаатгалаар дамжуулан эдгэрлийг амлаж, бидний амьдралыг ариусган, ер бусын утга агуулгатай болгосон ба энэ дэлхий дээр нандигнан хайрладаг харилцаа холбоо маань “мөнхийн алдар суутаар хоёр дахин ихсэ[н]” (С ба Г 130:2-ыг үзнэ үү) мөнхөд үргэлжлэх боломжтой гэдгийг бататгадаг.

Үнэний жишиг номын эхний 8-н бүлгийг жилийн туршид энэ сэтгүүлийн дугааруудад хэвлэн гаргасан. Энэ сарын дугаарт *Гэгээнтнүүд* номын хамгийн сүүлчийн цуврал бүлгийг гаргах ч уг түүхийг **saints.lds.org**, Gospel Library аппликэйшнаар болон хэвлэмэл хувилбараар (**store.lds.org** дээрээс захиална уу) үргэлжлүүлэн гаргах болно. Би та бүхнийг



дээрх арга замуудын аль нэгээр эдгээрийг үргэлжлүүлэн авч уншихад урьж байна.

Тэнгэрлэг загвар ба төлөвлөгөө

Гэгээнтнүүд ном нь бошиглогчид өөрсдийн тохирууллын нэгэн хэсэг болгон бидэнд хэн гэдгээ болон Бурханы зорилгыг амьдралаасаа олж харахад туслахын тулд өнгөрсөн үйл явдлыг ашигладаг бурханлаг загварыг үргэлжлүүлэн ашигладаг. Судруудад олон бошиглогч Их Эзэний өвөг дээдэст нь хэрхэн нигүүлсэнгүй хандсан талаарх түүхүүдийг ярих замаар зааж эхэлдэг.¹ Моронай Мормоны Номын уншигчдыг түүхийн туршид “Их Эзэн хэчнээн нигүүлсэнгүй байсаар буйг та нар

санан мөн үүнийг зүрх сэтгэлдээ тунгаахыг” ухуулсан (Моронай 10:3). Бурханы нинжин сэтгэлийн талаар эргэцүүлэн бодох нь бидэнд “тэдгээр зүйлүүдийг байгаагаар нь, мөн тэдгээр зүйлүүдийг үнэхээр байхаар нь” заадаг Сүнсний гэрчийг хүлээн авахад биднийг бэлддэг (Иаков 4:13; Моронай 10:4–5-ыг үзнэ үү).

Тэнгэрлэг эцэг эх маань бидний эцсийн аз жаргал, өргөмжлөлийг төлөвлөсөн гэдгийг мэдэх нь бидэнд хэтийн төлөвийг болон тэнгэрлэг эцэг эхийн үр хүүхдүүд гэсэн шинж чанарыг өгч, хүнд хэцүү үед ч Их Эзэнд итгэх итгэлийг маань өсгөн нэмэгдүүлдэг. Их Эзэний нинжин сэтгэлийг санаж байх нь эд баялгаас ирэх бардамнал, аюулаас биднийг мөн адил хамгаална. Моронай нифайчуудын “үлэмж баян болж эх[элсэн]” цагийн тухай бичсэн байдаг. Гэвч бардамнал, эд баялаг нь хүмүүсийн уналтынх нь шалтгаан болж байсан Мормоны Номон дээрх өөр цаг үеүдээс ялгаатай нь, тэд өөр замыг сонгосон байдаг. “Гэвч тэдний баялаг, өөрөөр хэлбэл хүч чадал, өөрөөр хэлбэл дэгжил хөгжил байсан хэдий ч, тэд өөрсдийнхөө нүдэнд бардамнан хөөрсөн нь үгүй; бас Их Эзэн Бурханаа дурсан санахдаа ч хойрго байсангүй; харин тэд түүний өмнө өөрсдийгөө үлэмж даруусгасан ажээ.” Тэд “Их Эзэн тэдний төлөө ямар агуу зүйлүүд хийснийг” (Алма 62:48–50-ийг үзнэ үү) санаж байсан тул гэрээнүүдээ сахиж, зөв шударга хэвээр үлдсэн байжээ.

Гэгээнтнүүд ном нь үүний адил өөр олон сургамжийг заадаг. Та Их Эзэнийг хайрладаг, Түүний хайрыг мэдэрч байсан төгс бус хүмүүсийн итгэлийн сорилт, сэтгэлийн зовлон, баяр баясгалан, илчлэлтүүд болон шийдвэрийг мэдрэх үед энэ нь танд амьдралдаа Их Эзэний мутрыг олж харахад тусална.

Та уншиж байхдаа өмнө нь сонсож байсан түүхээсээ хүртэл шинэ ойлголт, утга агуулга олж харах болно. Сүмийн түүхэнд Иосеф Смитийн Анхны үзэгдлээс өөр сайн цэдэглэгдсэн түүх байхгүй ч *Гэгээнтнүүд* ном нь Иосеф зүрх сэтгэлдээ мэдэрсэн зүйлээ оюун ухаандаа бодсон зүйлтэйгээ нийцүүлэх гэж хэрхэн тэмцэлдсэн болохыг илүү сайн ойлгоход бидэнд тусалдаг.

Тухайн үед байсан аль ч сүм “Шинэ Гэрээнд цэдэглэгдсэн Есүс Христийн сайн мэдээг”² заахгүй байгааг Иосеф анзаарсан байсан тул түүний Аврагчийн өршөөлийг мэдрэх гэсэн хүсэл гүйцэлдэх боломжгүй байв. Иосеф аль сүм зөв

болохыг эсвэл бүгдээрээ буруу эсэхийг тунгаажээ. Тэр эрэлхийлж буй амар амгалангаа олохын тулд аль нэгийг нь зөв байгаасай хэмээн дотроо ихэд найдаж байсан юм. Бодол санаа, зүрх сэтгэл хоёр нь зөрж байх үед Иосеф Бурханаас асууж болох юм байна гэдгээ олж нээсэн. Тэр залбирахын тулд ой руу явсан. Тэнд түүнд Эцэг, Хүү хоёр үзэгдэж, түүнийг өршөөн, мухардлыг нь төсөөлж ч байгаагүй арга замаар шийдвэрлэж өгсөн билээ.³

Иосеф болон түүний гэр бүлийнхэн мөн Их Эзэний сэргээгдсэн гэрээг хүлээн авсан өөр олон хүн Бурханы тэднийг гэх хайрыг мэдрэн, Түүнд хэрхэн ойртож болох талаар суралцаж, хайртай хүмүүстэйгээ харьцах харилцаагаа илааршуулахыг хүссэн. *Гэгээнтнүүд* ном нь тэдний түүхийг өгүүлдэг.



Гэгээнтнүүд ном нь Их Эзэний ажил хэргийг мэдэж авах нь бидэнд аливаа зүйлсийг мөнхийн талаас харах боломжийг олгон, тэдгээрийг байгаагаар нь болон байж болохоор нь харж мөн Их Эзэн биднийг хүнд хэцүү үед харж хандана гэдэгт итгэх итгэлээ хөгжүүлэхэд тусалдаг болохыг харуулдаг.

Сорилт бэрхшээлтэй үед Их Эзэнд итгэж найдах нь

Гэгээнтнүүд номын 1-р ботид Их Эзэний зарлигуудыг дагаж, Түүний хүслийн дагуу үйлдэж байсан Аманда Барнэс Смит болон түүний гэр бүлийнхний түүх багтсан байдаг.⁴ Амандагийн нөхрийг нэг хүүтэй нь мөн Миссуригийн Шоал Крийк гэх жижигхэн сууринд буудалласан бусад 15 хожмын үеийн гэгээнтэнтэй хамт хэрцгийгээр хөнөөсөн байлаа. Их Эзэн Амандаг энэхүү аймшигт үйл явдлын туршид өргөн дэмжиж, залбиралд нь хариулсан төдийгүй, хүндээр шархдаж гэмтсэн хүүг нь эдгээсэн юм.⁵

Гэгээнтнүүд номонд Амандаг асар их зовлон бэрхшээл дунд Их Эзэнд хэрхэн итгэж найдаж сурсан болохыг харуулдаг. Түүнчлэн зовж зүдэрч байхдаа ч гэсэн Иосеф Смит Бурханы нинжин сэтгэлийг хэрхэн олж мэдсэн тухай өгүүлдэг. Энэ нь Их Эзэний ажил хэргийг мэдэх нь бидэнд аливаа зүйлсийг мөнхийн талаас нь харах боломжийг олгон, тэдгээрийг байгаагаар нь төдийгүй, байж болохоор нь харж мөн Тэрээр биднийг хүнд хэцүү үед харж хандана гэдэгт итгэх итгэлээ хөгжүүлэхэд тусалдаг болохыг харуулдаг.

Бошиглогч Иосеф Шоал Крийкт Амандагийн гэр бүл болон бусад хүнд тохиолдсон зүйлийн талаар сонсоод, тэдгээр гэгээнтэнг хоморголон алуулж байснаас өөрөө шоронд орж, үхсэн нь дээр гэж бодож байжээ. Дараа өдөр нь тэр Миссуригийн цагдаагийнхантай асуудлыг тайван байдлаар шийдвэрлэх оролдлого гаргаж, Фар Вэстийн гол суурин дахь гэгээнтнүүд рүү хийх гэж байсан дайралтыг зогсоосон юм. Оронд нь тэр баригдаж, шоронд орсон байлаа.



Бараг таван сарын дараа Иосеф Миссуригийн Либерти шоронгийн хүйтэн өрөөнд шахцалдан, хоригдсон хэвээр байв. Тэр Бурханыг хаана байгааг мөн бэлэвсэрч, өнчилсөн хүмүүсийн гуйлтыг хэчнээн удаан сонсохыг нь асуув. “Ай Их Эзэн минь, тэдэн уруу таны зүрх сэтгэл зөөлөрч, мөн таны дотор тэдэн уруу өрөвч сэтгэлээр хөдөлсөн байхаас өмнө тэд эдгээр буруу зүйлүүдийг мөн хууль бус доромжлолуудыг хэчнээн удаан тэвчих юм бэ?” хэмээн тэр залбирсан билээ. (С ба Г 121:3).

Гэгээнтнүүд ном нь зовлон бэрхшээл бол Их Эзэний таалахгүй эсвэл адислалаа эргүүлэн авч байгаагийн нотолгоо биш гэдгийг бидэнд заадаг. Сөрөг зүйлс нь

Бурханы төлөвлөгөөний нэгэн хэсэг бөгөөд тэдгээр нь биднийг мөнхийн, селестиел хувь тавиланд цэвэршүүлэн бэлддэг билээ (2 Нифай 2:11-ийг үзнэ үү). Аврагчийн эцэс төгсгөлгүй зовлон зүдгүүр нь биднийг зовж байхад халамжилж, эцсийн эцэст өргөмжлөх боломжийг Түүнд олгодог гэдгийг Иосеф мэдэж авсан (Алма 7:11–13-ыг үзнэ үү). Иосефын зовлон зүдгүүр дунд тавьсан асуултын хариуд Их Эзэн бүх төрлийн саад бэрхшээлийг тоочсоныхоо эцэст:

“Хэрэв тамын эрүү чиний араас амаа томоор ангайлах аваас, эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь.

Хүний Хүү тэд бүгдэд доош бууж ирсэн юм. Чи түүнээс илүү агуу гэж үү?” хэмээн хэлсэн юм. (С ба Г 122:7–8).

Эдгээрийг өөрийн биеэр мэдрэх нь бидэнд Христтэй адил зовлонд унасан хүмүүсийн зовлон шаналлыг ойлгох чадварыг олгодог. Иосеф шоронд байхдаа “Энэ үйл явдлын дараа миний зүрх сэтгэл үргэлж урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр зөөлөрсөн байна” гэдгээ ухаарчээ. Тэр гэгээнтнүүдтэй хамт байж, тэднийг тайтгаруулахыг хүсэж байсан. Тэр “Надад тэдгээр шударга бус явдал тохиолдоогүй бол одоо төрж байгаа мэдрэмжийг би мэдрэхгүй байх байсан”⁶ хэмээн тайлбарласан байдаг.

Тэргүүн Зөвлөл болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга *Гэгээнтнүүд* номыг хэвлэхийг зөвшөөрч, үүрэг даалгавар өгсөн шалтгаануудын нэг бол бидний хүн нэг бүрд *эдгээр зүйлийг* бусдын түүхээр дамжуулан мэдрүүлэх явдал юм. Хэдийгээр Бурхан хэмжээлшгүй мэргэн ухаанаар хилэнц, гай зовлонг зайлуулахгүй байх нь зүйтэй гэж үзсэн ч биднийг хайрладаг мөн боддог болохыг нь бид Амандагаар дамжуулан сурах боломжтой. Тэрээр бидний залбирлыг сонсдог төдийгүй энэрэнгүй, нинжин сэтгэлтэй билээ.

Ариун сүмийн сэргээгдсэн адислалууд

Тэрхүү энэрэнгүй, нинжин сэтгэлийг нь ариун сүмээс өөр хаанаас ч олж харах боломжгүй юм. *Гэгээнтнүүд* номын төвд ариун сүмийн сэргээгдсэн адислалуудын түүх байдаг. Эхний боть нь 1846 онд Наувугийн ариун сүмд олон мянган хожмын үеийн гэгээнтэн ариун нандин ёслолуудыг хүлээн авч байгаагаар дуусдаг. Хоёр дахь ботийн оргил хэсэг бол 1893 онд Солт Лэйк ариун сүмийг онцгойлон адисалж, тэнд гэгээнтнүүд ёслолуудыг хүлээн авч эхэлсэн түүх байх юм. Гурав дахь боть нь 1955 онд Европын гэгээнтнүүд Швейцарь дахь ариун сүмд цугларч эхэлсэн түүхээр дуусна. Дөрөв дэх боть

дээр орчин үеийн түүх гарах ба эрт дээр үед бошиглогчдын зөгнөн харснаар ариун сүм дэлхий даяар баригдаж, дэлхийн бөмбөрцгийн булан бүрд байх гэгээнтнүүд өргөмжлөлийн ёслолуудыг хүлээн авч байгаа тухай өгүүлнэ.

Их Эзэний өргөөнд бид гэрээнд орж, энэ дэлхийн хилэнц, зовлон зүдгүүр гэх мэт Уналтын үр дагаврыг даван туулах хүчээс хүртдэг. Бид хамгаалалтыг, эцэст нь хайртай хүмүүстэйгээ мөнхөд лацдуулан, Амиалтаар урагш гарч ирэх хүчийг хүлээн авдаг.

Гэгээнтнүүд ном нь бидний ой санамжийг ариун нандин арга замаар тэлэх замаар бидэнд гэрээгээ санахад туслах болно. Энэ нь бидэнд Аврагчийн бидний төлөө хийсэн зүйлийг үргэлж санахад тусална. Бид Бурханы урьд өмнө хийж байсан зүйлийн талаарх цэдэггүйгээр “Их Эзэн хүмүүний үрсэд хэчнээн нигүүлсэнгүй байсаар буйг” (Моронай 10:3) санахгүй байх байсан. Ийм шалтгааны улмаас бид Их Эзэнд болон Түүний тэднийг гэх хайрыг мэдэрсэн туршлагаа бичиж тэмдэглэсэн гэгээнтнүүдэд талархаж байх ёстой. Их Эзэн Иосеф Смитэд туршлагаа бичиж тэмдэглэхийг зарлигласан (С ба Г 21:1-ийг үзнэ үү). Тэрээр Иосефын удирдлаган доор ажиллаж байсан түүхчид “сүмийн цэдгийг хийгээд түүхийг байнга хөтлөх[ийг]” (С ба Г 47:3) зарлигласан билээ. Түүхэн бичгүүдэд “сүмийн сайн сайхны тулд мөн өсч өндийх ирээдүй үеийнхний тулд байх бүх зүйлийг” (С ба Г 69:8) оруулахыг зарлигласан байдаг.

Эдгээр илчлэлт болон Аврагчийг үргэлж дурсан санаж байх гэрээт амлалтаа марталгүйгээр Тэргүүн Зөвлөл, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга *Гэгээнтнүүд* номыг 10 жилийн өмнөөс төлөвлөсөн юм. Одоо бид та нарыг үүнийг уншаад, энэ нь Бурханы төлөвлөгөөг ойлгоход танд тусална гэдэгт итгэж, Их Эзэн хэрхэн нигүүлсэнгүй хандсаар ирсэн гэдгийг олж харан, сайн, муу аль ч үед итгэлтэйгээр тэвчихэд мөн Христтэй адилаар бусдын зовлонг ойлгон, өргөмжлөлд хүргэх гэрээнүүдийг сахихад уриалж байна. ■

ЭШЛЭЛҮҮД


1. Жишээнд Нифай (1 Нифай 17:23–43), Хаан Бенжамин (Мозая 1), Лимхай (Мозая 7), Алмад хандсан тэнгэр элч (Мозая 27), Алма (Алма 9:10), Мормон (Мормон 3:17–22), Мосе нар (Египетээс гарсан нь 13:3) орсон болно.
2. Joseph Smith, in “History, circa Summer 1832,” 2, josephsmithpapers.org.
3. “History, 1838–1856, volume A-1 [23 December 1805–30 August 1834],” 3, josephsmithpapers.org-ийг үзнэ үү.
4. “Revelation, 12 January 1838–C,” [1], josephsmithpapers.org-ийг үзнэ үү.
5. *Saints*, volume 1, chapter 30, “Fight Like Angels”-ийг үзнэ үү.
6. “Letter to Presendia Huntington Buell, 15 March 1839,” [1], josephsmithpapers.org.

ӨНДӨГ, ГАЛ ХАМГААЛАГЧ, ИТГЭЛ

Гэр бүлийн маань зорилгуудын нэг бол өөрсдийн гэсэн гэр оронтой болохын тулд урьдчилгаа төлбөрийг хийх хангалттай мөнгө хуримтлуулах явдал байлаа. Тэр зорилго байгаагүйсэн бол би амралтын өдрүүдийг зурагт үзэн өнгөрүүлж, санхүүгийн боломж өөрөө хүрч ирэхийг хүлээн суух байсан.

Чилийн хойд хэсэгт байрладаг уул уурхайн компанийн жолоочийн хувьд би гэрээсээ хол дөрвөн өдрийг уурхайд өнгөрүүлээд, үлдсэн гурван өдрийг буюу бямбаас даваа гаргийг гэртээ өнгөрүүлдэг. Байр худалдаж авахаар орлого болон хадгаламжаа нэмэгдүүлэхийн тулд би өндөг зарж эхлэхээр шийдэв. Бид найз нөхөд, хөрш, Сүмийн гишүүдээс захиаалга авч, долоо хоног тутам 1000 орчим өндөг бөөний үнээр худалдан авч, бямба, даваа гаргуудад өндгийг хүргэж өгөхөөр төлөвлөж байв.

Би эхнэр Лаура болон хоёр хүүхэдтэйгээ хамт хүргэлт хийж, цагийг хамтдаа сайхан өнгөрүүлэхээр шийдлээ. Биднийг анхныхаа багц өндгийг авахаар явах замд том асуудал гарав. Нэг хүүхэд маань харандааны жижигхэн төмөр үзүүрлэгчээр тоглож байгаад, үзүүрлэгчээ шидэхэд тэр нь машины тамхины асаагуур дээр унах нь тэр. Оч үсчин, фургон машины маань бүх цахилгаан хүч алдагдаж,



Харандааны жижигхэн төмөр үзүүрлэгч машины тамхины асаагуур дээр унахад машин маань гэнэт зогсов. Бид гал хамгаалагчаа шатаасан байлаа.

хурдны зам дээр гэнэт зогсов. Бид гал хамгаалагчаа шатаасан байлаа.

Замын хөдөлгөөнд саад болж, юу хийхээ мэдэхгүй сууж байхдаа бид сэтгэлээр унаж, уйлмаар санагдаж байв. Тэр үед би, хэрэв бид Бурханд итгэх юм бол Тэрээр биднийг өргөн дэмжиж, тусална гэсэн амлалтыг саналаа. Сэтгэл минь тайвширч, тэнд гомдоллон зүгээр суух хэрэггүй

юм байна гэдгээ би ухаарсан юм. Бидэнд асуудал гарсан бөгөөд Бурханы тусламжтайгаар шийдвэрлэх хэрэгтэй байлаа.

Лаура бид хоёр бие бие рүүгээ хараад, “Итгэлээ харуулах хэрэгтэй” хэмээн хэлэв. Бид ч залбираад, нулимсаа арчлаа. Дараа нь Лаура машиныг асааж, би араас нь түлхэхээр гарлаа. Хэдэн хүн машинаасаа гарч ирээд надад туслав.

Бид ч машиныг ойролцоогоор 200 метр газар түлхэн, хурдны замын зогсоол дээр аюулгүй газар оллоо. Машин зогсоол дээр хүрч ирэхэд машины стерео хөгжмийн дэлгүүрийн өмнө ирснээ олж харлаа.

Би ч шатсан гал хамгаалагчаа олоод, дэлгүүрт орж, “Танайд энэ байна уу?” гэж асуув.

Худалдагч “Байлгүй яахав” гэж хариуллаа.

Би гал хамгаалагч худалдан авч, үүнийгээ сольж хийхэд машин дорхноо асаж, бид цааш явсан юм. Биднийг ирэхэд өндөгний бөөний төв яг хааж байлаа. Бид өндгөө худалдан аваад, хүргэж өгч чадсан юм.

Бидэнд саад бэрхшээл тулгарах үед Тэнгэрлэг Эцэгээс тусламж хүсэхээ бүү март. Биднийг урагшилж, Түүнд итгэлээ харуулах юм бол Тэрээр бидэнд хариулна гэдгийг би мэднэ. ■

Алваро Алкайно, Чили, Антофагаста

ЭЭЖИЙН МААНЬ ГАРААР БИЧИГДСЭН АДИСЛАЛ

Нэг орой би удахгүй болох тойргийн чуулган дээр ямар захиас өгөхөө бодож суулаа. Би судраа долоо хоногийн туршид судалж, олон удирдамж, ойлголтыг хүлээн авсан ч Их Эзэн гадасны ерөнхийлөгчийн хувиар намайг тойргийнхоо гишүүдтэй юу хуваалцахыг хүсэж байгаа талаар тодорхой удирдамж хүлээн аваагүй л байлаа.

Би бодол санааг маань удирдан залах Сүнсний удирдамжийн төлөө чин сэтгэлээсээ залбирсан юм. Дараа нь би судраа нээгээд дахин уншиж эхэллээ. Миний бодол санаанд бишоптой саяхан ярилцсан тойргийн зорилтууд шууд орж ирэв. Эдгээр зорилгын нэг нь сайн мэдээг найз нөхөд, хөршүүдтэйгээ хуваалцахдаа *Миний сайн мэдээг номло* товхимлыг ашиглах явдал байлаа.

Надад тэр орой судраас судлах үед *Миний сайн мэдээг номло* товхимлыг оруулах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрөв. Би нэг хувийг гаргаж ирээд, тодорхой хуудас гэлгүй нээлээ. Уг хуудсан дээрээс би 1 Нифай 8:8–11 болон 1 Нифай 11:21–22-ыг гараар бичсэн хоёр гар бичмэл олсон юм. Ойртуулан харвал, тэдгээр эшлэлийг ээж минь гараараа бичсэн болохыг анзаарав. Сайхан ээж минь хэдэн жилийн өмнө, 80 насны сүүдэр зооглосноосоо хоёрхон сарын дараа насан

эцэслэсэн билээ. Тэр эр зориг гарган, амин хувиа үл хичээн үйлчлэх, бусдын зөвхөн сайн талыг харахын үлгэр дуурайл байсан юм. Тэр бас судруудад хайртай байсан.

Эдгээр эшлэлийг бичиж тэмдэглэхэд түүнд юу нөлөөлснийг олж мэдэхээр би судруудаа нээв. Би эдгээрийг уншиж байхдаа оюун санаандаа ямар захиас өгөх ёстойгоо шууд ойлгосон юм. Энэ нь сайн мэдээний амтат үр жимснээс хүртсэн Сүмийн гишүүд заримдаа яг тэр жимсийг нь өөр хүмүүс эрэлхийлж байгаа гэдгийг мартдаг тухай энгийн захиас байв. Бид тэдэнд хүрч, үүнийг хаанаас олж болохыг хэлэх хэрэгтэй.

Тойргийн чуулганд бэлдэхээр *Миний сайн мэдээг номло* товхимлыг нээхдээ ээжийнхээ гараараа бичсэн эшлэлтэй хуудсыг нээв.

Би *Миний сайн мэдээг номло* товхимлын үлдсэн хэсэгтэй танилцаж байхдаа хайрт ээжийгээ бодсон. Уг номон дээр түүнийх гэдгийг нь тодорхойлох ямар ч нэр, тэмдэглэл болон өөр ямар нэг зүйл байсангүй. Намайг энэ мөчийг хүртэл хөтөлсөн сүнслэг өдөөлтүүдийн талаар би бодон, гайхаж суулаа. Сүнс миний бодол санаа залбирч байсны минь дагуу чиглүүлэгдсэнийг надад баталсан юм. Олон жилийн өмнө ээж минь эдгээр эшлэлийг бичиж байхдаа Их Эзэн эдгээрийг хүүгийнх нь даруухан залбиралд хариулахдаа ашиглана гэдгийг мэдээгүй. ■
Даглас Хэжэр, АНУ, Невада



КИЕВ ДЭХ ИХ ЭЗЭНИЙ ӨРГӨӨНД БОЛСОН ГАЙХАМШИГ

Би гэр бүлийнхэнтэйгээ 2010 оны 10-р сард Румынээс Украины Киев хүртэл машинаар аялж, ариун сүмийг онцгойлон адислах ёслолд оролцох гэж байгаадаа баяртай байлаа. Энэ нь Румын, Молдавын номлол дахь гэгээнтнүүдэд зориулагдсан гэдгийг мэдэж байсан ч бид тэнд очихын тулд 14 орчим цаг зарцуулсан юм. Бид ирээд, Румынээс ирсэн өөр нэг бүлгийнхэнтэй уулзав. Бид энэ ариун нандин үйл явдалд оролцохоор Киевт байгаадаа баяртай байлаа.

Онцгойлон адислах ёслолын өдөр Румынээс ирсэн манай бүлгийнхнийг ариун сүмийн доод давхрын өрөөнөөс ёслолын шууд дамжуулалтыг үзэхээр хуваарилсан юм. Заримынх нь урам хугарч эхлэв. Тэд селестиел өрөөнд бошиглогчтой хамт онцгойлон адислах ёслолд оролцоно гэж найдаж байв. Бүр зарим нь гэрээсээ, Румын дэх цуглааны байрнаасаа шууд нэвтрүүлэг үзэж болох байсан гэж хэллээ.

Би дотроо “Тэнгэрлэг Эцэг минь, бид Румынээс ирсэн эдгээр гишүүнд хэрхэн мартагдашгүй дурсамж үлдээж болох вэ?” гэж залбирч эхлэв.

Онцгойлон адислах ёслол эхлэхэд би хариултаа аваагүй л байв. Удалгүй бид ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) булангийн чулууг тавихаар доош бууж ирнэ гэдгийг олж мэдлээ. Магадгүй энэ нь бидний хариулт байж болох байв! Би бошиглогчийг ямар нэгэн арга



замаар ирж, Румыний гэгээнтнүүдтэй уулзаасай хэмээн залбирсан юм.

“Би үүнийг өөрийнхөө төлөө биш, ах эгч нарынхаа төлөө гуйж байна” хэмээн би залбирсан.

Булангийн чулуу тавих ёслолын дараа ерөнхийлөгч Монсон селестил өрөө рүү явах замдаа манай өрөөний хажуугаар өнгөрөв. Гэнэт надад тэнд зогсоод, манай өрөөнд орж ирэхийг урих хэрэгтэй гэсэн мэдрэмж төрлөө.

Би зогсоод, “Бошиглогч оо! Бидэнтэй уулзаач. Бид Румынээс ирсэн” гэж хэлэв.

Тэр намайг сонссонгүй бололтой. Харин хэсэг хугацааны дараа тэр эргэн ирээд, “Румын” гэсээр өрөөнд орж ирлээ.

Тэр бидэнтэй мэндлээд, бидэнд маш их хайртай гэдгээ хэллээ. Би гишүүдийнхээ царайг хараад сэтгэл

Би дотроо “Тэнгэрлэг Эцэг минь, бид Румынээс ирсэн эдгээр гишүүнд хэрхэн мартагдашгүй дурсамж үлдээж болох вэ?” гэж залбирч эхлэв.

хангалуун байв. Би “Эцэг минь таны өргөөнд болсон энэ гайхамшигт баярлалаа” гэж залбирсан юм.

Бошиглогчийг өрөөнөөс гарахад бүгд аз жаргалтай байв. Манай өрөө ариун сүмийн хамгийн адислагдсан өрөө гэж бид бодож билээ. Би энэ үйл явдлыг хэзээ ч мартахгүй. ■
Дору Вазил, Румын, Бухарест

САЙШААСАН ИНЭЭМСЭГЛЭЛ

Нэг орой манай тойргийнхон олон цаг бэлдсэн үйл ажиллагаагаа зохион байгуулсан юм. Үйл ажиллагааны дараа нэг залуухан сонирхогч надтай салах ёс хийснийхээ дараа эргэж ирээд, “Би хэзээ эргэж ирж болох вэ?” гэж асуулаа. Намайг түүнд ням гарагт гэж хэлэхэд, тэр хүү “Үгүй ээ, өөр үйл ажиллагаа байхгүй юм уу?” гэж асуув. Тэрээр тойргийн өсвөр үеийнхэнтэй цагийг маш сайхан өнгөрүүлсэн тул дахин ирэхийг хүссэн байлаа.

Би бас үйл ажиллагаан дээр гаднаас ирсэн нэгэн хостой яриа өрнүүлж, бодол санааг нь асуув. Нөхөр нь “Бид энд ирснээс хойш тайвшрал, амар амгаланг мэдрэч байна” гэхэд эхнэр нь толгойгоо дохин батлав. Энэ бол гайхалтай зүйл байв. Яагаад гэвэл, тэд анх ирснээсээ хойш хүмүүсийн яриа хөөрөө, бөөн шуугиан дунд байсан. Гэтэл тэр над руу хараад, цааш үргэлжлүүлэн, “Энэ Ариун Сүнс, тийм үү?” гэж асуув. Гайхсандаа би “тийм” гэж хариуллаа.

Энэ үйл ажиллагаанд бэлдэхийн тулд маш олон зүйл хийсэн тул би

тэр оройн бүх зүйлээ хийж дуусгаад, хурдхан шиг гэртээ харьж, орондоо орохыг хүсэж байв. Их ядарсан байсан болохоор сонирхогчидтой өрнүүлсэн ярианыхаа талаар тийм ч сайн бодсонгүй. Би гэртээ ирээд, залбирч, орондоо орсон ч унтаж чадсангүй. Их Эзэний инээмсэглэж байгаа дүр төрх санаанаас гарахгүй байв. Энэ бол хүлээн зөвшөөрч байгааг илтгэсэн инээмсэглэл байлаа. Яг тэр мөчид би үйл ажиллагааны үеэр болж өнгөрсөн сайхан үйл явдлуудыг эргэн санаав.

Тойргийн гишүүдийн хичээл зүтгэл, хайр энэрэл тэр гурван сонирхогчийн зүрх сэтгэлийг хөндсөн байв. Энэ нь бидний хийсэн зүйлийг сайшаасан инээмсэглэл болохыг би ойлгосон. Би нулимс дуслуулахгүй байж чадаагүй бөгөөд Их Эзэний бидэнд өгсөн бэлэгт ихэд талархсан билээ. Тэр биднийг сайшаан инээмсэглэж байв. Их Эзэний үгс үнэн бөгөөд зөвхөн нэг бодгалийг түүнд авчрах аваас, Эцэгийн хаант улсад бидний баяр хөөр хэчнээн агуу байх болно гэдгийг би гэрчилж байна (С ба Г 18:15). ■

Франклин Ромэро, Эквадор, Манаби

ТҮҮХЭЭ ХУВААЛЦ

Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой буланд сайн мэдээний ямар ч сэдвэстэй холбоотой бодит түүхийг хэвлэдэг ч бусдад тохинуулж, сайн мэдээний дагуу урам зоригтой амьдарч байгаа та нарын туршлага бидэнд онцгой хэрэгтэй байна. Та нар бидэн рүү liahona.lds.org вэбсайтаар түүхээ илгээнэ үү (“Submit an Article or Feedback” дээр дар).



“Хэцүү үгс” үргэлж байсаар байна. Гэхдээ эргэлзээ, тодорхой бус байдлын оронд итгэлийг сонгох сонголт үргэлж байх болно.

САЙН МЭДЭЭНИЙ ДАГУУ АМЬДРАХ БИДНИЙ СЭДЭЛ

Минди Сэлү

Сүмийн сэтгүүлүүд

Шавь байх зам нь “харагдах ба үл харагдах”¹ адислалуудаар дүүрэн байдаг. Энэ замаар явбал адислагдах нь тодорхой байдаг ч үргэлж амар хялбар, тааламжтай байдаггүй. Есүс Христийн шавь болохын тулд хөдөлмөрлөж, золиослол хийх шаардлагатай бөгөөд заримдаа зарлигуудын дагуу амьдарч, эдгээр золиослолыг гаргах сэдлийг олох амаргүй байдаг.

Залуу хүний хувьд та нар шинэ үүрэг хариуцлагуудаа хооронд нь зохицуулан, амьдралаа өөрчлөх шийдвэр гаргаж, үлдсэн амьдралынхаа туршид шавь байх өөрийн гэсэн замаа олох гээд завгүй байгаа байх. Үүнээс гадна та нарт Сүмийн бодлого, түүх болон сайн мэдээний сургаалын хувьд сайн ойлгодоггүй зүйлс, тэмцэлддэг уруу таталтуудаас гадна өнөөг хүртэл хүсэн хүлээж буй адислал, Бурханы танд зориулсан төлөвлөгөөний талаар асуулт байж болно.

Бидний зарим нь амлагдсан адислалуудыг авахын тулд сайн мэдээний дагуу амьдрах нь хэрэгтэй ч юм уу үгүй ч юм уу гэж боддог. Бид нийцэхгүй, хэт их ажиллагаатай эсвэл хариултын оронд асуулт их байна гэж маргаж болох юм. Гэхдээ үнэндээ бүх зүйл сэдлээс шалтгаална. Та нар яагаад хийж байгаа зүйлээ хийж, амьдарч байгаа хэв маягаараа амьдардаг вэ? Та яагаад эргэн тойрныхон чинь анзаарахгүй байсан ч зарлигуудыг дагасаар байдаг вэ?

Таны хэн болох мөн та амьдралынхаа аль шатанд явж байгаагаас үл хамааран, Аврагчид болон Түүний сайн мэдээнд итгэх итгэлээ хөгжүүлэн, өөрийн гэсэн сэдлийг олж авах сонголт зөвхөн таных юм.



Бид хэнд хандах ёстой вэ?

Сайн мэдээний дагуу амьдрах сэдлийг олж, авч үлдэх нь өнөө үед өвөрмөц сорилт бэрхшээл байхаа больжээ. Аврагчийг дэлхий дээр байх үед ч гэсэн хүмүүст Түүний заасан зарчмуудыг ойлгож, улмаар дагахад хэцүү байсан. Түүнийг “амийн талх[ын]” (Иохан 6:35–58-ыг үзнэ үү) хувьд Өөрийн гүйцэтгэдэг үүрэг буюу ойлголтыг тайлбарлахыг сонсоод хэдэн шавь нь таалсангүй. Тэд “Энэ чинь хэцүү үг байна. Үүнийг хэн сонсож чадах вэ?” (Иохан 6:60) гэгцгээн эргэлзсээр хариулжээ.

Тэд энэ сургаалд итгэж, хүлээн авахгүй байгааг Христ хараад, “Энэ нь та нарыг бүдрүүлчихэв үү?” (Иохан 6:61) хэмээн асуув. Итгэхийн оронд эргэлзсэн учраас Түүний дагалдагчдаас олон хүн “зайлан явж, цаашид Түүнтэй хамт явсангүй” (Иохан 6:66).

Харин Христ үлдсэн шавь нараасаа “явахыг хүсэж байна уу?” гэхэд Петр Түүнд “Эзэн, бид хэн уруу явах юм бэ?” (Иохан 6:67–68) гэж боломжтой цорын ганц хариултыг өгчээ.

Бидний сэдлийн эх үүсвэр

Петр сэдлийнх нь эх сурвалж хэн гэдгийг мэдэж байсан. Энэ нь сайн мэдээг дагахын тулд бид хийдэг зүйлсээ яагаад хийдгийн үндсэн шалтгаан буюу бидний Есүс Христийн талаарх гэрчлэл, Түүнд итгэх итгэл юм. “Та

бол Бурханы Ариун Нэгэн мөн гэдэгт бид итгэцгээсэн, мөн таньж мэдэцгээсэн”

(Иохан 6:69; онцлон тэмдэглэл нэмэгдсэн) хэмээн Петр тунхагласан. Бид Есүс Христ, Түүний бурханлаг зан чанар, үйл хэргийн талаар үүний адил бат бөх итгэлтэй болсноор хүнд хэцүү, хэн ч анзаарч харахгүй үед, бүр юу хийхээ мэдэхгүй байхдаа ч гэсэн сайн мэдээний дагуу үргэлжлүүлэн амьдрах сэдлийг олж авах боломжтой.

“Хэцүү үгс” үргэлж байсаар байна. Гэхдээ эргэлзээ, тодорхой бус байдлын оронд итгэлийг сонгох сонголт үргэлж байх болно. Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Л.Витни Клэйтон: “Итгэх шийдвэр нь бидний хийдэг хамгийн чухал сонголт юм”² хэмээн хэлсэн.

Хэрэв бид тэрхүү “хэцүү үгс” хэмээн хэлсэн хүмүүсээс өөр бодолтой бол юу хийх вэ?

1. Хэдийгээр “орхин яв[ах]” амархан ч итгэлтэй хэвээр үлдсэн Петр болон бусад шавийн үлгэр жишээг дага. Бошиглогч, төлөөлөгч, удирдагчдын зөвлөгөөг сонс.

“Айдаст автаж, эргэлзээнд идүүлж эсвэл хүнд хүчир цаг үетэй тулгарахдаа олж авсан итгэлээ бүү алд. Тэр итгэл тань хэчнээн хязгаарлагдмал бага байсан ч хамаагүй. . . . Олж авсан итгэлээсээ зууран, илүү их мэдлэг иртэл тэвчээртэй байцгаа.”³

“Итгэлээр урагшаа нэг энгийн алхам, дараа нь дахиад нэг алхам хий. . . . Тэрээр итгэдэг байсан үнэнүүддээ анхаарлаа төвлөрүүлж чадсан ба тэдгээр үнэнээр оюун ухаан, зүрх сэтгэлээ дүүргэ. . . .

. . . Сайн мэдээний энгийн үнэнээс эхэл.”⁴



2. Судруудад ойр байж, сургаалыг нь дага.

“Мормоны Номыг өдөр бүр залбиран судалж, тунгаан бод.”⁵

“Хэрэв хэн нэгэн Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ” (Иохан 7:17).

“Зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бологтун” (Иаков 1:22).

3. Зарлигуудыг үргэлжлүүлэн сахь.

“Хичээнгүйлэн эрэлхийлж, зарлигуудын дагуу амьдрах үед бидний чин сэтгэлийн асуултуудын хариулт ирдэг. . . . Бидний итгэл учир зүйн хувьд ойлгогдохгүй байгаа зүйлсэд итгэхэд маань тусалдаг.”⁶

“Та нар үргэлжлүүлэн дуулгавартай байснаар, . . . эрэлхийлж буй мэдлэг, ойлголтоо олж авах болно.”⁷

Эцэст нь Петрийн хэлсэн зүйл бидний сэдлийн үндэс суурь юм. Есүс бол Христ бөгөөд Тэрээр Өөрийн Сүмийг удирддаг мөн мөнх амьдралын үгс Түүнд байдаг гэдэгт бид итгэдэг үү? Түүнд итгэх итгэл яг одоо ойлгохгүй байгаа “хэцүү үгсээс” илүү байх ёсгүй гэж үү?

Сайн мэдээний дагуу амьдрахын ашиг тус

Бид Бурхан болон Есүс Христийг дагаж, бүрэн ойлгохгүй байсан ч зарлигуудыг сахих юм бол хэмжээлшгүй их адислалыг хүлээн авах болно. Эгэл хүн “Энэ нь надад ямар ашигтай вэ?” гэж асуудаг. Сайн мэдээний сургаалууд “энэ дэлхийд амар амгаланг хийгээд ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авна,” Бурханы эзэмшилд танд бэлдсэн байр бий; Тэнгэрлэг Эцэгт байгаа бүхэн танд өгөгдөнө; “хэзээ ч төгсөшгүй аз жаргалын

байдалд оршиж бол[но]" (С ба Г 59:23; Ифер 12:34; С ба Г 84:38; Мозая 2:41) болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорфын хэлснээр "Эндээс [Сүмээс] та үнэлж боломгүй үнэ цэнтэй зүйлээ олох болно. . . . Та эндээс мөнх амийн үгс, адислагдсан гэтэлгэлийн амлалт, амар амгалан болон аз жаргалд хүрэх замыг олох болно."⁸ Тэдгээрээс цөөн хэдийг нэрлэе.

Христийг дагаж, Түүний зарлигуудыг сахихад өөрийгөө зориулах үед биднийг дээр дурдсанаас гадна өөр олон зүйлийг хүртэх болно хэмээн амласан байдаг. Энэ нь уг зам үргэлж амархан буюу ойлгомжтой байна гэсэн үг биш ч, гуйвшгүй байснаар хүлээн авна хэмээн амлагдсан адислалууд амьдралын маань туршид болон бүр дараа нь ч өгөгдсөөр байх болно.

Хэдийгээр эдгээр адислал гайхамшигтай хэдий ч сайн мэдээний дагуу амьдрах бидний гол сэдэл болох ёсгүй. Танд ямар асуулт байгаа мөн аль сургаалыг ойлгохгүй байгаагаас үл хамааран Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх итгэл тань Петр болон бусдын хувьд байсны адил сайн мэдээний дагуу амьдрах сэдлийн тань түлхүүр байх болно.

Ахлагч Угдорф "Бидний сэдэл, бодол санаа эцсийн эцэст үйлдэлд маань нөлөөлнө. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний үнэнүүдийн талаарх гэрчлэл амьдралын маань хамгийн хүчирхэг сэдэл юм. Их Эзэн өөрт нь үйлчлэхийг хүссэн хүмүүст хандан 'Санаа бодол

болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай' (С ба Г 6:36) хэмээн дахин дахин хэлсэн юм.

Есүс Христ болон сэргээгдсэн сайн мэдээний талаарх гэрчлэл Бурханы бидэнд тусгайлан зориулсан төлөвлөгөөний талаар олж мэдэн, үүний дагуу үйлдэхэд тусална. Энэ нь бидэнд Бурханы бодит байдал, үнэн болон нинжин сэтгэлийг мөн Есүс Христийн сургаал, Цагаатгал, хожмын үеийн бошиглогчдын бурханлаг дуудлагыг баталдаг."⁹

Миний хувьд хэцүү байсан ч би үргэлжлүүлэн хичээнэ. Би залбирч, судраа судалсаар байх болно. Би бас өдөр бүр Аврагчийн тухай гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд хичээл зүтгэл гаргана. Мөн Түүний хүссэний дагуу амьдарч, Түүний болон амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгс хэрхэн амьдрахыг заана гэдэгт итгэж, зөвхөн миний итгэлээс биш, харин Түүний мөнхийн золиослол болон намайг гэх хайраас урган гардаг сэдэлд найдсаар байх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Дийтр Ф.Угдорф, "Шавь болох зам," 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 75.
2. А.Витни Клэйтон, "Итгэхийг сонго," 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 20.
3. Жэффри Р.Холланд, "Эзэн минь, би итгэж байна," 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 108; онцлон тэмдэглэлт эх хувь дээр байгаа.
4. Рөүзмэри М.Виксом, "Итгэлээ сэргээх нь," 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 80.
5. Томас С.Монсон, "Мормоны Номын хүч," 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 73.
6. Рөүзмэри М.Виксом, "Итгэлээ сэргээх нь," 80.
7. Рассэлл М.Нэлсон, "Сүмд зориулсан мөн бидний амьдралд зориулсан иачлэлт," 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган.
8. Дийтр Ф.Угдорф, "Ирж, бидэнтэй нэгд," 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 23.
9. Dieter F. Uchtdorf, "The Power of a Personal Testimony," *Liahona*, Nov. 2006, 37.



ХОЁР СОНГОЛТ

"Их Эзэний зам хэцүү биш. Сайн мэдээ ч хэцүү биш, харин амьдрал хэцүү. . . . Бидний хувьд амьдрал хүнд хэцүү ч эгэл жирийн юм. Бидэнд ердөө хоёрхон сонголт байдаг. Нэг бол Их Эзэнийг дагаж, Түүний хүчийг хүлээж аван, амар амгалан, гэрэл, хүч чадал, мэдлэг, итгэл найдвар, удирдамж, хайр энэрэл, баяр баясгалантай байж болно. Харин өөр ямар ч замаар явсан ганцаараа, Түүний дэмжлэг, хүч, удирдамж чиглүүлэггүйгээр харанхуй дотор гай зовлон, эргэлзээ тээнэгэлзээ, цөхрөл гутралын замаар явна. Аль замаар нь явбал илүү хялбар вэ? гэж би асууя."

Ахлагч Лорэнс И.Корбриж, "Зам," 2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 44.

**Миний амьдрал
харанхуйд автаж
байгааг би мэд-
рэв. Дараа нь би
бишоптойгоо
ярих хэрэгтэй
юм байна гэдгээ
ухаарлаа.**

Наманчлалд хөтлөх анхны алхам

Аурилас Петерсон

Би номлогчидтой баптисм хүртэх өдрөө товлосноо санаж байна. Тэд надаас Тэнгэрлэг Эцэгтэйгээ энэ гэрээг байгуулахад бэлэн байна уу гэж асууж билээ. Би энэ талаар юу ч бодолгүйгээр шууд л “Бэлэн” гэж баяртай нь аргагүй хариулсан юм. Би хайраар дүүрэн Эцэгийнхээ надад өгсөн онцгой бэлгийг хүлээн авахыг хүссэн ба Аврагчгүйгээр миний амьдрал тийм ч аз жаргалтай байхгүй гэдгийг мэдэж байв. Гэхдээ ирээдүйд надад ямар байхыг би үнэндээ мэдэхгүй байлаа.

Эцэст нь тэмдэглэлт өдөр ирлээ. Тэр өдөр мартагдашгүй сайхан байсан ба би маш их аз жаргалтай байв.

Харанхуй өдрүүд

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулсны дараа надад гэнэт өдөр хоног харанхуй болсон мэт санагдах болов. Гэр бүлд маань асуудал гарч, Бурханы бүх хуулийг дагаж чадахгүй байлаа. Би юу хийхээ мэдэхгүй байсан ба бүх зүйлд бууж өгөхийг хүсэж байв. Хэн ч намайг ойлгохгүй байгаа мэт санагдаж байлаа.

Би үргэлж Мормоны Номыг унших дуртай байсан ч тэр үед уншихаа больсон байв. Нэг өдөр гэртээ ганцаараа байхдаа Мормоны

Номыг унш гэсэн Сүнсний нөлөөг мэдэрсэн юм. Би өмнөхөн нь зовлон шаналлаас салган, амар амгаланг авчрах хариултыг олохыг хүсэн залбирсан байлаа. Би Алмагийн 5-р бүлгийг шууд гаргав. 27-р шүлэгт “Та нар Бурханы өмнө өөрсдийгөө өөсэвгүй байлган, алхалсан уу? Хэрэв та нар энэ цагт үхэхээр дуудагдвал, та нар хангалттай даруухан байсан хэмээн өөрсдөдөө хэлж чадахсан болов уу? Өөрийн хүмүүсийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирэх Христийн цусаар өмсгөлүүд тань цэвэршигдэж, цагаан болгогдсон гэх үү?” гэсэн байлаа.

Эцэст нь энэ үгс миний сэтгэлийг хөндөв. Би наманчлах хэрэгтэй гэдгээ мэдэж байсан ба бишоптойгоо уулзахаар цаг авлаа. Би үнэхээр их айж байсан ч өөрийгөө хүчлэн очиж, түүнтэй уулзсан юм.

Бурханы амлалтыг ойлгох нь

Бишопын өрөөнд орж ирэхэд надад гэм буруутай гэсэн мэдрэмж төрж, эргээд явчихмаар санагдаж билээ. Гэхдээ би хэлэх хэрэгтэй бүхнээ хэлэх зүрх зориг өгөхийг хүсэн залбирсан юм. Бишоп намайг өрөөндөө орохыг уриад, дараа нь Бурханы тусламжийг хүлээн авахыг хүсэж залбирав. Тэр надтай хүүтэйгээ ярьж байгаа мэт

харьцаж, намайг хайрлаж байгаа нь хэлсэн үгээс нь мэдрэгдэж байлаа. Тэр надад зөвлөгөө өгч, Бурханы өршөөлийг хүлээн авахын тулд тодорхой зүйлс хийхийг, дараа нь өөртэй нь дахин уулзахыг хүсэв.

Надад ийм боломж олдсонд би маш их баярласан. Би түүний зөвлөгөөг дагаж, эцэст нь Их Эзэний: “Миний эсрэг зөрчил үйлдэх хэнийг боловч, мөн хэрэв тэр чиний өмнө мөн миний өмнө нүглүүдээ тоочиж, мөн чин зүрхнийхээ угаас наманчлах аваас, түүнийг та нар уучлах болно; мөн түүнчлэн би түүнийг өршөөх болно” (Мозая 26:29) хэмээн

Алмад өгсөн өршөөлийн амлалтыг ойлгосон юм. Чин сэтгэлээсээ наманчилсны дараа Бурхан намайг уучилсан гэдгийг би мэдэж байсан. Эцэст нь би Тэнгэрлэг Эцэгийн хайрыг зүрх сэтгэлдээ мэдэрч, харанхуй замхран алга болсон билээ. Би аз жаргалаар дүүрч, өөрөө өөрөөрөө бахархаж байсан юм.

Бишоп танд туслахад бэлэн байдаг

Бишоп бол тойрогт Их Эзэнийг төлөөлж байдаг хүн юм. Тэр Бурханы танд зориулан бэлдсэн жинхэнэ аз жаргалыг олоход тань туслахад

бэлэн байдаг. Түүнд итгэж найд. Хэрэв танд асуудал байгаа эсвэл наманчлах хэрэгтэй бол явж түүнийг ол. Тэрээр чамд туслах болно.

Заримдаа түүнтэй очиж уулзахад хэцүү байдаг. Гэхдээ ерөнхийлөгч Лорензо Снөүгийн (1814–1901) Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн төлөвлөгөөг тайлбарласнаар: “Сүнсний дэлхийд [мөнх бус амьдралын өмнөх дэлхийд] бидэнд ... одоо олж авч байгаа туршлагыг авахаар ирэхийг санал болгоход бүх зүйл таатай байсан, таалагдсан гэж бодохгүй байна. ... Гэсэн хэдий ч бид тэнд байхдаа өргөмжлөгдөн, алдар сууд хүрэхийн тулд энэ бүх туршлагыг хуримтлуулах шаардлагатай байсан гэдгээ тод томруун харж, ойлгож байсан гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна. Тэр цааш нь: “Бид Бурханы хүслийг дагахыг хүсэж байсан тул энд байгаа билээ” гэж хэлсэн билээ (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2012], 110).

Наманчлал нь Бурханы хүслийг дагаж буйн нэгэн хэсэг юм. Тиймээс бишопоосоо айж эмээхийн оронд түүнийг найзаа болго. Бурхан түүнийг сонгосон бөгөөд тэр танд наманчлахад төдийгүй Есүс Христэд ирэхэд туслах замаар бодгалийг тань илааршуулна. Их Эзэн бидэнд туслахыг хүсдэг ч бид эхлээд наманчлах эхний алхмаа хийсэн байх хэрэгтэй. Ийнхүү бид Исаиа 1:18 дээрх “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно” гэсэн амлалт биелэхийг харах боломжтой. Мөн энэ зорилгоор бишоп танд туслахад бэлэн байдаг.

Бурхан амьд бөгөөд Есүс Христ бидний Аврагч гэдгийг би гэрчилж байна. Тэр хоёр хоёулаа бидэнд маш их хайртай! ■

Зохиогч нь Гайти Кюест амьдардаг.



ИХ ЭЗЭНИЙ АРГА ЗАМААР СУРАЛЦАХ НЬ



Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулга
Ахлагч
Дэвид А.Бэднар

Их Эзэн Өөрийн ажлыг яаравч-
луулж байгаа тул биднээс үргэлж
суралцаж, өөрчлөгдөж, Аврагчид
итгэх итгэлээр урагш тэмүүлэхийг
шаарддаг.

Бүх зүйлд загвар өгнө

1831 оны 6-р сард Их Эзэний бошиглогч Иосеф Смитээр дамжуулан өгсөн илчлэлтэд: “Мөн дахин, та нар мэхлэгдэхгүй байж болохын тулд бибээр та нарт бүх зүйлд загвар өгнө; учир нь Сатан уг нутагт тархсан байна, мөн тэрээр үндэстнүүдийг мэхлэхээр урагш одох ажгуу” (С ба Г 52:14) хэмээн тунхагласан.

Сонирхолтой нь, Их Эзэн бидэнд бүх зүйлд зориулан “нэг” биш “олон” загвар өгчээ. Их Эзэн “бүх зүйлд загвар” хэмээн хэлснээр нөхцөл байдал бүрд хэрэглэж болох ганцхан загварыг санал болгосон гэдэгт би итгэдэггүй. Харин өөр өөр

сүнслэг зорилгод хүрэхийн тулд ашиглаж болох олон янзын загвар Их Эзэний арга замд ордог гэдэгт итгэдэг.

Аль ч суралцаж, заах туршлагын эцсийн зорилго бол бидний хэрэгцээ шаардлагад хамгийн сайн нийцсэн, хүссэн суралцах үр дүнд маань хүрэхэд туслах загваруудын загварыг олж тодорхойлон, ашиглах явдал байх ёстой.

Ариун Сүнс бол багш мөн

Ариун Сүнс нь Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн, Илчлэгч, Багш, Тайтгаруулагч, Ариусгагч бөгөөд бүгдийг сануулах болно (Иохан 14:16–17, 26; 3 Нифай 27:20-ийг үзнэ үү). Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэймс Э.Талмэйж (1862–1933) “Ариун Сүнсний хүмүүний дунд гүйцэтгэх үүргийн талаар сударт дурдсан байдаг. Тэр бол Эцэгийн илгээсэн багш бөгөөд төлөөсийг нь төлсөн

Ариун Сүнсийг багш болгон
урих нь Их Эзэний бүх суралцах
загварын гол зорилго юм.



ИТГЭЛЭЭР СУРАЛЦАХАД ЗҮРХ СЭТГЭЛ ХИЙГЭЭД ЭРМЭЛЗЭГЧ ОЮУ- НЫ АЛЬ АЛИНЫГ НЬ ШААРДДАГ.



хүмүүстээ Тэрээр бодгалийн хөгжил дэвшилд шаардлагатай бүгдийг илчлэх болно.”¹ Ариун Сүнснийг *тийнхүү* багш байхаар урих явдал нь Их Эзэний бүх суралцаж, заах загварын гол зорилго юм.

Ёс суртахууны сонгох эрх чөлөөгөө ашиглаж, зөв зарчмуудын дагуу үйлддэг суралцагч нь өөрийн зүрх сэтгэлийг Ариун Сүнсэнд нээснээр Түүний заагч, гэрчлэгч хүч, батлагч гэрчийг урьдаг. Итгэлтэй байж, итгэлээр суралцах нь идэвхгүй хүлээн авах биш, харин сүнслэг байдал, оюун ухаан, бие бялдрын хувьд хүчин чармайлт гаргахыг шаарддаг. Бид итгэлээр өдөөгдсөн чин сэтгэлийн тууштай үйлдлээрээ суралцахыг мөн Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авахыг хүсэж байгаагаа Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христэд харуулдаг.

Номлогчид итгэлээр суралцахад нь сонирхогчдоо хэрхэн тусалдаг талаар авч үзнэ үү. Мормоны Номын талаар залбирч судлах, зарлигуудыг сахих, Сүмийн цуглаануудад оролцох зэрэг сүнслэг амлалт өгч, сахих нь сонирхогчийн зүгээс итгэлээ ашиглан, үйлдэхийг шаарддаг. Мөн энэ зарчим бүх гишүүнд, тухайлбал эцэг эх, багш, удирдагчдад хамаатай.

Заах, сэнхрүүлэх, тайлбарлах нь чухал ч гэлээ сонирхогч, хүүхэд, оюутан эсвэл гишүүнд сэргээгдсэн сайн мэдээний бүрэн байдлын талаарх гэрчлэлийг хэзээ ч өгөхгүй. Зөвхөн тэдний итгэл үйлдэл хийхэд хөтөлж, зүрх сэтгэл рүү нь орох замыг нээсэн үед Ариун Сүнс батлагч гэрчийг хүргэх боломжтой. Номлогч, эцэг эх, багш, удирдагчид Сүнсний хүчээр зааж сурах хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ өөр нэгэн чухал зүйл бол тэд бусдад сайн мэдээний талаар өөрөө итгэлээр суралцахад нь туслах үүрэгтэй.

Миний тайлбарлаж байгаа суралцах арга зам нь зөвхөн танин мэдэхүйн түвшинд ойлгож, мэдээллийг хадгалж, эргэн санахаас илүү гүн гүнзгий түвшинд хүрдэг. Миний хэлж байгаа суралцах арга зам нь биднийг Бурханы хувьд сэргээж (Алма 5:7-г үзнэ үү), эгэл хүнээ орхиж (Мозая 3:19-ийг үзнэ үү), зүрх сэтгэлийг маань өөрчилж (Мозая 5:2-ыг үзнэ үү), Их Эзэнд хөрвөгдөн, хэзээ ч итгэл алдрахгүй (Алма 23:6) байхад хүргэдэг. Итгэлээр суралцахад зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуны (С ба Г 64:34) аль аль нь шаардагддаг ба үүний үр дүнд Ариун Сүнс Бурханы үгийн хүчийг

зүрх сэтгэлд авчирдаг. Итгэлээр суралцахыг багшаас суралцагчид, номлогчоос сонирхогчид лекц уншин, үзүүлж эсвэл туршилтын дадлага хийх замаар дамжуулах боломжгүй, харин суралцагч өөртөө мэдлэг олж авахын тулд итгэлээ хөгжүүлэн, үйлдэх ёстой.

Суралцаж, заах загвар

1. Суралцахад бэлд. Ням гаргийн ангид сууж, багшийн сэдэв танилцуулахыг сонсох нь сайн хэрэг. Гэхдээ та багшийн хичээлийн өмнө уншиж, тунгаан бодож, залбирахад урьсан зүйл дээрээ ажиллаж, бэлдэх юм бол Сүнсний хүчтэй мэдрэх бөгөөд Ариун Сүнс таны багш болох болно. Бэлтгэл нь илчлэлтийг урьдаг.

2. Сэнхрэхийн тулд хамтдаа ярилц. Би та нарын анхаарлыг дараах шүлэгт хандуулахыг хүсэж байна. “Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд харин нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог” (С ба Г 88:122).

Энэ бол Их Эзэний суралцаж, заах хүчтэй загваруудын нэг юм. Би “Өөрсдийнхөө дунд багшийг томил” гэсэн шүлгийг арай өөр өнцгөөр харахыг санал болгох гэсэн юм. Багш гэдэг нь хэн бэ? Ариун Сүнс. Хэрэв та Ариун Сүнсийг багшаа болгохыг хүсэж байгаа юм бол “нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсо[x]” ёстой бус уу? Тэрхүү сэнхрэлийг зөвхөн Ариун Сүнс өгдөг.

Харин сэнхрүүлэхээр харилцах нь илчлэлтийг урьдаг. Саяхнаас бид Сүм дээр сүнслэг байдлын хувьд аль болох илүү мэдрэмтгий, хатуу, шаардлага өндөртэй суралцах, заах загвараас суралцаж мөн тэдгээрийг хэрэгжүүлж байгаа. Бид үргэлж хийдэг байсан зүйлээ үргэлжлүүлэн хийж, бахь байдгаараа үлдэх үү эсвэл наманчлан, Их Эзэний арга замаар илүү түлхүү суралцаж, өөрчлөгдөх үү?

3. Үйлдэхэд урих. Ганцхан энгийн асуулт энэ зорилгод хүрэхэд тусалдаг. Та сурч мэдсэн зүйлээ ашиглан юу хийх вэ? Илчлэлтийнхээ дагуу үйлдэх нь өөр олон илчлэлтийг урьдаг.

Бид Их Эзэний яаравчлуулж буй ажилтай хөл нийлүүлж, улиг болсон аргаараа хийхгүй байгаасай хэмээн би залбирч байна.

Их Эзэн Есүс бодит бөгөөд амьд гэх гэрчлэлээ тунхаглая. Тэр амьд гэдгийг би гэрчилж байна. Тэр амилсан. Тэрээр энэ Сүмийг тэргүүлж,

ажил хэргийг нь хөтлөн явуулдаг. Бидний хүн нэг бүрийг яаравчлуулж буй ажилтай нь мөр зэрэгцэн алхалж, өсөлт хөгжил, сурч мэдэхэд зориулсан загварыг нь дагаасай хэмээн Тэр хүсдэг. ■

2014 оны 6-р сарын 25-нд болсон номлолын шинэ ерөнхийлөгчдөд зориулсан сургалт дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛ

1. James E. Talmage, *Articles of Faith*, 12th ed. (1924), 162.



БЭЛТГЭЛ НЬ ИЛЧЛЭЛТИЙГ УРЬДАГ.

ЕРӨНХИЙ ЧУУЛГАНААС СУРАЛЦАХ

5

АРГА ЗАМ

ЕРӨНХИЙ ЧУУЛГАН бол дэлхийн өнцөг булан бүрд байгаа гишүүдтэй хамт Сүмийн удирдагчдыг сонсож, Их Эзэнээс удирдамж хүлээн авах гайхалтай сайхан боломж юм. Ерөнхий чуулганы захиасуудыг үзэж, сонсож, судлах нь амьдралд тань Сүнсийг авчран, хувийн гэрчлэлээ өсгөн нэмэгдүүлэхэд туслах болно. Энэ нь танд хувийн илчлэлт хүлээн авч, үүнийхээ дагуу үйлдэх боломж олгох юм.


Энд Ерөнхий чуулганаас суралцаж болох 5 арга замыг санал болгож байна.

ХРИСТ БА БАЯН ЗАЛУУ УДИРДАГЧ, ГЕНРИХ ХОФМАНЫ БҮТЭЭЛЭЭС

1

ЕРӨНХИЙ ЧУУЛГАН ЭХЛЭХЭЭС ӨМНӨ АСУУЛТУУДАА БИЧ

Ерөнхий чуулган эхлэхээс өмнө цаг зав гарган асуултуудаа бичээд, чуулганы үеэр ирэх хариултуудад анхаарлаа хандуул. Та идэвхтэй оролцож, Сүнсийг сонсох юм бол таны залбирал болон асуултууд хариулагдах боломжтой.



2

ХРИСТЭЭС СУРАЛЦАХЫГ ЭРЭЛХИЙЛ

Бошиглогчид Аврагчийн талаар гэрчилж, заадаг (Үйлс 10:43-ыг үзнэ үү). Та Ерөнхий чуулганы захиасуудыг сонсож байхдаа үг хэлж байгаа хүмүүс Есүс Христийн талаар танд юу зааж байгаа тухай бодож болно. Та бүр тэмдэглэл дээрээ жагсаалт гаргаж болно.



*Танд илчлэлт
хүлээн авч,
үүнийхээ дагуу
зоригтой үйлдэх
чадавх байгаа.*

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, "Их
Эзэн Өөрийн Сүмийг удирддаг," 2017
оны 10-р сарын Ерөнхий чуулган

3

СЭДВҮҮДЭД АНХААРАЛ ХАНДУУЛ

Ерөнхий чуулганы зарим хэсгийг үзсэнийхээ дараа та нэг сэдвийг нэгээс олон удаа дурдсаныг сонссоноо анзаарна. Таны анзаарч харсан загвар нь Сүнсний зүгээс суралцах хэрэгтэй зүйлийг тань олж харахад тусалж байгаа нэг арга зам байж болох юм.

5

УРАМ ЗОРИГ АВЧ, ҮЙЛДЭХЭД СҮНСЛЭГЭЭР ӨДӨӨГД

Таныг үйлдэл хийхэд сүнслэгээр өдөөсөн эсвэл үйлдэл хийхэд урьсан захиас, үгсийг бичиж тэмдэглэ. Энэ нь танд сурсан зүйлээ амьдралд хэрэгжүүлж, мөн дараа нь юу бодож байснаа хэрэгтэй үед эргэн санахад тусална. ■



Итгэлтэй байж,
итгэлээр суралцах
нь идэвхгүй хүлээн
авах явдал биш,
харин энэ нь сүнслэг
байдал, оюун ухаан,
бие бялдын хувьд
хичээнгүйлэн орол-
цохыг шаарддаг.

Ахлагч Дэвид А.Бэднар, "Их Эзэний
арга замаар суралцах нь," энэ
дугаарын 50-р хуудас

4

МОРМОНЫ НОМЫН ХЭСГЭЭС ТЭМДЭГЛЭЖ АВ

Та Сүмийн удирдагчдын эш татсан судруудад, ялангуяа "манай шашны тулгуурын чулуу" (Мормоны Номын Удиртгал) болох Мормоны Номонд анхаарал хандуулснаар олон зүйлийг сурч, мэдэж авах боломжтой. Ерөнхий чуулган дээр дурдах бүрд нь тэмдэглэ. Олж мэдсэн зүйлс тань таныг гайхшируулна!

АРИУН СҮНСЭЭР ЗААЛГАСАН НЬ

Эдгээр өсвөр үеийнхэн Ерөнхий чуулганы өмнө
Сүнсээр заалгахад бэлтгэгдсэн. Тэд өмнөх Ерөнхий чуулганаас
дараах зүйлсийг сурч, өөрөөр хийдэг болсон.



Сүнсээр өдөөгдсөн удирдамж

Ерөнхий чуулган намайг сүнслэгээр өдөөсөн. Бусдад үйлчлэн, Христэд найдаж, төмөр бариулаас чанга зууран барих талаар удирдагчдынхаа өгсөн зааврыг сонсож байхад Ариун Сүнс энэ сайн мэдээ үнэн ба бид зарлигуудыг сахиж, Бурханы үгийг дагаснаар мөнх амьдралыг авах боломжтой гэдгийг надад гэрчлэхийг би мэдэрсэн юм. Би орон нутагтаа илүү ихээр үйлчилж, өөрийн гэрчлэлийг өдөр бүр залбиран, судраас судлах замаар хүчирхэгжүүлэх зорилго тавьсан. Би Тэнгэрлэг Эцэгийн охин гэдгээ мэднэ. Тэр амьд бөгөөд намайг мөнхөд, үргэлж хайрладаг.

Мэйглин Б., 16 настай, АНУ, Делавэр

Түүний талаарх мэдээлэл: Гурван хүүхдийн ууган нь; кросс гүйлтээр хичээллэдэг; ном уншиж, дуу дуулах дуртай мөн испани хэлэнд дуртай бөгөөд англи хэлийг гадныханд заахыг хүсдэг.



Асуултуудын хариу

Надад Ерөнхий чуулган болохоос өмнө (1) Би хэрхэн эерэг хандлагатай байж, найзуудаа буруу шийдвэр гаргахаас өмнө тусалж болох вэ? (2) Би тэднээр шоглуулахгүйгээр хэрхэн Сүмийн талаар гэрчилж болох вэ? гэсэн хоёр асуулт байсан. Чуулганы үеэр Сүнс надад ганцаараа биш гэдгийг гэрчилсэн юм. Одоо би чин сэтгэлээсээ судраас суралцах юм бол найзуудтайгаа холбоотой асуултуудынхаа хариултыг олж авна гэдгээ мэднэ. Тэнгэрлэг Эцэг минь залбирлыг маань сонсдог гэдгийг би мэдэх бөгөөд өдөр бүр илүү сайн болохыг хичээх болно.

Исаак Р., 13 настай, Эквадор, Пичинча

Түүний талаарх мэдээлэл: Айлын ганц хүүхэд; төгөлдөр хуур тоглох, тэшүүрээр гулгах, жудо-гоор хичээллэх, сэлэх, дуулах, лаа хийх дуртай; эмч болохыг хүсдэг; ногоон өнгөнд дуртай.






Өсөж хөгжих урилга

Ерөнхий чуулган Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрах хүслийг маань хүчирхэгжүүлсэн. Энэ нь энэ Сүм гэрэл болон аз жаргалыг авчирдаг үнэн Сүм болохыг мэдэж, ойлгоход надад тусалсан. Сүнс намайг өдөр бүр өсөж хөгжин, сайн мэдээний талаарх хүчтэй гэрчлэлтэй болохын тул Мормоны Номоос уншихад урихыг би мэдэрсэн. Тэнгэрлэг Эцэг намайг тэдгээр сүнслэг захиасыг сонсоосой хэмээн хүссэн гэдэгт би итгэдэг.

Висент А., 16 настай, Чили, хотын бүс

Түүний талаарх мэдээлэл: 4 хүүхэдтэй айлын ууган нь; видео тоглоом тоглох, хөгжим сонсох, хөл бөмбөг тоглох дуртай; жүжигт оролцдог, номлолд үйлчлэхийг хүсдэг.




Суралцахад бэлэн байх

Би Ерөнхий чуулганаар Сүнсийг маш хүчтэй мэдэрдэг. Би чуулганд асуултуудаа болон сүнслэг байдлын хувьд өөрийгөө бэлдэж байсан тул энэ нь миний амьдралын утга учрыг өөрчилж, үг бүрээс илүү ихийг суралцах болсон юм. Би бошиглогч, төлөөлөгчдөд талархдаг бөгөөд Тэнгэрлэг Эцэг бидний амьдралыг удирдан залахаар тэднийг илгээсэн гэдгийг мэднэ.

Бэн Х., 17 настай, АНУ, Кентаки

Түүний талаарх мэдээлэл: Спортод дуртай; сургуульдаа сагсан бөмбөг, теннис тоглодог; цана, сноубордоор гулгах, аялах, ууланд алхах дуртай.



Гэрэл эрэлхийлэх

Уржнан жил надад хамгийн хүнд жил байв. Аав маань хорт хавдартай тэмцэж байсан ба манай хот террорист халдлагад өртсөн байлаа. Би сэтгэлийн түгшүүрт автах болсон бөгөөд сүнслэг болон бие махбодынхоо аюулгүй байдалд санаа зовж байж хэрхэн амар тайванг мэдрэх билээ гэж боддог байв. Ерөнхий чуулганаас бид ариун журамтай амьдрах юм бол амар амгаланг олж, зүрх сэтгэлээ итгэлээр дүүргэж, аливаа зүйлийг мөнхийн талаас нь авч үзэх чадвартай байх болно гэдгийг би мэдэж авсан. Энэ нь хүнд хэцүү үед өөрийн ойлголтод тулгуурлахын оронд Христэд хандахад намайг сүнслэгээр өдөөсөн. Христийн гэрлийн тод туяаг эрэлхийлснээр харанхуйн нөлөөнөөс гарч чадна гэдгээ би мэднэ.

Оливиа Х., 17 настай, Бельги

Түүний талаарх мэдээлэл: Усанд сэлдэг; орон гэргүй хүмүүсийг хооллодог шөлний газрын гал тогоо, асрамжийн газар, сургуулийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрт сайн дураараа үйлчлэх дуртай.

“ХЭРЭВ ТА НАР [ЕРӨНХИЙ
ЧУУЛГАНЫГ]

СОНСОХ

ЮМ БОЛ АРИУН СҮНС ТА НАРЫН
ДОТОР ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙГ
МЭДРЭХ БОЛНО ГЭДГИЙГ БИ
СҮМИЙН ЗАЛУУ ГИШҮҮДЭД

АМЛАЖ

БАЙНА. ИХ ЭЗЭН ТА НАРЫГ
АМЬДРАЛАА ХЭРХЭН АВЧ ЯВААСАЙ
ХЭМЭЭН ХҮСЭЖ БАЙГААГАА
ТА НАРТ ХЭЛЭХ БОЛНО.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч
Робэрт Д.Хэйлс (1932-2017)
“Ерөнхий чуулган: Итгэл ба
гэрчлэлийг хүчирхэгжүүлэх нь”

ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ талаарх баримт

Чуулганы төвийн бадралт баг бишгүүр хөгжим нь

7667

гуурс хоолойтой боловч тэдгээрээс зөвхөн 170-ыг нь үзэгчид харах боломжтой

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ерөнхий эрх мэдэлтнээр үйлчилсэн 34 жилийн хугацаандаа

84

удаа Ерөнхий чуулган дээр үг хэлсэн байна

221

улс орон, газар нутгийн хүмүүс Ерөнхий чуулганыг үздэг

Хэлж буй үгсийг

94

хэлээр орчуулдаг



Чуулганы төвийн индрийг **ЕРӨНХИЙЛӨГЧ ГОРДОН Б.ХИНКЛИГИЙН** (1910–2008) хөгшин хушганы модоор хийсэн



АНУ-ын Юта мужийн Солт Лэйк Ситид болдог Ерөнхий чуулганы таван хуралдаанд

100000

гаруй хүн оролцдог

Чуулганы төвийн заал

230 тохой (70.5 м) урт

БОИНГ 747 ОНГОЦЫГ

ч багтаах боломжтой



Ерөнхий чуулган болгон дээр ойролцоогоор

35

үг яриа хэлэгддэг



ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ ҮЕЭР ӨГСӨН ОНЦГОЙ МЭДЭГДЛҮҮД:

**1995 ОНЫ
9-Р САР:**

“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”

**1998 ОНЫ
4-Р САР:**

Жижиг ариун сүмүүдийг барих

**2001 ОНЫ
4-Р САР:**


Тасралтгүй Боловсролын Санг эхлүүлэх

**2012 ОНЫ
10-Р САР:**

Номлолд үйлчлэх насыг доошлуулах

**2018 ОНЫ
4-Р САР:**

Гэрийн болон айлчлагч багшлалтыг тохинууллаар орлуулах



“Хүмүүс
хэрэлдэж,
маргаж
байхад би
гэр орондоо
Сүнсийг
хэрхэн урьж
чадах вэ?”

ЭНХИЙГ САХИГЧ БАЙ

“Бид бусдын биеэ
авч явах байдлыг
өөрчилж чадах-
гүй үед өөрөө
өөрсдийгөө зохих
ёсоор захирах тал
дээр ажиллана...”

Гэр бүлийн
гишүүдтэйгээ
хэрэлдэн марга-
хын оронд бид
хамтгаа бүтээж,
сонсож, хэлэлцэх
ёстой.”

Elder Marvin J. Ashton of the
Quorum of the Twelve Apostles
(1915-94), “No Time for
Contention,” Apr. 1978 general
conference.



Уучлал гуй

Би хэрүүл маргаанд
орох үедээ уучлалт
гуйдаг. Өөрийнхөө
зөв байсан гэж бодож,
мэдэж байсан ч буруу-

гаа хүлээх нь өрөөнд амар тайван
орчинг эргүүлэн авчирдаг. Дараа
нь холдон явж, дуугаа хураа мөн
сэдвийг өөрчил эсвэл санал ний-
лэх зүйлийг ол. Сүнс удалгүй
эргэн ирнэ.

Дилан М., 15 настай, АНУ, Калифорни

Зүгээр л хайрла

Цэвэр хайрыг гэр бүлийнхэндээ
үзүүлэх нь Сүнсийг гэр оронд маань
урин авчирдгийг би мэдэж авсан.
Бошиглогч хайр бол өөрчлөлтөд
хүргэдэг хурдасгуур, бодгалийг
эдгээгч гавар хэмээн хэлсэн. Хайрын
сүнс гэр оронд аюулгүй байдал,
амар амгаланг авчирдаг.

Жозэф К., 18 настай, АНУ, Аризона

Гэр бүлийнхэнтэйгээ ярилц

Гэр бүлийнхэн тань Сүмийн гишүүд
биш бол тэднийг хэрэлдэхэд ямар
муухай санагддагаа хэлээд, тэднээс
өөрчлөгдөхийг хүс. Энэ нь нөлөө-
лөхгүй бол залбираад, дахин оролд.
Хэрэв тэд Сүмийн гишүүд бол
тэдэнд Бурханы хүүхдүүд гэдгийг нь
мөн хэрүүл маргаанаас зайлсхийх
хэрэгтэй гэдгийг нь сануул.

Каролина С., 19 настай, Бразил, Гояс



Сүнсний төлөө залбир

Эргэн тойрон дахь
гэр бүлийнхэн тань
хэрэлдэн маргалдахад
Сүнсний оршихуйг мэд-

рэхэд хэцүү байдаг ч хэрэв та зохис-
той бол Сүнснийг мэдэрч чадахгүй
гэсэн үг биш юм. Их Эзэний Сүнснийг
илүү хүчтэй мэдрэхийн тулд дот-
роо залбирч, сүнслэг удирдамжинд
онцгой анхаарал хандуул. Тэнгэрлэг
Эцэг танд амар амгаланг мэдэрч, тэр-
хүү амар амгаланг хэрхэн гэр орон-
доо авчрах хамгийн сайн арга замыг
олж мэдэхэд тусална.

Кэйти Ж., 17 настай, АНУ, Юта

Харилцан буулт хийхийг хичээ

Бүгдийн санаанд таарч тохирох
арга замаар асуудлыг шийдвэрлэх
талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилц
эсвэл судраас хуваалцаж, дуулал
дуул. Мөн та Тэнгэрлэг Эцэгээс
асуудлыг шийдвэрлэх талаар тус-
ламж гуйн, залбирч болно. Ингэс-
нээр бүгд тайвшрах ба орилж
хашгиран, хүчирхийлэлд хүргэхгүй-
гээр асуудлыг шийдвэрлэх боломж-
той. Ариун Сүнс та нарыг амар
амгалангаар дүүргэж, дахин хэрүүл
маргаан хийхгүй байх хүслийг бүг-
дэд өгөх нь гарцаагүй.

Луис Ф., 14 настай, Мексик, Кармен

*Эдгээр хариулт тусламж, ойлголт өгөх
зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан
ёсны мэдэгдэл биш юм.*



Гэрчлэл нь ердийн нэг мэдрэмжээс илүү зүйл үү?

Гэрчлэл гэдэг нь Аврагчийн Петрт хандан “Учир нь үүнийг чамд мах
цус нь биш, харин Тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм” (Матай 16:17)
хэмээн хэлсэн тэр зүйл юм. Энэ бол Ариун Сүнсээр дамжуулан илчил-
сэн Бурханы мэдлэг.

Ариун Сүнсний дуу хоолой бидэнд сонсогддог гэхээс илүү мэд-
рэгддэг ч энэ нь оюун ухаан болон “зүрх сэтгэл[ийн] чинь” (С ба Г 8:2;
онцлон тодорхойлолт нэмэгдсэн) бодол санаагаар болон мэдрэмжээр
дамжин ирдэг.

Бошиглогч Иосеф Смит илчлэлтийн сүнсийг “цэвэр оюун ухаан орж
ирж байгааг мэдэрвэл илчлэлтийн сүнс оюун ухаанд чинь гэнэтийн
санаанууд орж ирэхэд хүргэ[дэг]” тийм мэдрэмж хэмээн дүрсэлсэн
(Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит [2007], 151).

Бид оюун ухаан, зүрх сэтгэл буюу бодол санаа, мэдрэмж, хүслээ
Бурханд хандуулах юм бол Тэрээр бидний оюун ухаан, зүрх сэтгэлд
Ариун Сүнсний намуухан, аниргүй, нам гүм дуу хоолойгоор ярих болно.
Түүнийг бидний сүнстэй харьцах үед бидэнд онцгой мэдрэмж, бодол
санаа төрөх шиг санагддаг. Энэ бол Түүний бидэнд өгдөг гэрчлэл юм.

Та юу гэж бодож байна вэ?

“Би сайн жишигтэй найз нөхдийг хэрхэн олох вэ?”

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай
сургийн хамт liahona.lds.org хаягаар (“Өгүүлэл
оруулах” дээр дар) 2018 оны 11-р сарын
15-ны дотор ирүүлнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой
болгохын тулд хянан засварлах магадлалтай.

Ирээдүйд тань таныг бэлддэг зам

Лиан Бартон

Сүмийн сэтгүүлүүд

14 настай ямар ч охин өөрийгөө тоос тортогтой амбаарт зэвэрсэн хүрз эргүүлэн, морины өмхий үнэртэй саравчийг цэвэрлэнэ гэж мөрөөдөхгүй байх. Харин би том болж, өөр ажил хийж чаддаг болтлоо хичээлийнхээ дараа өдөр бүр үүнийг хийдэг байв.

Энэ нь ахлах ангид байхдаа хийхийг хүсдэг байсан ажил маань байгаагүй ч би тухайн үед дуртай ажлаа буюу малын хашаа цэвэрлэхтэй холбоогүй ажил хийхийг хүсэж л байгаа юм бол коллежид явах хэрэгтэй гэж мэдэж байсан юм. Тийшээ явахын тулд надад мөнгө хэрэгтэй байлаа. Миний хувьд боловсролтой болох нь сэтгэл ханамж авах (аз завшаан тохиолдвол) ажил мэргэжил эзэмшихийн тулд хийх зөв алхам байв.

Хамгийн сайхан нь миний сонгосон зам бол ажиллаж, өөрийн хэрэгцээг хангах боломжийг олоход туслах олон арга замын зөвхөн нэг нь юм. Үүнийг материаллаг болон сүнслэг байдлын хувьд бие даах гэж нэрлэдэг. Та байгаа боломж бололцоогоо эргэцүүлэн бодохдоо өөрийг тань хамгийн сайн бэлдэх арга замыг сонгохыг хичээ.

Доорх түүх нь хэдхэн жилийн өмнө таны адил бага залуу байсан хүмүүсийн түүх юм. Та энэ залуучуудын жишээг дагаснаар амжилттай бие даахад туслах өөрийн замыг олж болно.

ЭРГЭН ТОЙРОНД ТАНЬ ЯМАР ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БАЙГААГ САЙТАР БОДОЖ ҮЗ

Аудом Писет, Камбож улс

Зорилгодоо хүрэхийн тулд шаргуу хөдөлмөрлөх нь маш чухал ч амжилтад хүрэх өөр нэгэн арга зам бол ухаалгаар ажиллах явдал гэдгийг би үргэлж өөртөө сануулдаг. Англид номлолд үйлчилснийхээ дараа би Камбожид эргэн ирж, ажлын зах зээлийг судлав. Би ажил бүрийг хийж сурахад хэр хугацаа зарцуулах хэрэгтэйг мөн сургалтын төлбөр хэд болохыг судалж эхлэв.

Хувцасны бараа судлаач болоход сургалтын хөтөлбөрийн хугацаа богинохон атлаа хэцүү төдийгүй тийм ч олон хүн энэ ажлыг хийхгүй байгааг би олж мэдэв. Энэ нь сайхан боломж болохыг би олж хараад, уг боломжоос зууран барихаар шийдсэн юм. Одоо би хөтөлбөртөө хамрагдаж дуусаад, хувцасны компанид бараа судлаачаар ажиллаж байна.

Зөв ажил мэргэжлээ олох амаргүй ч надад тусалж, өргөн дэмждэг Аврагч бий.



Аль коллежид явах, ямар ажилд орох эсвэл ямар ажил мэргэжил эзэмшихийг эрэлхийлж байгаа зэргээсээ үл хамааран та Бурханы хаант улсыг барьж байгуулахад туслах нэн чухал шинж чанаруудыг хөгжүүлж байгаа билээ.

БОЛОВСРОЛЫГ АШИГЛАН ҮҮД ХААЛГЫГ НЭЭ

Иоланда Тэйксэйра, Африк, Кейп Верд

Ээж маань үргэлж намайг “Боловсрол бол амжилтад хүрэх түлхүүр” хэмээн урамшуулдаг байсан. Би өөртөө, ялангуяа гэр бүлдээ илүү сайхан ирээдүйг хүссэн бөгөөд үүндээ хүрэхийн тулд сургуульдаа үргэлжлүүлэн сурах ёстой байлаа. Тухайн үед би коллежид явах мөнгөгүй байсан тул техник мэргэжлийн сургуульд компьютерийн системийн засварын мэргэжлээр суралцахаар тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргав.

Сурч байх үед надад олон хүндрэл бэрхшээл тулгарч байсан ч тэдгээр нь сайн сайхан өдөр ирнэ хэмээн урагшлахад минь саад болж чадаагүй юм. Залбирал надад их тусалсан бөгөөд би Их Эзэнтэй үргэлж зөвлөлддөг байсан. Би үргэлж сайн сурахыг хичээдэг байсан ба одоо ч гэсэн ажилдаа бие сэтгэлээ зориулан, компьютерийн техникч болон маркетингийн туслахаар шаргуу ажилладаг.



ХҮСЭЖ БҮЙ ИРЭЭДҮЙГЭЭ БҮТЭЭХИЙН ТУЛД ОДООНООС ЭХЛЭН АЖИЛЛА

*Анн-Софий болон Лоорэнс Кавин, НВУ,
Шотланд*

Анн-Софий: Би их сургуульд суралцахыг үргэлж хүсдэг байсан ч өсвөр насанд байхдаа ямар чиглэлээр суралцах талаарх төлөвлөгөө маань эрс өөрчлөгдсөн юм. Би ахлах сургуулиа төгссөнийхөө дараа эмнэлэгт сайн дурын ажилтнаар 6 сар ажилласан. Тэр үеэс эхлэн сувилагч болохыг хүсэх болсон ч яг хийж чадна гэдэгтэй итгэлгүй байв.

Манай тойргийн бие даах чадвар хөгжүүлэх ангид шаардлагыг нь хангахгүй байж болох ч хүссэн ажил мэргэжлээ сонгохыг биднээс хүссэн юм. Би юу хийх вэ гэж залбирахад сувилагч бол гэсэн бодол санаанаас маань огт гарахгүй байлаа. Би Их Эзэний удирдамжийг дагахаар шийдсэн.

Энэ зам тийм ч амар хялбар байсангүй. Эхлээд би сувилагчийн сургалтын хөтөлбөрийг болон тухайн мэргэжлээр суралцахад миний зүгээс юу шаардагдахыг судалсан. Би энэ мэргэжлээр сурсан хүмүүстэй уулзаж ярилцсан. Эхлээд би



сувилагчийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ өгч, хүлээх жагсаалтад оров. Би бууж өгөлгүй дахин хүсэлтээ өгснөөр эцэст нь орж чадсан юм. Их Эзэнд танд зориулсан төлөвлөгөө байдаг тул заримдаа тэвчээртэй байж, Түүнд итгэж найдах хэрэгтэй.



Лоорэнс: Би бага байхдаа ямар ч мэргэжлээр сурч, ямар ч ажил хийсэн бай хамгийн сайнаараа хичээнэ гэсэн зорилго тавьсан юм. Би үргэлж суралцаж, сайжирч, амжилтад хүрэх хамгийн сайн боломжийг өөртөө олгохыг хичээдэг байв.

Одоо би хувцасны компанид менежерээр ажилладаг ч цагдаа болохыг хүсдэг. Шотландад цагдаа болох хүсэлт гаргахын тулд тухайн улсад гурван жил тасралтгүй амьдарсан байх ёстой. Номлолд хоёр жил үйлчилж байх хугацаандаа гадаадад байсан тул би тэнд ажиллахын тулд хэдэн сар хүлээх хэрэгтэй болсон.

Хэдийгээр энэ нь том саад ч гэлээ би бууж өгөөгүй. Надад гэр бүлээ тэжээх сайн ажил байгаа бөгөөд би дараагийн ажилдаа сайн тодорхойлолт авахын тулд шаргуу хөдөлмөрлөдөг.



ӨӨРИЙН ЗАМЫГ ОЛЖ НЭЭХ

1.

ӨӨРӨӨ ӨӨРИЙГӨӨ ТАНЬЖ МЭД

Та ямар зүйлийг сайн хийдэг вэ? Та юу хийх дуртай вэ? Эдгээр асуултад хариулах нь таны үр чадвар, сонирхол, авьяастай нийцэх боломжит ажил мэргэжлээ олж тодорхойлоход тусална.

САНАА: Эцэг эх, багш, найз нөхдөөсөө ямар авьяас чадварыг өөрөөс тань олж харж байгааг асууж болно. Тэдний хэлсэн зүйл таныг гайхшируулж болох юм.

2.

ОРЧНОО САЙН МЭД

Амьдарч байгаа газарт тань ямар ажил мэргэжил эрэлт хэрэгцээтэй байна вэ? Аль компани ажилчид авч байна вэ? Хөгжиж байгаа мөн ирээдүйд илүү их боломж бололцоо нээгдэх магадлал өндөртэй салбарт ажил мэргэжлийн замаа сонгох нь ухаалаг шийдвэр юм.

САНАА: Коллеж, их сургууль эсвэл техник мэргэжлийн сургуулиуд ямар үр чадвар эрэлт хэрэгцээтэй мөн аль салбар өсөж өргөжиж байгааг ихэвчлэн мэддэг.

3.

ДАРАА НЬ ЮУ ХИЙХЭЭ МЭДДЭГ БАЙ

Хүссэн ажилд тань ямар шаардлага тавигддаг вэ? Та хэрэгтэй сургалт, боловсролоо хаанаас авах вэ? Та төлбөрөө хэрхэн хийх вэ? Та ажил мэргэжлийн урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд эхлээд уг зорилгодоо хэрхэн хүрэх вэ гэдгээ мэддэг байх хэрэгтэй.

САНАА: Хүссэн мэргэжлээр тань ажиллаж байгаа хүнтэй ярилцаж болно. Тэднээс асууж лавла. Ихэнх хүн зөвлөгөө, санаа өгөх дуртай байдаг.

Энэ залуучуудын адил та ч гэсэн өөрийгөө болон ирээдүйн гэр бүлээ явч явахад бэлдэх олон арга замыг олох болно. Та зорилгоо мартгахгүй л бол амжилтаа төлөвлөх боломжтой. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф: “Чадах бүхнээ хийж, хийдэг юм бүхэндээ гарамгай гэдгээ харуулцгаая. Шинэ өдөр бүрийн авчрах ажил хөдөлмөрийн агуу боломжинд оюун ухаан, бие бялдраа бэлдэцгээе” гэж заасан (“Ямар ч эдийн засгийн үед хамаарах хоёр зарчим,” 2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган). Та одооноос эхлэн сурч, ажиллахад анхаарлаа төвлөрүүлснээр ирээдүйдээ итгэлтэй байхад туслах дадал хэвшлийг өөрөө өөртөө төлөвшүүлнэ. ■

Эрхлэгчийн тайлбар: Бишопоосоо гадасны бие даах чадвар хөгжүүлэх мэргэжилтэнтэй танилцуулахыг хүс. Тэд ирээдүйн боловсрол, ажил мэргэжлийн боломж бололцоог олж нээхэд тань тусална.

Бурханы хайрыг дамжуулах нь



Аллий Б., 12 настай, АНУ, Кентаки

Хэдэн жилийн өмнө манай гэр бүл Кентакид нүүж ирсэн юм. Би найз нөхөд, хамаатан саднаа орхин явж байгаадаа дурамжхан байлаа. Кентаки миний дассан газраас тэс өөр байв. Анх Сүмд очоод, тэнд цөөхөн хүн байгааг би олж харав. Ямар жижигхэн салбартай болохыг мэдээд би муулж суухын оронд ямар нэгэн зүйл хийхээр шийдлээ.

Маргааш нь би ээжтэйгээ хамт дэлгүүр оров. Гэрээсээ гарахын өмнө би дамжуулдаг картуудаа авлаа. Дэлгүүрт ороод би чихэр авч, кассан дээр дөхөж очив. Кассчин чихрийг уншуулаад надад өглөө. Харин би түүнд эргүүлэн өгөв. Тэр гайхсан маягтай хараад, “Хатагтай, та сая мөнгөө төлсөн шүү дээ” гэж хэллээ.

Би “Тийм ээ. Гэхдээ би үүнийг танд бэлэг болгон өгч байгаа юм” гэв. Тэгээд би дамжуулан өгөх картаа чихэртэйгээ хамт өглөө. Тэр инээмсэглээд, талархлаа илэрхийлэв. Дамжуулах картын ар талд “Хүн бүр Бурханы хүүхэд” гэж миний бичсэн үгсийг тэр харлаа. Тэр эмэгтэй Сүмд нэгдэхгүй байсан ч би өнөөдөр сайн зүйл хийснээ мэдэж байсан учир сэтгэл хангалуун тэндээс гарав.

Орой болоход би үлдсэн дамжуулан өгөх картуудаа кассны хажууд орхиод гарснаа саналаа! Дараагийн удаа би дэлгүүр орохдоо карт маань байгаа эсэхийг асуухаар очив. Би нэг зүйлийг олж хараад, байсан газраа зог туслаа. Таван кассан дээр “Хүн бүр Бурханы хүүхэд” гэж бичсэн дамжуулан өгөх карт байв. Кассчин картуудыг бусдадаа дамжуулан өгсөн байлаа. Би хийсэн зүйлдээ ямар их баярласан гэж санана аа. ■



Хавцал дахь залбирал



Карсэн К., 11 настай, АНУ, Юта

Өнгөрсөн жил би аав, ах хоёртойгоо ууланд аялсан юм. Бид хавцлын гүн рүү оров. Удалгүй хажуугийн харгуйгаар явлаа. Бид том агуйнууд мөн дээрээс нь өнгийн харах сайхан газрууд олов. Бид сул чулуу, огцом толгод өөд, улам бүр дээшээ авирлаа.

Хэсэг явсны дараа бид зүг чигээ бүрмөсөн алдав. Хавцлаар доош буухын тулд аль замаар явах хэрэгтэйгээ бид сайн мэдэхгүй байлаа. Өтгөн бургасан дунд орсон байсан тул хавцлын дээд, доод талын аль аль нь харагдахгүй байв. Би цухалдаж эхэллээ. Хаашаа явахаа би ч, аав ч мэдэхгүй байв!

Харанхуй болж, хүйтэрч эхлэх үед хавцлаас гарч

чадаагүй л байлаа. Харин Тэнгэрлэг Эцэг аль зүг рүү явахыг мэднэ гэдгийг би мэдэж байв.

Би “Бид эндээс гарахыг хүсэж л байгаа юм бол залбирах хэрэгтэй” гэж хэллээ. Тэгээд бид гурав өвдөг сөгдөн, Тэнгэрлэг Эцэгээс хавцлаас гарах замыг зааж өгөхийг хүсэн залбирав.

Биднийг явж эхлэнгүүт надад өндөр, шулуун мод харагдахад зүүн гар тийшээ эргэх хэрэгтэй гэсэн мэдэрэмж төрлөө. Зүүн гар тийш эргэнгүүт би машинаа олж харав. Тэнгэрлэг Эцэг бидэнд хавцлаас гарахад тусалсан гэдгийг би мэднэ. Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд хариулж, яг нар жаргаж байхад бид эсэн мэнд хавцлаас гарч чадсан юм.

Би залбирлын хүчинд болон Тэнгэрлэг Эцэг биднийг сонсдог гэдэгт үнэхээр талархаж явдаг. ■

Чех улсад тод гэрэлтсээр

Сүмийн сэтгүүлүүд, Шэрон Гүүдрич эмхэтгэв

Бид Чех улс дахь Хүүхдийн хэсгийн хүүхдүүд. Бид ингэж улс орондоо тод гэрэлтдэг.

Нэгэн удаа би хайртай бээлийгээ гэж, үүндээ маш их харамсав. Би ээжтэйгээ хамт залбирсан ч олсонгүй. Харин би итгэлтэй байх гэж хичээсэн. Харин долоо хоногийн дараа дүү маань миний бээлийг гудамжнаас олсон! Бурхан бидний залбиралд хариулдаг. Би Түүнд хайртай бөгөөд амьд гэдгийг нь мэднэ.

Андрэ В., 9 настай



Надад Сүмийн гишүүн биш ч гэсэн жишгийг маань хүндэлдэг сургуулийн найзууд байдаг. Нэг удаа би залбирахыг санал болгоход тэд зөвшөөрсөн! Би үүнд нь маш их баярласан.

Ивана А., 11 настай



Би найзуудтайгаа хамт шатаар доош бууж байлаа. Лифтэн дээр ирэхэд надад эвгүйцэх мэдрэмж төрж, би найзуудаасаа суухгүй байхыг гуйв. Мэдээж тэд суухаар шийдсэн. Харин би шатаар явлаа. Намайг доош



буухад найзууд маань тэнд байсангүй. Тэд лифтэнд гацсан байлаа! Тэд гарах гэж нэлээд удав. Би ноцтой зүйл болоогүйд мөн Ариун Сүнсийг дагасандаа баярласан.

Амалий Н., 10 настай

Далайн эрэгт тэнгэр харанхуйлж эхлэв. Шуурга шуурч, хүчтэй давалгаалах нь тэр! Тэнгэр дуутарч, цахилгаан цахиж, мөндөр орлоо. Бүгд нөмөр газар руу гүйцгээв. Бид шуурганд осолдож, гэмтээгүй. Гэртээ харих зам зуураа бид гурван солонго татсан байхыг харсан. Бурхан бидэнд тусалж, хамгаалсан гэдгийг бид мэднэ.

Якуб Б., 10 настай



Сургууль дээр өөртэй нь хэн ч найзлахыг хүсдэггүй нэгэн найз надад бий. Бусад хүүхэд түүнд эелдэг бус зүйл хэлэх болсон тул тэр өөрийгөө царай муутай гэж бодох болсон байлаа.

Би энэ тухай багшдаа хэлээд, түүнийг надтай тоглохыг урьсан. Тэр ямар их баярласан гээч!

Людмила В., 8 настай



Би усанд орж, орондоо орохыг хүсэхгүй байсан тул ээждээ уурлаж байлаа. Маргааш нь би буруу сонголт хийсэндээ сэтгэлээр унав. Ээж надад Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, уучлалт гуйж болно гэж хэлсэн. Бид өвдөг сөгдөн залбирснаар сэтгэл санаа илүү дээрдэв. Бид наманчилж, Есүс Христийн ачаар өршөөгдөх боломжтой гэдгээ олж мэдсэн.

Самуэл Х., 5 настай



Би Сүм дээр гэрчлэлээ хуваалцсан. Ямар их зориг гаргасан гээч! Тэр үеэс хойш би Сүнсийг мэдрэх болсон.

Элишка К., 11 настай

Усан гахайгаа өвдөхөд би залбирсан. Тэнгэрлэг Эцэг бидэнд тусалсанд би талархдаг.

Анэта П., 10 настай



БИДЭНД ОД ИЛГЭЭНЭ ҮҮ!



Бид одоо цуглуулж дуусах дөхсөн байна! Та бидэнд хараахан илгээгээгүй байгаа бол одныхоо зургийг өөрийн түүх, зураг, эцэг эхийн зөвшөөрлийн хамт lahona@ldschurch.org хаягаар э-мэйлээр илгээгээрэй.



“Би дэлхийн Гэтэлгэгч, бидний 'Эзэн Түүнийг' гэрчилж байна.
Тэр бол амьд Бурханы Цорын Ганц Хүү.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

ахлагч Жэффри Р.Холланд


“Miracles of the Restoration,” Ensign, Nov. 1994, 34.

Бидний хуудас



Би Сүмд очихдоо Бурханы Сүнсийг, Түүнийг болон өөрийн Аврагч Есүс Христийг хайрлах хайрыг мэдэрдэг. Би Гэтэлгэгчдээ хайртай.

Аяана Б., 7 настай, Франц




Би гэр бүлийнхэнтэйгээ хамт ариун сүмд байх дуртай. Энэ нь үзэсгэлэнтэй сайхан газар бөгөөд би 12 нас хүрээд орно. Энэ бол Их Эзэний өргөө.

Алдо К., 10 настай, Мексик



“Ерөнхийлөгч Монсон ба түүний зөвлөхүүд”

Омар А., 9 настай, Перу



Би сургууль дээрээ сайн мэдээг найз нөхөдтэйгөө, ялангуяа ярьж, бичиж уншихдаа тааруу нэг хүүтэй хуваалцах дуртай. Есүс Христ сайн мэдээг зааж байсны адил үүнийг хуваалцаж болох нэг арга зам бол бусдад тусалж, үйлчлэх явдал юм. Багш бидэнд гэрийн даалгаврын дэвтэр дээрээ хийх даалгаврыг өгөх бүрд би тэр хүүд туслахад үргэлж бэлэн байдаг. Тэнгэрлэг Эцэгийнхээ хайрыг мэдрэхэд надад тусалдаг болохоор би бусдад үйлчлэх дуртай.

Аллисон М., 10 настай, Эль Сальвадор

Голланд дахь ИТГЭЛ НАЙДВАР

Мэган Армнэкт

Бодит түүхээс сэдэвлэв

15 настай Грэйс охин Дэлхийн II дайны үед Голландад амьдарч байв. Дайн олон жил үргэлжилж байлаа. Голландчууд өлсөж, дайн хурдан дуусаасай хэмээн хүсэж байв.

Дэлхийн II дайны төгсгөл үед Голландын хувьд хамгийн хүнд хэцүү цаг үе байв. Нацистууд бараг бүх зүйлийг нь цөлмөсөн байлаа. Грэйс сургуульд ч явж чадахгүй байв. Гэр орноо халаах нүүрс ч байсангүй. Грэйс болон түүний гэр бүлийнхэн өлсөхгүйн тулд алтанзул цэцгийн булцуу иддэг байжээ. *Хэцүүхэн л амттай байж!* Хамгийн хэцүү нь аав нь дайны олзлогдогч хэвээр байлаа.

Гэхдээ итгэл найдвар алдарсангүй. Хүмүүс нацистууд дайнд яагдаж байна хэмээн ярьцгаах болов. Харин 1945 оны 5-р сард нацистууд бууж өгсөн юм. Голланд эцэст нь дахин эрх чөлөөтэй боллоо! Хүмүүс энэ баярт үйл явдлыг гудамжиндаа гаран тэмдэглэцгээв. Одоо Грэйс сургуульдаа дахин явах боломжтой болжээ. Цэргүүд байна гэж айх хэрэггүй болсон байлаа.

Нэг өдөр Грэйс ах дүү нартайгаа сургуулиа тараад харих замдаа Голландын далбаа гэрийнх нь гадна намирч байхыг харсан нь хамгийн сайхан үйл явдал байв. Энэ нь нэг л зүйлийг хэлж байгааг тэд мэдэж байлаа!

“Аав гэртээ ирсэн байна” гэж Хибэр хашхирав.

Грэйс ах дүү нартайгаа хамт гэр рүүгээ гүйсээр орлоо. Тэр аавыгаа тэврэхэд аав нь түүнийг энгэртээ чанга гэгч нь тэврэв. Аав гэртээ байгаа нь сайхан байлаа.

Удалгүй хоол хүнс, хувцас хунар, эм тан агуулсан илгээмж Голландад бууж эхлэв. Солт Лэйк Сити дэх



Сүмийн удирдагчид дайны дараа хүмүүст туслахаар хүнс, барааг ханган нийлүүлж байлаа. Грэйс бүр шинэ даашинзтай болсон гээч! Тэр нэг даашинзаа 5 жил өмссөн тул шинэ даашинзтай болж байгаадаа баяртай байв.

Мөн олон жилийн дараа Грэйс цадталаа идэж байлаа. Голланд дахь номлолын ерөнхийлөгчийн зөвлөл болон засгийн газраас хоол хүнсийг нэмэгдүүлэх зорилгоор төмсний

төсөл хэрэгжүүлж эхлэв. Сүмийн гишүүд ойролцоох талбайд ихээхэн төмс тарив. Намар гэхэд тэд хэдэн мянган төмстэй болох байлаа.

Грэйс “Хар даа!” хэмээн соёолсон төмсийг заагаад, “Бид дахин хэзээ ч өлсөхгүй” гэж аавдаа хэлэв.

Аав нь толгой дохисон ч инээмсэглэсэнгүй. Тэр “Би ерөнхийлөгч Заппийтэй ярьсан. Тэр надад Германы хожмын үеийн гэгээнтнүүд бидний өлсөж байсантай адил өлсөж байгаа гэсэн. Тэд бидний авсан шиг тусламжийг засгийн газраасаа авахгүй байгаа” гэж хэлэв. Аав нь Грэйсийн мөрөн дээр гараа тавиад, “Ерөнхийлөгч Заппий биднээс төмсөө Германы гэгээнтнүүдэд өгөх эсэх талаар асуусан” гэв.

“Төмсөө өгнө гэж үү!” гэж Грэйс уйллаа. Гэхдээ *нацистууд* чинь Германых биз дээ! “Аав аа, тэд хожмын үеийн гэгээнтнүүд ч гэлээ германчууд шүү дээ” гэхэд

“Хэцүү байгааг чинь ойлгож байна. Гэхдээ тэд ч гэсэн Бурханы хүүхдүүд шүү дээ. Тэр тэднийг ч гэсэн хайрладаг. Намайг хоригдол болгосныг нь би уучилсан. Бурхан бидэнд бусдыг уучлахад тусална” гэж аав нь хэллээ.



Грэйс аав руугаа харав. Аав нь түүний мэдэх хамгийн зоригтой хүн байв. Харин түүнд аавынхаа адил бусдыг уучлах зүрх зориг байгаа эсэхэд тэр эргэлзэж байлаа. Харин дараа нь тэр дайны үед сургуульд байсан нэг багшаа санахад. Багш нь бүх герман хүн нацистууд биш, мөн бүх нацист цэрэг муу хүн биш гэж хэлсэн байлаа. Харин одоо Герман дахь охид, хөвгүүд яг Грэйсийн өлсөж байсны адил өлсөж байв.

Грэйс гүнзгий амьсгаа аван, “Би ойлгож байна. Төмсөө тэдэнд өгье дөө” гэлээ.

Аав нь түүнийг чанга гэгч тэврээд, инээмсэглэн, “Чи зоригтой охин байна. Ингэх нь амар биш л дээ. Гэхдээ бид ч мөн Герман дахь ах, эгч нар маань ч гэсэн Есүс Христийн шавь нар шүү дээ” гэв.

Грэйс инээмсэглэв. Дотор нь хурсан байсан уур

уцаар замхран алга болж, түүнд амар тайван, халуун дулаан мэдрэмж төрлөө. Тэр германчуудыг уучилж чадна. Есүс ч гэсэн түүнд уучлахад нь тусална. ■

Зохиогч нь АНУ-ын Нью-Жерсид амьдардаг.

Голландын хожмын үеийн гэгээнтнүүд Германы гэгээнтнүүдэд 140 мянган фунт (70 тонн) төмс, 180 мянган фунт (90 тонн) май загас өгсөн. Дараа нь буюу 1953 онд Германы гэгээнтнүүд хүчтэй үерийн дараа Голландын гэгээнтнүүдэд хоол хүнсний зүйлс илгээсэн юм.

Мормоны Номын уншлагын клуб

МОРМОНЫ НОМЫГ УНШИЖ, БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ!

Та ганцаараа, гэр бүлтэйгээ эсвэл найзтайгаа хамт уншиж болно. Тэгээд Мормоны Ном уншиж байгаа зургаа бидэнд илгээн, Мормоны Номоос өөрийн дуртай түүхийг юм уу сурсан зүйлийнхээ талаар бичээрэй. Та түүхээ бидэн рүү liahona.lds.org вэбсайтаар ("Submit an Article" дээр дарж) илгээнэ үү.



Энэ сарын судар: Моронай 10:4

“... Хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно.”



Миний Мормоны Номын дуртай түүх 3 Нифай 17 дээр байдаг бөгөөд энэ нь Есүс хүүхдүүдийг адисалж байгаа түүх юм. Энэ нь Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр хэрхэн биднийг хайрладаг болохыг өгүүлдэг учраас би энэ түүхэнд дуртай.

Би хүүхдүүдэд ямар байсныг ойлгож байгаа бөгөөд өөрийгөө тэнд зогсож байгаагаар төсөөлөн боддог.

Барбора Ж., 11 настай, Чех улс



Мормоны Ном үнэн учраас би энэ номонд дуртай. Үүнийг бошиглогчид бичсэн. Энэ нь надад зөвийг сонгоход болон асуудал тулгарах үед тусалдаг. Би үүнд итгэдэг.

Жэйсон С., 10 настай, Энэтхэг, Махараштра

Естер зоригтой нэгэн байв

Естер Персийн хатан хаан байсан. Хаан Естерийг иудей хүн байсныг мэдээгүй. Хааны найз иудейчүүдийг үзэн яддаг муу хүн байв. Тэрээр хааныг хууран мэхэлж, газар дээрх бүх иудей хүнийг алах ёстой хэмээн хэлүүлжээ. Харин Естер хаанаас хүмүүсийг нь авраач гэж гуйхаар шийдэв. Гэвч тэр хааны сэнтийд очсоноор амиа алдах байлаа. Естер иудейчүүдээс гурав хоног мацаг барихыг хүсэв. Естерийг сэнтийд нь дөхөж ирэхэд нөхөр нь баяртай хүлээн авав. Тэр хааныг найзтай нь хамт оройн зоогонд урилаа. Тэр тэнд өөрийгөө иудей хүн болохыг хэлэв. Хаан хуулиа өөрчлөх боломжгүй байсан ч иудейчүүдэд өөрсдийгөө хамгаалах боломж олгосон байна. Бурханы тусламжтайгаар Естер өөрийн хүмүүсийг аварсан юм!



“Хатан хаан Естер,” Рэбэкка К., 8 настай, Венесуэл, Арагуа

Естерийн тухай Естер 2–8-аас уншина уу.



ЕСТЕР

Естер зоригтой, Бурханд итгэдэг нэгэн байсан. Би ч гэсэн зоригтой байж, зөв зүйлийн талд зогсож чадна!

- ☐ Естер 4:14-ийн сүүлийн хэсгийг цээжилнэ үү.
- ☐ Хуучин Гэрээний 45-р хэсгийг scripturestories.lds.org-ooc үзнэ үү.
- ☐ Хэрэв эцэг эх чинь чамайг том болсон гэж үзвэл санаа зовж явдаг нэг хүнийхээ төлөө мацаг барь.
- ☐ Би ...-ээр зоригтой байж чадна

Хатан хаан Естер

Ким Вэбб Рэйд



Естер нь хатан хаан байв. Тэр Персийн хаантай гэрлэсэн байжээ.




Хааны найз муу хүн байв. Тэрээр хааныг хууран, бүх иудейчүүдийг алах хууль гаргуулжээ. Хаан эхнэр Естерийгээ иудей хүн байсныг мэдээгүй.

Харин Естер өөрийн нөхөр болох хаанаас хүмүүсийг нь авраач гэж гуйхаар шийдэв. Гэвч тэр хааныг уурлуулахаас эмээж байлаа. Естер иудейчүүдээс гурав хоног мацаг барьж, өөрийнх нь төлөө залбирахыг хүсэв. Дараа нь Естер хаан дээр очжээ. Тэр харин уурласангүй!




Естер хааныг найзтай нь хамт оройн зоогонд хүрэлцэн ирэхийг хүсэв. Оройн зоогийн үеэр Естер хаанд *өөрийгөө* иудей хүн гэдгийг хэлжээ. Найз нь өөрийг нь хууран мэхэлсэнд хаан уурлав. Тэрээр иудейчүүдийг өөрсдийгөө хамгаалж чадна гэж хэлэв. Естер өөрийн хүмүүсийг аврахад тусаллаа!



Бид Тэнгэрлэг Эцэгээс тусламж гүйн залбирч болно.
Бид мөн Естериин адил хатан зоригтой байж чадна. ■

Естер 2–8-р бүлгээс авав.

Би бусдад хайрыг мэдрэхэд нь тусалж чадна





Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх
Ерөнхийлөгч
Жэймс Э.Фауст
(1920–2007)

БИДНИЙ ТУУШТАЙ ДЭМЖЛЭГ

*Сүнсний удирдамж нь . . . бошиглогч,
үзмэрч, илчлэгчидтэй хэрхэн нийцэж
байгаагаас ихээхэн шалтгаалдаг.*

Би “дуудагдсан мөн сонгогдсон”
(С ба Г 55:1) санваарын удир-
дагчдын тухай, өнөө үед Сүмийг
удирдан хөтлөх ариун үүрэгт ажлын
талаар ярихыг хүсэж байна. . . .

. . . [Арван хоёр Төлөөлөгчийн
Чуулгын] Ах нар маань бүгд сайн,
ариун шударга, итгэл даасан хүмүүс
юм. Би тэдний зүрх сэтгэлийг мэд-
нэ. Тэд бол Их Эзэний үйлчлэгчид.
Тэдний цорын ганц хүсэл бол өөрс-
дийн агуу дуудлагуудаа хөдөлмөр-
лөж, дэлхий дээрх Бурханы хаант
улсыг байгуулах явдал юм. Энэ цаг
үед үйлчилж байгаа Ах нар маань
өөрсдийгөө хэн болохыг баталж,
сорилт бэрхшээлийг давсан, итгэл-
тэй хүмүүс. . . . Тэдний зүрх сэтгэл
цагаахан, хуримтлуулсан туршлага
нь арвин, оюун билиг нь хурц,
сүнслэг мэргэн ухаан нь гүнзгий тул
дэргэд нь байхад л амар амгалан
мэдрэгддэг.

. . . [Намайг дуудагдахад зөв-
лөсөн] хамгийн чухал зүйл бол



Ах нартай үргэлж нийцтэй бай-
хыг хичээх хэрэгтэй гэсэн явдал
юм. . . . Энэ нь зүрх сэтгэлийнхээ
угаас хийхийг хүссэн тэр зүйл
минь байсан.

. . . Миний дүгнэснээр сүнслэг
удирдамжийн ихээхэн хэсэг нь бүгд
. . . бошиглогч, үзмэрч мөн илчлэгч
байхаар дэмжигдсэн Сүмийн ерөн-
хийлөгч, Тэргүүн Зөвлөл, Арван
хоёрын чуулгатай хэрхэн нийцтэй
байхаас ихээхэн шалтгаална. Хэрэв
бид Сүмийн ерөнхийлөгч болон
бусад бошиглогч, үзмэрч, илчлэгч-
тэй нийцтэй бүс байвал хэрхэн Их
Эзэний Сүнстэй бүрэн нийцнэ гэж
бодож зүрхлэх билээ? . . .

Би Сүмийн ерөнхийлөгч, Тэргүүн
Зөвлөл, Арван хоёрын чуулга болон
бусад ерөнхий эрх мэдэлтэнг бүх
зүрх сэтгэлээрээ дэмждэг байхыг
Сүмийн гишүүдэд зөвлөж байна.
Хэрэв бид ийнхүү дэмжвэл хамгаа-
лагдах болно. . . .

Мөн бид орон нутгийнхаа удир-
дагчдыг дэмжих хэрэгтэй. Учир нь
тэд ч гэсэн “дуудагдсан мөн сонгогд-
сон” билээ. Энэ Сүмийн гишүүн бүр
бишоп эсвэл салбар, гадас, номло-
лын болон Сүмийн ерөнхийлөгчөө-
сөө, түүнчлэн түүний хамтрагчдаас
зөвлөгөө авах боломжтой. Эдгээр
ахын хэн нь ч дуудлагаа өгөөч гэж
хүсээгүй. Тэдний хэн нь ч төгс биш.
Хэдий тийм ч тэд Бурханы үйлчлэг-
чид бөгөөд Тэрээр тэднийг илчлэлт
хүлээн авах эрхтэй хүмүүсээр дам-
жуулан дуудсан. Дуудагдан, дэм-
жигдэж, онцгойлон адислагдсан тэд
бидний дэмжлэгийг авах эрхтэй. ■

*2005 оны 10-р сарын Ерөнхий чуулган
дээр хэлсэн үгнээс.*



ЭДМАНД БЛЭЙР ЛЭЙТОН (1852-1922), СИЛОАМЫН ЦӨӨРМИЙН ДЭРГЭД БАЙХ СОХОР ЭР, 1879 ОН, ЗОТОН ДАВХУН ДЭЭР ТОСОН БУЛГААР ЗҮРСАН ЗУРАГ, 40 X 50 1/4 ИНЧ (101.6 X 127.63 CM), БРИТАМ ЯНГИЙН ИХ СРҮНҮҮЛГИЙН УРЛАГИЙН МҮЗЕЙ 2014 ОНД ЖАК Р.ВИЙТИГИЙН ХАНДИВЛАСАН МӨНӨӨР ХУДАЛДАН АВСАН.

**СИЛОАМЫН ЦӨӨРМИЙН
ДЭРГЭД БАЙХ СОХОР ЭР,
ЭДМАНД БЛЭЙР ЛЭЙТОН**

“Тэр—Есүс гэдэг хүн шавар зуурч, нүдийг минь шаваад, надад “Силоам уруу яваад, угаа” гэж айлдсан. Тэгээд би явж, угаагаад хараатай болсон гэж хариулав. . . .

Хэрэв энэ хүн Бурханаас ирээгүй юм бол, Тэр юу ч хийж чадахгүй байсан” (Иохан 9:11, 33).

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

**“ЯАГААД”
ГЭСЭН АСУУЛТАНДАА
ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ**

*Сургаалын дагуу амьдрахад тань
урам зориг өгдөг зүйл юу вэ?*

44

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД
ЗОРИУЛАВ

**АРИУН СҮНС ТАНД
ХЭРХЭН ЗААЖ
ЧАДАХ ВЭ?**

50, 56

**ХҮСЭЖ БҮЙ
ИРЭЭДҮЙНХЭЭ
ТӨЛӨӨ ОДООНООС
ЭХЛЭН АЖИЛЛА**

62

ЕРӨНХИЙ ЧУУЛГАН

**ЕРӨНХИЙ
ЧУУЛГАНААС
СУРАЛЦАХ 5
АРГА ЗАМ**

50, 54,
58



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

